



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.05.27 № 35-1/68

танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Арилжааны хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.05.23 № ХЭГ/1492
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай**

Арилжааны хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 778 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255000491

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“25.ХЭЛЭЛЦСЭН нь: Арилжааны хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Арилжааны хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,

Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2025.05.21 № 01/4593

танай _____-ны № _____-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД О.АЛТАНГЭРЭЛ ТАНАА**

Арилжааны хуулийн төсөл, түүнтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761000361

151601641



МОНГОЛЫН ЭСЭГ
 СЭХЭГ
 У. Аюулбаяр



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.05.21 № 1/2758

танай _____-ны № _____-г

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА**

Арилжааны хуулийн төсөл, түүнтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151601625

АБ.Файл: 2025

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**



О.АЛТАНГЭРЭЛ

АРИЛЖААНЫ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Иргэний хуулийн¹ үндсэн зарчим нь эрх тэгш байх, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх, үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, шүүхээр хамгаалуулах байдаг бол арилжааны эрх зүйн үндсэн зарчим нь харилцаанд оролцогч талуудын ашгийн төлөөх зорилгыг хамгаалах, гэрээний эрх чөлөө, гэрээнд итгэх итгэлийг хамгаалах, хуулиас гадна арилжааны тогтсон зан заншлыг хэрэглэх, хэлцэл хийхэд түргэн шуурхай, хялбар, зардал багатай байх, хэлцлийн хэлбэрийг тохирох, хэлцлийн найдвартай байдлыг хангах, гадаад илэрхийлэлд итгэх буюу хэлцэлд итгэх итгэлийг хамгаалах, хариуцлагатай байх зарчмуудыг гол болгодог.

Монгол Улсад худалдаа, арилжаатай холбоотой харилцааг Иргэний хууль² болон тусгайлсан хууль /Компанийн тухай,³ Нөхөрлөлийн тухай,⁴ Өрсөлдөөний тухай,⁵ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай,⁶ Даатгалын тухай,⁷ Банкны тухай,⁸ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл үйл ажиллагааны тухай,⁹ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай,¹⁰ Санхүүгийн түрээсийн тухай хууль¹¹ гэх зэрэг/-аар зохицуулж ирсэн боловч арилжаа эрхлэгч хоорондын харилцаа, түүн дотор ашгийн төлөө зорилго бүхий арилжаа эрхлэгчдийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой харилцааг цогц байдлаар буюу бусад субъект хоорондын харилцаанаас ялгамжтай зохицуулсан эрх зүйн тогтолцоо байхгүй байна.

Иргэний хуульд “аж ахуйн үйл ажиллагаа” гэх нэр томъёо 8 удаа, “аж ахуйн зориулалт” гэх нэр томъёо 15 удаа удаа, “аж ахуйн” гэх нэр томъёо 33 удаа давтагдсанаас үзэхэд хуулийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагааны онцлогт нийцсэн зарим хэм хэмжээг бий болгосон байх бөгөөд хувийн эрх зүйн ердийн харилцааг зохицуулах нийтлэг зохицуулалт болон аж ахуйн харилцааг зохицуулах тусгай зохицуулалт Иргэний хуульд зэрэгцэн оршиж байгааг илтгэнэ.

¹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2002), №07

² Төрийн мэдээдэл эмхэтгэл (2002), №07

³ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2011), №42

⁴ Төрийн мэдээдэл эмхэтгэл (1995), №08-09

⁵ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2010), №28

⁶ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2004), №03

⁷ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2004), №20

⁸ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2010), №07

⁹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2021), №27

¹⁰ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2002), №48

¹¹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2006), №46

Өөрөөр хэлбэл Иргэний хуульд аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч хоорондын /Business-to-Customer/, эсхүл иргэд хоорондын /Customer-to-Customer/ харилцааг илүүтэйгээр зохицуулсан боловч аж ахуй эрхлэгчдийн хооронд /Business-to-Business/ үүсэх бизнесийн онцлог харилцааг зохицуулсан цөөн хэдэн хэм хэмжээг агуулсан бөгөөд иргэд хоорондын болон аж ахуй эрхлэгчтэй холбоотой харилцааг ялгамжтай зохицуулаагүйгээс арилжааны дээрх суурь зарчмууд хангагдахгүй орхигдож, арилжаа эрхлэгчдийн хооронд маргаан үүсэх, аж ахуйн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Арилжааны харилцаа нь иргэний эрх зүйн нийтлэг зохицуулалттай харьцуулахад уян хатан, түргэн шуурхай, эрх зүйн тогтвортой байдлаас ихээхэн хамаардаг тул арилжаа эрхлэгчдийн бизнесийн эрх зүйн харилцааг хөнгөвчлөх, хялбаршуулах шаардлагатай юм.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны эхний 06 сарын байдлаар 305 хувьцаат компани, 196,652 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 3101 зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 1976 бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 411 хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл буюу нийт 202445 ашгийн төлөө хуулийн этгээд бүртгэлтэй байх¹² боловч эдгээрээс 2022 оны байдлаар найман улирал дараалан санхүүгийн тайлангаа хүргүүлээгүйгээс улсын бүртгэлээс хасагдах болзлыг хангасан хувьцаат компани 5, хязгаарлагдмал хариуцлагатай компани 25621, нөхөрлөл 899 байна.

Мөн нийслэлийн хэмжээнд 2023 оны 03 дугаар сарын байдлаар худалдаа эрхэлж байгаа газар 8081, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа газар 3593, ахуйн үйлчилгээний газар 2788, авто үйлчилгээний газар 1316, зочлох үйлчилгээний газар 683, тоглоомын төв 73, чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ 220, соёл урлагийн үйлчилгээ 23 буюу нийт 16,777 худалдаа, үйлчилгээний газар Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд эдгээр газруудад нийт 100,506 хүн ажилладаг гэсэн тоон мэдээлэл байна.¹³

Иймд эдгээр 190 мянга гаруй хуулийн этгээд болон хувиараа бизнес эрхлэгчдийн ашгийн төлөөх зорилгыг дэмжих, бизнесийн харилцааны түргэн шуурхай байдлыг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх, зорилгоор иргэний эрх зүй болон арилжааны эрх зүйн ялгаа заагийг гаргах, хоршоог арилжаа эрхлэгчид тооцох, арилжааны эрх зүйн онцлог, нарийвчилсан бусад зохицуулалтуудыг бий болгох хэрэгцээ, шаардлага нэгэнт үүсжээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹⁴ 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайланд¹⁵ үндэслэн Арилжааны хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагыг тодорхойлж байна. **Үүнд:**

1.1.Хууль зүйн үндэслэл:

¹² Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн тоон мэдээ. 2023 он

¹³ Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас ирүүлсэн тоон мэдээ. 2023 он

¹⁴ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2015), №25

¹⁵ Арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. 2019 он

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”¹⁶-ийн 3.2.2.9-д “Арилжааны хуулийг батлуулж, бизнес эрхлэгчдийн ашгийн төлөөх зорилгыг дэмжих, бизнесийн харилцааны шуурхай байдлыг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж заасан.

Түүнчлэн “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”¹⁷-ийн 40-д “бизнес эрхлэгч хоорондын харилцаанд баримтлах онцлог зарчмыг тусгах, тэдгээрийн байгуулах гэрээ, хэлцлийг Иргэний хуулиас ялгаатай зохицуулах, түүнчлэн цахим хэлбэрээр гэрээ, хэлцэл хийх, арилжааны нэр ашиглах зохицуулалтыг боловсронгуй болгох, гэрээний талуудын итгэлцлийг нэмэгдүүлэх зорилгоор арилжаа эрхлэгчийн зарим мэдээллийг нээлттэй болгох, түүнчлэн бизнес эрхлэгчдийн ашгийн төлөөх зорилгыг дэмжих, бизнесийн харилцааны шуурхай байдлыг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий Арилжааны хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

1.2.Практик шаардлага

1/Арилжааны харилцаанд тогтсон зан заншлыг хэрэглэх асуудлын хүрээнд: Иргэний хуулийн 4 дүгээр зүйлд Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэх талаар зохицуулсан бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд орсон талуудын хооронд үүссэн асуудлыг зохицуулах хэм хэмжээ байхгүй бол иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна гэж заасан. Харин цөөн хэдэн тохиолдолд буюу гэрээ байгуулсанд тооцох, гэрээ тайлбарлах, хэлцлийн хэлбэрт тавигдах шаардлага зэрэгт ажил үүргийн хүрээнд тогтсон заншлыг харгалзаж болохоор зааснаас¹⁸ бусад тохиолдолд ажил үүргийн хүрээнд тогтсон заншил, талуудын хооронд тогтсон практикыг эрх зүйн эх сурвалжийн хувьд хүлээн зөвшөөрөөгүй тул талуудын хооронд асуудлыг шийдвэрлэх боломжгүй болж байна.

Монголын бизнесийн орчинд арилжаа эрхлэгчдийн дунд тодорхой хэмжээгээр арилжааны заншил, тогтсон практик мөрдөгдөж байгаа бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш байж болох арилжааны заншил ч тогтсон практик байна.¹⁹

Түүнчлэн шүүх, арбитр арилжааны заншил, тогтсон практикыг хэрэглэж хэрэг маргааныг шийдсэн тохиолдол төдийлөн түгээмэл биш, тэдгээрийн хэрэглээг практикт дэлгэрүүлээгүй гэсэн дүгнэлт гарсан байна.²⁰ Тухайлбал, 2011 оноос 2021 оны хооронд ердөө 7 хэрэгт арилжааны заншил, тогтсон практикыг хэрэглэсэн.

Онцолбол, 2013 оны сүүлчээс 2020 оны хооронд гаргасан иргэний хэргийн 223826 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд “заншлын хэм хэмжээ”,

¹⁶ Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан.

¹⁷ Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан.

¹⁸ Арилжааны заншил, тогтсон практикийн судалгаа. Эрх зүйн боловсрол академи. 2020 он

¹⁹ мөн тэнд.

²⁰ мөн тэнд.

“талуудын хооронд тогтсон практик”-ыг шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ авч үзэж, шийдвэртээ дурдсан тохиолдол ердөө 15 удаа байсан байна.²¹

Эдгээр 15 шийдвэрийг судлахад ихэнх тохиолдолд маргааны талууд байгуулсан гэрээнээсээ гадна талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэхийг шүүхээс хүссэн боловч шүүх шийдвэрээ гаргахдаа тус үндэслэлийг нь харгалзан үзээгүй, эсхүл ямар үйлдлийг нь, ямар шалтгаанаар “талуудын хооронд тогтсон практик”, “ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” гэж тооцсон талаар тайлбарлахгүйгээр хэргийг шийдвэрлэсэн байдал нийтлэг байжээ.²²

Бизнесийн харилцаа байнгын хөдөлгөөнтэй, хувьсан өөрчлөгдөж байдаг динамик шинжтэй харилцаа. Тиймээс шинээр үүссэн бизнесийн харилцаанд үйлчлэх хуулийн зохицуулалт байхгүй бол арилжааны заншлыг эрх зүйн эх сурвалжийн хэмжээнд ашиглаж болохоор, хэрэв тухайн заншил нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харш бол тухайн заншлыг хязгаарлаж, зохих эрх зүйн хэм хэмжээг бий болгох байдлаар хувийн эрх зүйг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлж, бизнесийн харилцааны хурдан шуурхай байдлыг дэмжих шаардлагатай байна.

2/Аж ахуй эрхлэгчийн бүртгэлийн талаар: Манай орны хувьд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй бөгөөд зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн хэлбэрийг бүртгэснээр хязгаарлагдаж байна.²³ Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөлийн хэлбэрээр бизнесийн буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэдэг байна.

Тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бүрдэнэ” гэж заасан бөгөөд хуулийн этгээдийн бүртгэл нь зөвхөн хуулийн этгээд хэлбэрээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой бүртгэл хийдэг. Харин эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл нь иргэн, хуулийн этгээдийн хуулиар бүртгүүлэх шаардлага тавигдсан эд хөрөнгийг бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулдаг бүртгэл байна.²⁴

Хувиараа аж ахуй эрхлэгчтэй холбоотой бүртгэл Татварын ерөнхий хууль²⁵ болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд²⁶ заасны дагуу бүртгэгдэх ёстой боловч хуулийн этгээдийн бүртгэлтэй нэгэн адил заавал бүртгүүлэх эрх зүйн механизм байхгүй. Түүнчлэн татварын бүртгэл нь аж ахуй эрхлэгчид татвар ногдуулах зорилго бүхий бүртгэл тул аж ахуй эрхлэгчийн мэдээллийг нийтэд ил болгохгүй бөгөөд аж ахуй эрхлэгчдийн хэлцлийн баталтгаат, найдвартай байдалд нөлөө үзүүлэхгүй.

Мөн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн²⁷ 6 дугаар зүйлд жижиг, дунд хэмжээний аж ахуй эрхлэгчдийг бүртгэх зохицуулалт тусгагдсан ч сайн

²¹ мөн тэнд.

²² мөн тэнд.

²³ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2018), №30

²⁴ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2018), №29

²⁵ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2019), №22

²⁶ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2019), №23

²⁷ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2019), №29

дурын бүртгэл бөгөөд заавал бүртгэх тогтолцоо биш бөгөөд үүнд хувиараа аж ахуй эрхлэгч болон хуулийн этгээдийн хэлбэрээр аж ахуй эрхлэгч аль аль нь бүртгүүлэх боломжтой боловч арилжаа эрхлэгчийн нэгдсэн бүртгэлийн тогтолцоо гэж үзэхгүй.

Аж ахуй эрхлэгчийн бүртгэлийн тогтолцооны гол зорилго нь аж ахуй эрхлэгчийн мэдээллийг нээлттэй болгох замаар хэлцэлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хэлцлийг түргэн, шуурхай, баталгаатай явагдах боломжийг олгох боловч манай улсад ийм тогтолцоо байхгүйгээс аж ахуй эрхлэгчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн зохицуулалт мөн хэрэгжих боломжгүй. Тухайлбал, төлөөллийн харилцаанд зөвхөн Иргэний хуулийн төлөөллийн зохицуулалт үйлчилж байгаа нь төлөөлөх эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл, төлөөллийн гаднах байдалд итгэсэн хэлцлийн нөгөө талын итгэлийг хамгаалах зохицуулалт үгүй, итгэлийг хамгаалах үндсэн зарчим хэрэгжих боломжгүй, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

3/Арилжааны нэрийн талаар: Арилжааны нэр нь эдийн засгийн үр өгөөж бий болгох утгаараа эд хөрөнгөд тооцогдож түүнийг өвлүүлэх, бэлэглэх, шилжүүлэх, гадны халдлагаас хамгаалах зэрэг эрх зүйн хамгаалалт шаардлагатай болдог. Түүнчлэн бизнесийн хамтрагч болох нөгөө талын хувьд арилжааны нэрэнд төөрөгдөхгүй, түүнээс ямар нэгэн хохирол хүлээхгүй байх зэрэг шаардлагын үүднээс эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах хэрэгцээ бий болгохоос гадна аж ахуй эрхлэгчийг нэрлэх, танин мэдэх, бараа бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, мэдээллийг түгээх, ялгаатай байдлыг бий болгох, хариуцлага хүлээх эрх зүйн үр дагаврыг үүсгэх зорилготой.

Харин манай улсын хувьд арилжааны нэр гэх ойлголтыг зохицуулаагүй бөгөөд Иргэний хууль дахь хуулийн этгээдийн оноосон нэр, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн²⁸ барааны тэмдгийн алинд нь хамаарах эсэх нь тодорхойгүй.

Тухайлбал Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “барааны тэмдэг гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн өөрийн үзүүлж буй бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг” ойлгохоор зааснаас үзэхэд барааны тэмдэг гэдэгт арилжааны нэр хамаарахааргүй бөгөөд Иргэний хууль дахь хуулийн этгээдийн оноосон нэртэй илүү төсөөтэй ойлголт юм.

Харин хуулийн этгээдийн оноосон нэр нь өөрөө бие даасан барааны тэмдэг хамаарах эсэх нь тодорхойгүй, улмаар хуулийн этгээдийн оноосон нэр олгох, барааны тэмдгээр бүртгэж, гэрчилгээжүүлэх чиг үүргийг тус тусын төрийн байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд эрх зүйн ялгамжтай зохицуулалтгүйгээс хуулийн этгээдийн ижил төстэй нэр олгох, бусад этгээд тухайн нэрийг өөрт ашигтайгаар ашиглах замаар бусдыг төөрөгдүүлэн ашиг олох үйлдлүүд гарч байгааг шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг маргаанаас тодорхой харж болно.²⁹

Мөн хуулийн этгээдийн оноосон нэр нь арилжааны нэрийн хувьд барааны тэмдэгээр хамгаалагдах эрхийн объектэд хамаарснаар аж ахуй эрхлэгч өөрийн бизнесийн нэрээ зөвхөн дотоодод төдийгүй олон улсад хамгаалуулах, тухайн нэрийг бусдад гэрээний үндсэн дээр шилжүүлэх, ашиглуулах замаар ашиг олох боломжийг

²⁸ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2010), №26

²⁹ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 221/МА2022/0792 дугаар магадлал. https://shuukh.mn/single_case/5453?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1

олгодог³⁰ ч манай улсын эрх зүйн зохицуулалтын хувьд арилжааны нэрийг зохицуулаагүй орхигдуулсан байдаг.

Түүнчлэн хувиараа аж ахуй эрхлэгч нь аж ахуйн үйл ажиллагаандаа арилжааны нэр ашиглах боломжтой бөгөөд хуулийн этгээдийн нэгэн адил арилжааны нэрээр дамжуулан бараа, бүтээгдэхүүний мэдээллийг түгээх, сурталчлах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар ашиг хүртэх боломжтой байдаг бол манай улсын хувьд зөвхөн хуулийн этгээдийн хувьд хуулийн этгээдийн оноосон нэрийг авч ашиглах эрхтэй бөгөөд хувиараа аж ахуй эрхлэгчийн хувьд арилжааны нэртэй байх, түүнийг ашиглах эрх зүйн зохицуулалт байхгүй.

4/Хөөн хэлэлцэх хугацааны талаар: Иргэний хуулийн 74-82 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаа нь үүргийн эрх зүйд бүхэлд нь адил үйлчлэх зохицуулалт бөгөөд иргэд хоорондын хэлцлийн харилцаа болон арилжаа эрхлэгч хоорондын хэлцлийн харилцаанд адил үйлчилдэг.

Хэдийгээр Татварын ерөнхий хуульд заасан татвар ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа зэрэг бусад хуульд хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай байдлаар тусгасан зохицуулалт бий боловч гэрээний үүрэгтэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаанд хамаардаггүйн улмаас арилжаа эрхлэгчдийн хоорондын гэрээ, хэлцэл хийгдсэнээс хойш удаан хугацаа өнгөрсний дараа маргаан үүсэх, хэлцлийн баталгаат байдлыг алдагдуулах зэрэг сөрөг үр дагаварыг үүсгэж байна.³¹

5/Төлөөлөх бүрэн эрхийн талаар: Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид аж ахуйн үйл ажиллагааны талаар шүүхийн болон шүүхийн бус аливаа үйлдэл хэрэгжүүлэх бүрэн эрх олгогдсон этгээд болон аж ахуй эрхлэгч хоорондын хэлцэлд төлөөлөх бүрэн эрхийн талаар нарийвчлан зохицуулсан хэм хэмжээ байхгүй.

Иргэний хуулийн 62-70 дугаар зүйлд заасан хэм хэмжээний дагуу энэхүү харилцааг зохицуулдаг боловч, эдгээр зохицуулалт нь иргэд хоорондын төлөөллийн харилцаанд хэрэглэгдэх бөгөөд энэ нь аж ахуйн үйл ажиллагааны ашгийн төлөөх шинж, хэлцэл хурдан, шуурхай байх, гэрээний зардал аль болох бага байх, хэлцлийн баталгаат байдлыг хангах зэрэг зарчимд сууриллаагүй хэм хэмжээ болно.

Хуулийн этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй удирдах байгуулагаас гадна, шүүхийн болон шүүхийн бус аливаа үйл ажиллагаа, хэлцэлд төлөөлөх ерөнхийлсөн бүрэн эрх олгогдсон этгээдийн талаар, түүний төлөөлөх бүрэн эрхийн талаар зохицуулсан хэм хэмжээ одоогоор хуульчлагдаагүй байна.

Тухайлбал, компанийн хувьд үйл ажиллагаа хариуцсан захирал, хүний нөөц хариуцсан захирал, хууль, эрх зүйн газрын захирал, борлуулалтын албаны дарга гэх мэт албан тушаал бий. Эдгээр албан тушаалын хувьд тухайн компанитай гэрээ байгуулах замаар компанийн тухайн нэг үйл ажиллагааны талаарх шүүхийн болон шүүхийн бус аливаа төлөөлөх бүрэн эрхийг эдэлж болох юм. Гэвч бодит байдал дээр гүйцэтгэх захирлын бүрэн эрхэд эдгээр хоорондоо ялгаа бүхий харилцаанд төлөөлөх

³⁰ Гадаад орнуудын арижаа/худалдаа/-ны тухай хуулиудын харьцуулсан судалгаа. Судлаач Н.Норовсамбуу, Г.Давааням, Ж.Содномдаржаа. 2019 он.

³¹ Арилжаа/худалдаа/-ны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны тайлан. Судлаач Б.Амарсанаа нар. 2019 он.

бүрэн эрхийг бүхэлд нь олгосон мэтээр хандаж, аж ахуйн үйл ажиллагааг явуулахад хүндрэлтэй нөхцөлийг үүсгэсээр байна.³²

6/Аж ахуйн шинжтэй хэлцлийн талаар: Иргэний хуулийн зохицуулалт нь нэг удаагийн шинжтэй харилцааг зохицуулахад чиглэгдсэн тул байнгын аж ахуйн харилцаатай байдаг этгээдүүдийн хоорондын харилцааг зохицуулахад хангалтгүй байна. Хэлцэл хийж буй аж ахуйн эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах, хурдан шуурхай хугацаанд эрх зүйн харилцаа тодорхой болох зохицуулалт хангалттай системчлэгдээгүй, аж ахуйн шинжтэй хэлцлийг зохицуулах зарим зохицуулалт байхгүй, зохицуулалтын хувьд хангалтгүй байна.

Түүнчлэн арилжааны эрх зүйн хувьд ерөнхий ангийн шинжтэй зохицуулалтууд болох худалдааны зуучлагч, худалдааны төлөөлөгчийн талаарх зохицуулалт нь иргэний эрх зүйн хувьд тусгай ангид хамаарах зохицуулалтад тооцогдож байна.³³

Мөн аж ахуйн шинжтэй хэлцлийг байгуулах этгээд буюу аж ахуй эрхлэгчийг бүрэн тодорхойлоогүйн улмаас иргэд хоорондын хэлцлийн хувьд аж ахуйн эрхлэгчид хамаарах ёстой зохицуулалтыг хэрэглэх сөрөг үр дагаварыг үүсгэж байна. Хэдийгээр манай улсын Иргэний хуульд арилжааны эрх зүйн шинж бүхий л зохицуулалтыг тусгасан хэдий ч тухайн зохицуулалтууд нь тодорхой бус, ерөнхий зохицуулалтын шинжтэйгээс шүүх хуулийг хэрэглэхдээ иргэн болон аж ахуй эрхлэгчийн харилцааг ялгамжгүй шийдвэрлэж буй тохиолдол цөөнгүй байна.

7/Аж ахуй эрхлэгчийн ашгийн төлөөх шинжийн талаар: Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5-д “Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй” гэж заасан байдаг. Шүүхийн практикт “тохирсон хүү” гэх ойлголтыг хэрхэн ойлгох талаар талууд гэрээгээр тохиролцсон хүүг “тохирсон хүү” гэж үзэх үү, эсхүл гэрээгээр тохиролцсон эсэхээс үл хамаарах хуульд заасан хүү гэж үзэх үү гэх асуудал болон “тохирсон хүү” гэдэгт хэр хэмжээний хүүг ойлгох вэ гэсэн асуудал маргаан дагуулсаар байна.

Шүүхийн практикт уг заалтыг хуульд заасан хүү шаардах эрх олгосон заалт гэж тайлбарлах байдал ажиглагдаж байгаагаас³⁴ үзэхэд арилжаа эрхлэгч хуульд зааснаар хүү шаардах эрхийг автоматаар олж авах эрхтэй байхаар хуульчлах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Хуульд “тохирсон хүү” гэх ерөнхий нэр томъёо хэрэглэсэн нь хуулийн зохицуулалтыг уян хатан байдлаар хэрэглэх боломжийг нээж өгсөн, шүүхээс тухай бүр зохистой шийдвэр гаргахад ач холбогдол бүхий заалт боловч арилжаа эрхлэгчийн хувьд уг тодорхойгүй зохицуулалтын үйлчлэлд хамаарах нь зохисгүй бөгөөд орлого, зарлага болон хэдий хэмжээний өр төлбөр үүсгэснээ тооцох зэрэг санхүүгийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлдөг байна.

Түүнчлэн, арилжаа эрхлэгч бусдын өмнөөс аливаа үйл ажиллагаа явуулсан, хэлцэл хийсэн бол гэрээндээ хөлс авахаар тодорхой тохиролцоогүй байсан ч түүний

³² мөн тэнд.

³³ Иргэний хуулийн гучин есдүгээр бүлэг, 413-419 дүгээр зүйл.

³⁴ Арилжаа/худалдаа/-ны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан судалгааны тайлан. Судлаач Б.Амарсанаа нар. 2019 он.

ашгийн төлөөх зорилгыг хангах зарчимтай боловч Иргэний хуулийн үүргийн эрх зүйн ерөнхий ангийн зохицуулалтад энэ талаар тодорхой зохицуулалтгүй бөгөөд зөвхөн гэрээний тусгай төрөл тэр дундаа бусдад ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон гэрээнд хөлс шаардах эрхийг зохицуулсан байдаг.³⁵

Тус зохицуулалт нь аж ахуй эрхлэгчийн зарим үйл ажиллагаанд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэж хөлсөө шаардах эрхтэй байх, зарим үйл ажиллагаанд хөлсийг харилцан тохиролцсон гэж үзэхгүй байх харилцан ялгамжтай үр дагаварыг үүсгэж байна.

Нөгөөтэйгүүр арилжааны үйл ажиллагааг Иргэний хуульд заасан цөөн тооны нэрлэгдсэн гэрээгээр хязгаарлаж болохгүй тул нэрлэгдээгүй гэрээ байгаа тохиолдолд одоогийн Иргэний хуулийн зохицуулалтын хүрээнд арилжаа эрхлэгч нь бусдын өмнөөс хэлцэл хийсэн, үйл ажиллагаа явуулсан тохиолдолд гэрээгээр тусгайлан тохиролцоогүй бол гүйцэтгэсэн ажлынхаа хөлсийг шаардах эрхгүй байдлаар хуульчилсныг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

8/Гэрээ байгуулах зардалын талаар: Иргэний эрх зүй дэх гэрээтэй холбоотой зардлыг гэрээ байгуулах зардал болон үүрэг гүйцэтгэх зардал гэж хуваан авч үздэг бөгөөд гэрээ байгуулах болон гэрээний үүргийн гүйцэтгэлд гарах зардлыг хэн хариуцах нь чухал ач холбогдолтой. Харин Иргэний хуульд гэрээ байгуулах зардлын талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй тул гэрээ байгуулах зардлыг гэрээний талуудын аль тал хэрхэн хариуцах талаар практикт маргаан дагуулсаар ирснийг Зээлийн гэрээний шимтгэлийн асуудлаас тодорхой харж болохоор байна.

9/Хэлцлийг баталгаажуулах талаар: Хамтран үүрэг гүйцэтгэх зарчмыг бизнесийн харилцаанд үндсэн зарчим болгож хэрэглэх шалтгаан нь худалдааны хэлцлээс үүсэх үүргийг илүү баталгаажуулах бөгөөд хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэн нэг нь үүрэг гүйцэтгэх чадамжгүй болсон ч бусад үүрэг гүйцэтгэгчид үүргийг бүхэлд нь гүйцэтгэх үүрэг хүлээдэгт оршдог тул энэхүү зарчмыг хуульчлах шаардлага үүссэн.

Иргэний хуулийн 215 дугаар зүйлийн 215.1-д “Үүрэг гүйцэтгүүлэгч хүлээсэн үүргээ биелүүлж үүрэг гүйцэтгэх боломж бүрдүүлэх хүртэл үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн төлбөрийнхөөс бусад үүргийн гүйцэтгэлийг саатуулж болно” гэж заасан.

Энэхүү зохицуулалтаар үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардах эрхийн эсрэг үүрэг гүйцэтгэгч мөн шаардах эрх хэрэгжүүлэх боломжтой бол энэ үүргийг биелүүлэх хүртэл хариу үүргээс татгалзах эрхтэй байх ба үүрэг гүйцэтгэгчийн саатуулан барих эрхийг зохицуулдаг. Энэ саатуулах эрхийн хувьд харилцан шаардах эрхүүд холбоотой байх буюу нэг ижил эрх зүйн харилцаанаас үүдэлтэй байх урьдчилсан нөхцөл тавигддаг.

Иргэний хуулийн дагуу саатуулан барих эрх үүсэхийн тулд барьцаагаар хангагдах шаардах эрх болон барьцааны зүйл нь хооронд холбоотой байх шаардлагатай буюу барьцааны зүйлтэй холбогдож үүссэн шаардах эрх байх хэрэгтэй.

Энэ нь бизнесийн харилцаанд тохиромжгүй бөгөөд харин бизнес эрхлэгчдийн хооронд тогтмол хийгдэж буй арилжаанаас үүссэн шаардах эрхийг хангуулахын тулд тухайн арилжаатай холбоогүй тусдаа хэлцлийн дагуу эсрэг талын өмчлөлийн зүйл нь

³⁵ Иргэний хуулийн III дэд хэсэг, Ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх үүрэг, 343-485 дугаар зүйл.

шаардах эрх бүхий бизнес эрхлэгчийн эзэмшилд байгаа бол үүнийг саатуулан барих байдлаар тухайн шаардах эрхээ хангуулж болохоор хуульчлах шаардлагатайг илтгэдэг.

Түүнчлэн Иргэний хуулийн 458 дугаар зүйлийн 458.3-т “Батлан даалтын гэрээгээр батлан даагчийн хүлээсэн үүрэг нь үүрэг гүйцэтгэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүрэгт хамаарна.” гэж заасан бөгөөд батлан даагч бусдын үүргийг үндсэн үүрэг гүйцэтгэгчийн хажуугаарр зэрэгцэн гүйцэтгэхээр амлах тул юуны өмнө батлан даах үүрэг үүссэн байх ёстой гэж үздэг. Энэ нь бизнес эрхлэгчдийн хооронд тогтмол хийгдэж буй арилжаанаас үүссэн үүргийн гүйцэтгэлийг нийтэд нь хангах арга болж чадах эсэх нь эргэлзээтэй байна.

Иргэний хуулийн 242 дугаар зүйлийн 242.2-т “Хамтран хүлээх үүрэг нь хууль буюу гэрээнд зааснаар, эсхүл үүргийн зүйлийн үл хуваагдах шинж чанартай холбоотой үүснэ” гэж заасан тул гэрээгээр хамтран үүрэг гүйцэтгэхээр тохироогүй тохиолдолд хамтран үүрэг гүйцэтгэх харилцаа үүсэхгүй гэж үзэх ба харин бизнесийн харилцаанд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хэн нь ч үүргээс чөлөөлөгдөхгүй буюу хамтран үүрэг гүйцэтгэхээр зохицуулах шаардлагатай.

10/Үл маргах журмын тухайд: Иргэний хуулийн 234 дугаар зүйлийн 234.4-т “Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардана.” гэж, Иргэний хуулийн 453 дугаар зүйлийн 453.2-т “Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй. Энэ заалт зөвхөн хөдлөх эд хөрөнгөнд хамаарна” гэж тус тус үл маргаж журмын талаар зохицуулсан байдаг боловч гэрээгээр тохиролцсон үл маргах журмыг албадан биелүүлэх тогтолцоо манай улсад байдаггүй тул эдгээр нь бодитоор хэрэгжихэд саад учруулж байна.

Үл маргаж журам нь шүүхийн шатыг алгасах, үүргийн гүйцэтгэлээ хурдан шуурхай хугацаанд олж авах боломжийг олгодог тул хэлцлийн нийтлэг зохицуулалт байдлаар талууд тохиролцвол гэрээндээ хэрэглэдэг байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

11/Хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах асуудал: Энэ хүрээнд хөөн хэлэлцэх хугацаа болон гомдлын шаардлага гаргах хугацааны хоорондын харилцааны талаар авч үзэх шаардлагатай байна.

Иргэний хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан, түүнчлэн гомдлын шаардлага гаргах буюу баталгаат хугацаа тогтоосон бол гомдлын шаардлагын хариуг авсан буюу эдгээр хугацаа дууссан үеэс үүснэ.” гэж зааснаас гадна гэрээний тусгай төрлийн зохицуулалтад гомдлын шаардлага гаргах тусгай хугацааг заасан байдаг.

Иргэний хуулийн “гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно” гэсэн шийдэл нь ялангуяа аж ахуйн хэлцэлд тохиромжгүй юм.

Тодруулбал, ердийн тохиолдолд шаардах эрх нь эрх зөрчигдсөн, эрх зөрчигдсөн тухай мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байгаа бол худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх гэх мэт гэрээнүүдийн хувьд тухайлбал доголдлын хувьд доголдолтой байсныг мэдсэн бол гомдлын шаардлага гаргах хугацаа тоологдон түүний дараагаар хөөн хэлэлцэх хугацаа тоологдож байна.

Түүнчлэн хэлцлийн хурдан шуурхай байдлыг хангах гол асуудал нь аж ахуй эрхлэгчийн анхаарал болгоомжтой байх буюу доголдлыг шалгах үүрэг байдаг. Иргэний хуулиар аж ахуй эрхлэгчид байх анхаарал болгоомжтой байх үүрэг болон аж ахуй эрхлэгч бус этгээдийн анхаарал болгоомжтой байх үүрэг хоорондоо ялгаатай болохыг хүлээн зөвшөөрсөн хэдий ч шүүхийн практикт эдгээрийг ялгаж хэрэглэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Тухайлбал, уг асуудлаар Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны зөвлөмжид "...орон сууцны талбайн хэмжээг мэргэжлийн, эсвэл зохих байгууллагаар хэмжүүлж, шалгаж, эд хөрөнгөө хүлээн авах, энэ байдлаар эд хөрөнгөө аваагүй бол худалдан авагч Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.1-д зааснаар шаардах эрхээ алдана." гэж дурдсанаас үзвэл шүүх "мэдэх боломжтой" гэсэн урьдчилсан нөхцлийг хэрэглэхдээ "орон сууцны талбайн хэмжээг мэргэжлийн, эсвэл зохих байгууллагаар хэмжүүлж, шалгаж, эд хөрөнгөө хүлээн авах" гэдэгтэй дүйцүүлж буйг харж болно.

Гэтэл Иргэний хуулийн 255-р зүйлийн 255.1.2-т "аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэн даруй шалган авах үүргээ биелүүлээгүй..." гэж аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдээс эд хөрөнгө хүлээн авахдаа ердийн тохиолдолтой харьцуулахад илүү анхааралтай байхыг хуулиар шаарддаг тул иргэн эд хөрөнгийг хүлээн авахдаа заавал шалгах үүрэг хүлээхгүй.

Эндээс дүгнэвэл хоёр аж ахуй эрхлэгчийн хоорондын худалдах, худалдан авах гэрээнд эрх зүйн харилцааг аль болох эрт үеэс тодорхой болгох зорилго бүхий худалдан авагч аж ахуй эрхлэгчид оногдуулсан шалгах үүрэг болон ердийн "мэдэх боломжтой" гэсэн урьдчилсан нөхцлийг хооронд нь ялгамжтай байдлаар авч үзээгүй байх бөгөөд иргэний эрх зүй болон арилжааны эрх зүйн, ахуйн харилцаа болон аж ахуйн харилцааг хооронд нь тодорхой байдлаар ялгаж, системчлэж ирээгүйтэй холбоотой.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь арилжаа эрхлэгчдийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилготой бөгөөд арилжаа эрхлэгч, арилжааны үйл ажиллагаа, хувиараа арилжаа эрхлэгч, арилжааны бүртгэл, түүнд сайн дураар бүртгүүлэх, жижиг арилжаа эрхлэгч, арилжааны хэлцэл зэрэг ойлголтыг тодорхойлох болон тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулснаар тус хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлох болно. Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу багцлан боловсруулах бөгөөд хуулийн төсөл нь нийт 22 бүлэгтэй, дараах бүтэцтэй байна. **Үүнд:**

-Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэлд хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, арилжааны эрх зүйн зарчим, арилжааны хууль тогтоомж болон

арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх суурь зарчмын талаар тус тус зохицуулах болно.

-Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт арилжааны эрх зүйн харилцаанд оролцогч буюу арилжаа эрхлэгч, хувиараа арилжаа эрхлэгч, арилжаа эрхлэгч хуулийн этгээд, насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны хувь хүн арилжаа эрхлэх тохиолдол, нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэг, арилжааны бүртгэлд сайн дурын үндсэн дээр бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болох хувь хүн, жижиг арилжаа эрхлэгч зэргийг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, холбогдох зохицуулалтыг тусгана;

-Хуулийн гуравдугаар бүлэгт арилжааны бүртгэлийн тогтолцоо, арилжааны бүртгэлийн үр дагавартай холбогдох зохицуулалтыг тусгах бөгөөд энэ нь хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэл төдийгүй нөхөрлөл болон компанийн холбогдох улсын бүртгэлийн харилцаанд нэгэн адил үйлчлэхээр тогтооно.

-Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлгээр арилжааны нэртэй холбоотой харилцааг зохицуулсан зохицуулалтыг тусгана. Ингэхдээ хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрээ бүртгүүлэх, бүртгүүлснээр бусдад ашиглуулах, шилжүүлэх, өв залгамжлуулах эрх нь баталгаажих, үүнтэй холбоотой эрх зүйн үр дагаврыг хэрхэн зохицуулах талаар тусгана.

-Хуулийн төслийн тавдугаар бүлэгт арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрхийн талаар тусгана. Арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг шилжүүлэх, түүний хязгаарлалт мөн арилжаа эрхлэгчийн ажилтанд тодорхой төрлийн хэлцэл, түүнд хамаарах хууль ёсны үйлдэл хийх бүрэн эрхийг олгох зохицуулалтыг тусгана.

-Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт арилжаа эрхлэгчийн ажилтны үл өрсөлдөх үүргийн талаар тусгана. Арилжаа эрхлэгч болон ажилтан нь хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос хойш тодорхой хугацааны турш ажилтанд үл өрсөлдөх үүргийг хүлээлгэсэн гэрээг бичгээр байгуулж болох, мөн тус гэрээ хүчин төгөлдөр бус байх нөхцөлийн талаар тусгана.

-Хуулийн төслийн долдугаар бүлэгт арилжааны төлөөлөгчийг тодорхойлох бөгөөд түүнтэй холбогдсон харилцааг зохицуулсан зохицуулалтыг нарийвчлан тусгана. Тухайлбал одоо үйлчилж буй Иргэний хуульд арилжааны төлөөлөгч, комиссыг нэг зүйл заалтаар хамтад нь зохицуулж байсныг ялган салгаж, арилжааны төлөөлөгчийн эрх, үүргийг илүү нарийвчлан тодорхойлно.

-Хуулийн төслийн наймдугаар бүлэгт Иргэний хуулийн 413, 414 дүгээр зүйлийн дагуу зохицуулж байсан худалдааны зуучлагчийн талаарх нарийвчилсан зохицуулалтыг тусгана. Ингэхдээ нэр томъёог арилжааны зуучлагч гэж өөрчилнө.

-Хуулийн төслийн есдүгээр бүлэг буюу II дугаар хэсэг нь Арилжааны хуулийн тусгай ангийн зохицуулалт болно. Тус бүлэгт арилжааны хэлцэл, нэг талт арилжааны хэлцэл, арилжааны хэлцлийн үүргийн ерөнхий ангид хамаарах зохицуулалтуудыг нарийвчлан тусгана. Арилжааны хэлцлийн зохицуулалтыг Иргэний хуулийн үүргийн эрх зүйн ерөнхий ангийн хэм хэмжээнээс ялгамжтай байдлаар тодоохойлно.

-Хуулийн төслийн аравдугаар бүлэгт худалдах, худалдан авах гэрээний тусгайлсан зохицуулалтыг тусгана. Үүнд гэрээний зүйлийн шинж чанарыг тодорхойлж хийсэн тохиолдол, барааны жингээр үнийг тодорхойлох, үүрэг гүйцэтгэх хугацаа заасан тохиолдол, доголдлыг нэн даруй шалгах, мэдэгдэх үүргийн талаар тус тус зохицуулалт оруулна.

-Хуулийн төслийн арван нэгдүгээр бүлгээс хорьдугаар бүлэг хүртэл тухайлсан арилжааны гэрээний онцлог хэм хэмжээг тодорхойлж оруулна.

Үүнд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа, санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээний нийтлэг зохицуулалт, франчайз, мерчандайз, комисс (ингэхдээ худалдааны төлөөлөгч, комиссыг нэг зүйл заалтаар хамтад нь зохицуулж байсныг ялгаж зохицуулна.), аялал жуулчлал, илгээмж, тээвэрлэлт (ингэхдээ нийтлэг үндэслэл, зорчигч тээвэрлэлтийн гэрээ, ачаа тээвэрлэлтийн гэрээний талаар тус бүрийн хувьд дэд бүлгээр зохицуулна.), хадгалалт, барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах, Иргэний хуулийн 431-444 дүгээр зүйлээр зохицуулж байсан даатгал, зээл тооцооны үүрэг (үүнд, төлбөр тооцооны гэрээ, аккредитив, инкасс, банк зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээл, мөнгөн хадгаламжийн гэрээ, банкны баталгааны гэрээний харилцааг тус тус зохицуулна.), тооцоо нийлэх гэрээний харилцааг тус тус зохицуулна.

Хуулийн төслийн хорин нэгдүгээр бүлэгт бусад зүйл буюу хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх хугацааг тусгана.

Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Энэ хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэгч буюу арилжаа эрхлэгчийн арилжаа, бизнесийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзсэн буюу Иргэний хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилсан хуулийн хэм хэмжээ бий болох бөгөөд иргэний эрх зүй болон арилжааны эрх зүйн зохицуулалт хоорондын ялгааг арилжаа эрхлэгч, арилжааны үйл ажиллагаа болон сайн дурын бүртгэлийн дагуу тодорхойлж, арилжааны нэр, арилжааны бүртгэл, арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх, арилжааны хэлцлийн ерөнхий ангийн зохицуулалт гэх зэрэг шинэ хэм хэмжээ тусгагдсанаар бизнес эрхлэгч буюу арилжаа эрхлэгч илүү мэргэшсэн, хариуцлагатай байх суурь нөхцөл бүрдэж, арилжаа эрхлэгчдийн хоорондын маргааныг шийдвэрлэхэд материаллаг хууль хэрэглээний хувьд илүү тодорхой нөхцөл байдал бүрдэнэ гэж үзэж байна.

Түүнчлэн арилжааны хуулийн төсөлд бизнес эрхлэгчид буюу арилжаа эрхлэгчдийн хооронд тогтсон практик, заншлын хэм хэмжээг шүүх хэрэглэх боломжийг тусгах бөгөөд энэ нь эх сурвалжийн хувьд илүү өргөн боломжийг арилжаа эрхлэгчдэд олгох болно. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчдэд өөрсдийн бий болгосон хэм хэмжээг өөрсдийнхөө харилцаанд тодорхой нөхцөл, шаардлагын дор хэрэглэх боломж бий болно.

Мөн хуулийн төсөл батлагдсанаар хувийн эрх зүйн системчлэл, хууль хэрэглээний нэгдмэл байдал илүү тодорхой болж хөгжих суурь тавигдана. Үүний үр дүнд арилжаа эрхлэгчдийн хийж буй арилжааны хэлцэл баталгаатай, хууль хэрэглээний хувьд нэгдмэл байдал бий болсноор маргаан үүсэх шалтгаан нөхцөл

буурч, бизнесийн харилцааны түргэн шуурхай байдал сайжрах, улмаар эдийн засгийн эргэлт улам эрчимжих зэрэг эдийн засаг, нийгэм, хууль зүйн чухал ач холбогдолтой.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд зэрэг холбогдох бусад хуулийн төслийг тус тус боловсруулна.

--oOo--

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Арилжааны хуулийн төслийн талаар

Монгол Улсад худалдаа, бизнес, арилжаатай холбоотой харилцааг Иргэний хууль болон Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Даатгалын тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай зэрэг тусгайлсан хуулиудаар зохицуулж байгаа боловч аж ахуй эрхлэгч (арилжаа эрхлэгчийг өөртөө багтаасан ойлголт) хоорондын харилцаа, түүн дотор ашгийн төлөө зорилго бүхий арилжаа эрхлэгч нарын арилжааны үйл ажиллагаатай холбоотой харилцааг цогц байдлаар, бусад субъект хоорондын харилцаанаас онцлон зохицуулсан хууль тогтоомж батлагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, Иргэний хуулиар аж ахуй эрхлэгч хоорондын (B2B) аж ахуй эрхлэгч болон хэрэглэгч хоорондын (B2C), эсхүл хэрэглэгч буюу иргэд хоорондын (C2C) харилцааг өөр хооронд нь ялгаж зохицуулсан зарим хэм хэмжээг жишээ нь аж ахуй эрхлэгч, аж ахуйн үйл ажиллагаа, худалдааны бусад үйл ажиллагаа, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй иргэн, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил гэх зэрэг нэр томъёог хэрэглэх замаар хуульчилсан боловч эдгээр нэр томъёог хэрхэн тайлбарлах, өөр хоорондоо ялгаатай эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээг хэрхэн ялгаж хэрэглэх талаар хангалттай тодорхой зохицуулаагүй орхигдуулжээ. Энэ нь Иргэний хуулийг анх боловсруулан батлах үед бусад орны Иргэний хууль төдийгүй Арилжааны хуулийг ч тодорхой хэмжээнд ашигласантай холбоотой юм. Иймд гадны зарим судлаачид арилжааны эрх зүйн харилцааг зохицуулсан хэм хэмжээг ямар тохиолдолд хэрэглэх талаар цаашид тодруулах шаардлагатайг бидэнд анхааруулсан нь бий.

Монгол улсын Иргэний хуулийг боловсруулах үед тухайлбал ХБНГУ-ын Иргэний хууль, Арилжааны хууль (Handelsgesetzbuch), Гүрж улсын Иргэний хууль (1997 он)-ийн зохицуулалтыг түлхүү харгалзан үзсэн байх бөгөөд Гүрж улсын хувьд тухайн Иргэний хуулиа батлахаас өмнө 1994 онд Аж ахуй эрхлэгчийн тухай хуулийг баталсан байжээ(хожим 2021 онд шинэчилсэн). Тиймээс одоогийн Иргэний хуульд Гүрж улсын Иргэний хууль (Аж ахуй эрхлэгчийн тухай хуультай орны Иргэний хууль) болон ХБНГУ-ын Арилжааны хуулийн зохицуулалтыг ашигласантай холбоотойгоор аж ахуй эрхлэгч, аж ахуйн үйл ажиллагаа, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил гэх зэрэг нэр томъёо хуульчлагдсан байна.

Дээрх нөхцөл байдлаас үзвэл одоогийн Иргэний хуулийн зохицуулалтыг хэрэглэхэд Иргэний эрх зүй болон Арилжааны эрх зүйн ялгаа заагийг гаргах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн болохыг харуулж байна. Учир нь одоогийн Иргэний хуульд бусад орны Арилжааны хуулийн зохицуулалтыг зарим тохиолдолд ашигласан боловч ямар шалгуурын дагуу хэрэглэх эсэх, Иргэний эрх зүйн бусад зохицуулалтаас ямар ялгаатай болохыг хангалттай тодорхойлоогүй байгаа юм. Нөгөөтэйгүүр арилжааны эрх зүйн онцлог, нарийвчилсан бусад зохицуулалтуудыг судлан тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүссэн гэж болно.

Иймд Арилжааны хууль бүхий Герман, тус улсын хуулийг өөрийн оронд нутагшуулсан Япон, Солонгос (Япон улсаас рецепц хийсэн), Гүрж зэрэг эх газрын эрх зүйн системтэй зарим улс орнуудын жишгээр бизнес эрхлэгч буюу арилжаа эрхлэгчдийн зарим харилцааг Иргэний хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилсан зохицуулалттай, бизнес эрхлэгч буюу арилжаа эрхлэгч нарын арилжааны үйл ажиллагааны онцлогийг харгалзан үзсэн арилжааны хуулиар зохицуулна.

Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй” судалгаанд гэрээний хэрэгжилтийг хангах шалгуур үзүүлэлтийн хувьд арилжааны маргааныг тусгайлан шийдвэрлэх институт байгаа эсэхийг голчлон анхаарч үнэлдэг. Манай улсад өгсөн үнэлгээгээс арилжааны шинжтэй маргааныг иргэний хэрэг маргаанаас ялгаатай, онцлог журмаар шийдвэрлэх дэд бүтэц дутагдаж байгааг харж болохоор байна. Иймд Арилжааны хууль батлагдсанаар цаашлаад энэ чиглэлээр мэргэшсэн шүүгч, өмгөөлөгч бэлтгэгдэх, түүнчлэн арилжааны дагнасан шүүх байгуулах, эсхүл иргэний шүүхдээ арилжааны хэргийн танхим байгуулах нөхцөл боломж бий болохыг үгүйсгэхгүй.

Арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаагаар бие даасан арилжааны хууль батлахыг зөвлөсөн бөгөөд хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг 2019 онд ХЗДХЯ, СЗХ, Монголбанкны төлөөлөл, хувийн эрх зүйн судлаач, шүүгч, өмгөөлөгч зэрэг гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Мөн хуулийн төслийг боловсруулахтай холбоотойгоор ажлын хэсгийн гишүүдийг сургалтад хамруулсан бөгөөд ХЗДХЯ-ны захиалгаар дараах судалгаануудыг хийлгэсэн:

1/Арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа;

2/Иргэний хуулийн III хэсэг /Гэрээний эрх зүй/-т заасан арилжааны гэрээний төрлүүдийн судалгаа;

3/Гадаад орнуудын арилжааны хуулиудын харьцуулсан судалгаа;

4/Ханнс Зайделийн сангийн дэмжлэгтэйгээр Арилжааны заншил, тогтсон практикийн судалгаа, Арилжааны хууль тогтоомжийн зохицуулалтын талаарх бизнес эрхлэгчдийн байр суурь судалгаа.

Арилжааны хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд 22 бүлэгтэй, 137 зүйлтэй байна. Уг төсөлд арилжааны эрх зүйн зарчим, арилжааны хууль тогтоомжийг хэрэглэх журам, арилжааны эрх зүйн харилцаан оролцогч буюу арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг арилжаа эрхлэгч, насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны хувь хүн арилжааны үйл ажиллагаа эрхлэх, арилжааны бүртгэлд сайн дурын үндсэн дээр бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болох этгээдүүд, жижиг арилжаа эрхлэгч зэрэг ойлголтын талаар, арилжааны бүртгэлийн ойлголт, тогтолцоо, хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэл буюу төрөлжсөн бүртгэлийн талаар, арилжааны бүртгэлийн үр дагавар (позитив болон негатив), арилжааны нэр, шударга бусаар бусдын арилжааны нэрийг ашиглахыг хориглосон зохицуулалт, эрх нь зөрчигдсөн этгээдүүдийн эрх, арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх, өв залгамжлуулах тохиолдол, арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх, түүний хязгаарлалт, арилжааны төлөөлөгч, арилжааны зуучлагч, арилжааны хэлцлийн нийтлэг зохицуулалт болон бусад гэрээний тусгайлсан зохицуулалтыг тусгасан.

Арилжааны хуулийн төслөөр зохицуулах гэж байгаа харилцаа нь өмнө нь огт зохицуулалтгүй байсан бус Иргэний хуулиар зохицуулагддаг байсан тул Иргэний хуульд тодорхой хэмжээгээр нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн төслийн агуулга, зарчимтай уялдуулах шаардлага үүсэхээр байна. Иймд зарчмын хувьд Арилжааны хуульд тусгах нь зохистой зохицуулалтуудыг Иргэний хуулиас хасаж, нэг мөр ангилж төрөлжүүлэх зарчмыг барих нь зүйтэй гэж үзсэн тул зарим бүлэг, зүйл, хэсэг, заалтуудыг Иргэний хуулиас хасаж, Арилжааны хуулийн төсөлд оруулна. Ингэхдээ нэр томъёотой холбоотойгоор зарим хэсгүүдэд өөрчлөлт оруулсан бөгөөд Иргэний хуулийн III хэсэг буюу Гэрээний эрх зүйгээс хэд хэдэн гэрээний хувьд хамгийн багадаа нэг тал нь заавал арилжаа эрхлэгч байх буюу арилжааны хэлцэл болох гэрээнүүдийг мөн ялгаж, зарим хэсэгт зохих нэмэлт, өөрчлөлтийг хийж Арилжааны хуулийн төсөлд тусгасан. Иргэний хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дээрх шалтгаанаар хүчингүй болгоно:

- 42 дугаар зүйлийн 42.3;
- 196 дугаар зүйлийн 196.1.7, 196.2, 196.3;
- 200 дугаар зүйлийн 200.4;
- 255 дугаар зүйлийн 255.1.2;
- Барьцаалан зээлдүүлэх журмаар болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор зээл олгох 286 дугаар зүйл;
- Санхүүгийн түрээс 312-317 дугаар зүйл;
- Франчайзийн гэрээ, Мерчандайзын гэрээ 333-338¹ дугаар зүйл;
- Аялал жуулчлалын гэрээ 370-379 дүгээр зүйл;
- Тээвэрлэлтийн гэрээ 380-398 дугаар зүйл;
- Илгээмжийн гэрээ 407-409 дүгээр зүйл;
- Худалдааны зуучлагч, төлөөлөгч, комисс 413-419 дүгээр зүйл;
- Хадгалалтын гэрээний зарим хэсэг, заалт 422.2, 427 дугаар зүйл;
- Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ 428-430 дугаар зүйл;
- Даатгалын гэрээ;
- Зээл тооцооны үүрэг 445-457 дугаар зүйл;
- Тооцоо нийлэх 466 дугаар зүйл.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу багцлан боловсруулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 1/2029 дугаар албан бичгээр төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагуудаас саналыг авч тусгасан. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг олон нийтэд танилцуулж дараах хэлэлцүүлсэн болно. Үүнд:

-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр “Арилжааны хуулийн төслийн үзэл баримтлал, зарим асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг эрдэмтэн, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан зохион байгуулж, бизнесийн эрх зүйн орчинд тулгамдаж байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам болон ХЗДХЯ-наас боловсруулж байгаа Арилжааны хуулийн төслийн үзэл баримтлалыг оролцогчдод танилцуулан хэлэлцүүлсэн;

-Монголын Хуульчдын холбоотой хамтран 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Арилжааны хуулийн төслийн талаар хуульчдын хүрээнд хэлэлцүүлсэн;

-Арилжааны хууль, эрх зүй хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын Худалдааны департаментын Ерөнхий зөвлөхийн албатай хамтран арилжааны гэрээний эрх зүйн сургалтыг шүүгч, өмгөөлөгч, хуульч, судлаач нарт зориулан 2024 оны 09 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсан.

-2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Иргэний хууль тогтоомж: “Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэв уулзалтад Арилжааны хуулийн төслийг тус тус танилцуулж, хэлэлцүүлсэн

-2025 оны 5 дугаар сард Арилжааны хуулийн төслийн танилцуулга, хэлэлцүүлгийг эрдэмтэн, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан тус тус зохион байгуулсан болно.

Мөн 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны www.mojha.gov.mn албан ёсны цахим хуудаст хуулийн төсөл, товч дэлгэрэнгүй танилцуулга, тэдгээрийн англи хэл дээрх хувилбар болон холбогдох бусад судалгааг байршуулан иргэд, олон нийт судалж, танилцан, санал өгөх боломжоор хангаж ажиллаа.

--oOo--

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Арилжааны хуулийн төслийн талаар

Удиртгал

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хууль буюу 2002 оны Иргэний хуулийн талаар судлаачид 1963 оны БНМАУ-ын “Иргэний хуулийн ихэнх зүйл, заалтыг 2002 оны Иргэний хуульд өнөөгийн төрийн бодлого, нийгмийн амьдралын өөрчлөлтийн дагуу улам боловсронгуй болгон өвлөн авч хэрэглэж байна” хэмээн дүгнэсэн нь бий¹. Харин судлаач Виллъям Э.Батлер (William E. Butler)-ын дүгнэснээр 1963 оны Иргэний хууль нь ЗХУ-ын Иргэний хуульд үндэслэн зохиогдсон². ОХУ-ын судлаачдын үзэж буйгаар хувийн эрх зүйн хувьд ОХУ нь ЗХУ-ын эрх зүйн уламжлалыг өвлөн авч хэрэглэж байгаа бөгөөд хувийн эрх зүйн тогтолцоо нь монист үзэл хандлагад суурилан хөгжсөн гэж дүгнэх боломжтой юм³.

ОХУ-ын судлаачид “оросын хувьд Арилжаа (худалдаа)-ны хуулийг тусад нь батлах түүхэн шаардлага байгаагүй бөгөөд өмнө нь батлагдаж байсан хууль тогтоомж (жишээ нь Худалдааны шинэ журам (Новоторговый устав 1667г.), 1917 оны хувьсгалаас өмнө үйлчилж байсан Худалдааны журам (Устав торговый) гэх мэт) нь хувийн эрх зүйн хэм хэмжээг огт хуульчлаагүй байсан” гэж дүгнэсэн байдаг⁴.

Эндээс дүгнэвэл одоогийн 2002 оны Иргэний хуулийг монист үзэл хандлагад суурилсан буюу иргэний болон арилжааны эрх зүйн харилцааг нэг кодексоор зохицуулах хэв шинжтэй гэж дүгнэх бүрэн боломжтой юм. Гэвч 2002 оны Иргэний хуульд аж ахуй эрхлэгч (ИХ-ийн 196.2, 200.4), аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй иргэн (ИХ-ийн 202.2), аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч (ИХ-ийн 255.1.2) гэх зэрэг нэр томъёо хуульчлагдсан бөгөөд эдгээр зохицуулалтууд нь Гүрж улсын Иргэний хууль (335, 343.2, 347, 348, 495)-ийн холбогдох зохицуулалтын агуулгад үндэслэн боловсруулагдсан нь тодорхой байдаг. Гүрж улсын Иргэний хуульд аж ахуй эрхлэгч, аж ахуйн үйл ажиллагаа гэх зэрэг нэр томъёо хуульчлагдсан нь тус улс Иргэний хуулиасаа гадна Аж ахуй эрхлэгчийн тухай хуулийг баталж мөрдүүлдэгтэй шууд холбогддог. Тус Аж ахуй эрхлэгчийн тухай хууль нь олон улсад нийтлэг байх Commercial code-д хамаарна.

Нөгөө талаас одоогийн 2002 оны Иргэний хуулийн зарим зохицуулалтыг боловсруулахдаа ХБНГУ-ын Handelsgesetzbuch буюу Арилжааны хуулийн зарим зохицуулалтыг харгалзан үзсэн байдаг. Хамгийн гол жишээг дурдахад ХБНГУ-ын Арилжааны хуулийн 93-104-р зүйлийн зохицуулалт нь манай улсын Иргэний хуулийн 413-419-р зүйлийн зохицуулалтад онцгой нөлөө үзүүлсэн болох нь тодорхой харагдана. Тиймээс ч Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарыг бичсэн ХБНГУ-ын

¹ Т.Мөнхжаргал, Монгол Улсын Иргэний Цаазын товчоон, УБ, 2006, 187 дахь тал

² WILLIAM E.BUTLER, THE MONGOLIAN LEGAL SYSTEM: CONTEMPORARY LEGISLATION AND DOCUMENTATION, MARTINUS NIJHOFF, 266-267 (1982)

³ Р.Пүрэвбаатар, Арилжаа (худалдаа)-ны эрх зүйн талаарх харьцуулсан судалгаа: зарим улс орон дахь чиг хандлага ба өөрийн орны нөхцөл байдлыг эргэцүүлэх нь, Хууль дээдлэх ёс №4, Цуврал 84 (2021), 51 дэх тал

⁴ Беляева О.А. Коммерческое право России: курс лекций, Юстицинформ, 2009 г, С.7

шүүгчдийн хувьд Иргэний хууль дахь “аж ахуйн үйл ажиллагаа” гэх ойлголтыг ХБНГУ-ын Арилжааны хуулийн 1-р зүйл дэх handelsgewerbe гэх ойлголтын тайлбартай төсөөтэй байдлаар тайлбарлахыг санал болгосон нь бий⁵.

Дээрх нөхцөл байдлыг эргэцүүлэн үзвэл одоогийн Иргэний хуулийн зохицуулалт нь тусдаа Арилжааны хууль (Commercial code) баталсан буюу дуалист үзэл баримтлалд суурилсан улс орны Иргэний хуулийн зохицуулалтыг эх сурвалж болгон ашигласан төдийгүй Арилжааны хуулийн зохицуулалтыг шууд ашиглан боловсруулагджээ. Гэвч иргэний эрх зүйн болон арилжааны эрх зүйн зохицуулалт хоорондын ялгааг харгалзан үзээгүйн дээр, ямар шалгуураар ялгаж хэрэглэх, арилжаа эрхлэгчийн хувьд ямар нарийвчилсан зохицуулалт бусад оронд үйлчилдэг болохыг судалж тусгаагүй гэж дүгнэж болох юм.

Иймд дээрх онцлогийг харгалзан үзэж судлаачдын зүгээс бие даасан арилжааны хуулийн төслийг боловсруулах нь зохистой болох талаар өөрсдийн саналыг илэрхийлсэн нь бий. Тус саналд “одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хууль нь 2002 онд батлагдснаас хойш даруй 17 жил хэрэгжиж байгаа ч хувийн эрх зүйн харилцааг боломжит хэмжээнд зохицуулсаар байна. Түүнчлэн Иргэний хууль нь нийгэм дэх иргэн, хуулийн этгээд хоорондын үүсэх гэрээний болон гэрээний бус үүргийн харилцаа, өмчийн харилцааг цогцоор нь зохицуулдаг суурь хууль байх тул тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар аж ахуй эрхлэгчийн ялгамжтай зохицуулалтыг бий болгохоос илүүтэй аж ахуй эрхлэгчийн харилцааны онцлогийг агуулсан бие даасан хуулийн төсөл байх нь илүү оновчтой арга зам юм” гэжээ⁶. Улмаар субъектив шалгуур⁷ыг баримтлан тус хуулийн төслийг боловсруулах нь арилжааны эрх зүйн хамгийн сүүлийн үеийн чиг хандлагад үндэслэх боломжийг бий болгож байгаагаараа ихээхэн ач холбогдолтой гэж үзжээ.

Өмнө дурдсанчлан одоогийн Иргэний хуулийн зохицуулалт нь ХБНГУ-ын Иргэний хууль, Арилжааны хууль болон Гүрж улсын Иргэний хуульд суурилсан. Харин Гүрж улсын Аж ахуй эрхлэгчийн тухай хууль нь ХБНГУ-ын Арилжааны хуульд голлон суурилсан аж. Нөгөөтэйгүүр ХБНГУ болон Гүрж улсын Арилжааны кодекс нь аль аль нь субъектив шалгуурт үндэслэсэн байх тул тус хуулийн төслийн хувьд ч субъектив шалгуурыг баримтлан боловсруулах нь зохистой гэж үзэж байна.

Нэр томъёоны хувьд манай улсын судлаачид орос хэлний “торговый”, “коммерческое” зэрэг үгийг тус бүр худалдааны, арилжааны гэх байдлаар хөрвүүлсэн байх⁸ бөгөөд олон улсад “commercial code” гэх байдлаар нэрлэж заншсан байх тул trade гэх ойлголтоос ялгаж “арилжаа”, “арилжааны эрх зүй”, “арилжааны хууль” гэсэн

⁵ Ё. Кают нар, Монгол Улсын Иргэний хуулийн тайбар .,УБ 2010 он, 829-р тал

⁶ Б.Амарсанаа нар, Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, УБ.,2019 он, 58 дахь тал

⁷ Субъектив шалгуур гэх ойлголтын талаар дэлгэрэнгүйг Р.Пүрэвбаатар, Арилжаа (худалдаа)-ны эрх зүйн талаарх харьцуулсан судалгаа: зарим улс орон дахь чиг хандлага ба өөрийн орны нөхцөл байдлыг эргэцүүлэх нь, Хууль дээдлэх ёс №4, Цуврал 84 (2021), 49, 56-57 дахь талаас үзнэ үү.

⁸ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн англи, орос, латин, хадмал эх толь, Адмон, 2015, Б.Амарсанаа, Худалдаа (арилжаа)-ны ерөнхий хууль (Commercial Code)-ийн төслийн төсөөлөл, анхаарах асуудал, Монгол улс, Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: худалдаа (арилжаа)-ны эрх зүй, илтгэлийн эмхэтгэл, УБ, 2017-г үзнэ үү.

нэр томъёог хэрэглэх нь илүү оновчтой гэж үзсэн болно⁹. “Арилжаа эрхлэгч” гэдэг нэр томъёоны хувьд Монгол Улсад бизнес эрхлэгч, бизнесийн байгууллага гэдэг нэр томъёогоор илүү хэрэглэж заншсан байна. Англи хэлэнд “entrepreneur”, “merchant”, “business entity”, “trader” зэрэг харилцан адилгүй нэр томъёог хэрэглэж заншсан боловч эрх зүйн нэр томъёоны хувьд эдгээр нь утга агуулгаараа ойролцоо юм. Бизнес буюу аж ахуй эрхэлж байгаа хүн, хуулийн этгээд болгоныг арилжаа эрхлэгч гэж тооцохгүй, тодорхой шалгуур хангасан байхыг шаардаж байгаа тул одоо байгаа нэр томъёог хэрэглэж эргэлзээ үүсгэхээс татгалзаж, “арилжаа эрхлэгч” гэсэн Монгол Улсын хууль зүйн нэр томъёонд төдийлөн хэрэглэж байгаагүй нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Арилжааны хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл бөгөөд 22 бүлэг, 137 зүйлтэй байна. Хуулийн төслийг бүлэг тус бүрээр багцлан дор танилцуулья.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Арилжааны эрх зүй нь хувийн эрх зүйн салбар боловч Иргэний эрх зүйгээс ялгарах зарим онцлог зарчимтай байдаг. Иймд Иргэний хуулийн 1.2-т заасан зарчмуудаас гадна арилжааны эрх зүйн онцлогийг тодотгосон дараах тусгайлсан зарчмууд мөрдөгдөхөөр тусгалаа. Үүнд:

- *Арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах* зарчмын хүрээнд Иргэний хуулийн субъектээс ялгаатай нь арилжаа эрхлэгч нь нэгэнт ашиг олохыг зорьж байгаа этгээд тул бусдын төлөө хийсэн үйлдэлдээ хариу төлбөр шаардах эрхийг баталгаажуулсан. Тухайлбал, гэрээнд хүү авахтай холбоотой тохиролцоо байхгүй байсан ч нөгөө талын буруугаас болж хөрөнгө нь эдийн засгийн эргэлтэд орж чадахгүй болсон тохиолдолд алдагдлыг нь аль болох бага байлгах зорилгоор хуульд заасан хүү, хөлс, шагнал шаардах эрх, түүнчлэн барьцааны эд хөрөнгө, эсхүл хадгалж байгаа эд хөрөнгийг худалдан борлуулж, борлуулсан үнээс өөрийн зардлаа гаргаж авах зэрэг эрхүүд тусгагдсан.

- *Гадаад нөхцөл байдалд үнэнч шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах* зарчмын хүрээнд арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх, арилжааны бүртгэлтэй холбоотой зохицуулалтууд тусгагдсан. Тухайлбал, арилжаа эрхлэгчийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэж байхад түүнийг тухайн хэлцлийг байгуулах, эсхүл бараа хүлээн авах, буцаах гэх мэт тодорхой үйлдлийг гүйцэтгэх эрхтэй эсэхийг заавал шалгах нь ажлыг удаашруулж хүндрэл үүсгэх тул түүнийг арилжаа эрхлэгчийг төлөөлөх бүрэн эрхтэй гэж тооцох зохицуулалт тусгасан. Түүнчлэн арилжаа эрхлэгч өөрийн арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах эрхийг хэн нэгэнд өгсөн боловч үл хөдлөх эд хөрөнгө захиран зарцуулах, барьцаа, баталгаа гэх мэт өөрт нь үүрэг үүсгэх хэлцэл хийх эрхийг олгоогүй бол энэ талаараа төлөөлөгч, төлөөлүүлэгч нар гуравдагч этгээдэд урьдчилж мэдэгдсэн тохиолдолд л эдгээр хязгаарлалт үүсэхээр буюу үүсэх үр дагавар, хариуцлагаас нь төлөөлүүлэгч чөлөөлөгдөхөөр заасан. Түүнчлэн арилжааны бүртгэлийг нь энэ зарчмыг хангах зорилгоор бий болгох бөгөөд арилжааны бүртгэлд оруулсан аливаа нээлттэй мэдээллийг гуравдагч этгээд үзэж, түүнийг үнэн зөв гэж итгэх итгэлийг нь баталгаажуулсан.

⁹ Эдгээр үгийг ойролцоо утга, агуулгаар эсхүл төдийлөн ялгалгүй хэрэглэх тохиолдол байгаа болохыг энд дурдах зүйтэй.

• *Арилжаа эрхлэгч нь үүргээ биелүүлэхдээ мэргэшсэн, анхаарал болгоомжтой хандах зарчмын хүрээнд жишээ нь худалдах, худалдан авах гэрээний талууд хоёулаа арилжаа эрхлэгч байгаа тохиолдолд буюу хоёр талт арилжааны хэлцлийн хувьд худалдан авагч арилжаа эрхлэгч нь худалдаж авсан бараагаа нэн даруй шалгах, доголдол илэрвэл тэр даруй худалдагчид энэ талаар мэдэгдэх үүрэгтэй бөгөөд үүнийг биелүүлээгүй бол доголдлыг нь хүлээн зөвшөөрч хүлээн авсанд тооцож, шаардлага гаргах эрхээ алдах үр дагавартай байхаар заасан. Мөн арилжаа эрхлэгч нь нэгэнт амласан буюу эрсдэлээ тооцсоны үндсэн дээр зөвшөөрч гэрээ байгуулсан тул өөрийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой төлөхөөр тохиролцсон анзыг багасгуулахаар Иргэний хуулийн субъектын адил шаардах эрхгүй гэх мэт зохицуулалтууд тусгагдсан.*

• *Арилжааны үйл ажиллагааны хялбар, шуурхай байдлыг хангах зарчмын хүрээнд хэлцэл богино хугацаанд байгуулагдах, өөрчлөгдөх, дуусгавар болсон эсэх нь тодорхой болж байх шаардлагатай бөгөөд гэрээ байгуулах санал, түүнийг хүлээн зөвшөөрөх саналыг илүү хялбар, түргэн шуурхай зохицуулах, зэрэг аж ахуй эрхлэгчдийн харилцааг хялбар бөгөөд түргэн шуурхай байлгах тусгай зохицуулалтыг тусгасан.*

Арилжааны хууль тогтоомжийн эрэмбэ, түүнийг хэрэглэхтэй холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь хэсэгт заасан. Үүнтэй уялдуулан Иргэний хуульд мөн өөрчлөлт оруулсан. Арилжаа эрхлэхтэй холбоотой харилцааг тухайлсан хуульд өөрөөр заагаагүй бол Арилжааны хуулийг хэрэглэнэ. Арилжааны хуульд өөрөөр заагаагүй бол тухайлсан хууль болон Арилжааны хуульд арилжаа эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулснаас бусад харилцааг энэ хуулийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр Иргэний хуулийг хэрэглэнэ.

Тухайлсан хууль болон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг арилжааны заншил, талуудын хооронд тогтсон практикийн дагуу, тийм заншил, практик байхгүй, эсхүл талууд түүнийг хэрэглэхгүй талаар хүсэл зоригоо тодорхой илэрхийлсэн тохиолдолд энэ хуулийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр Иргэний хуулийг хэрэглэхээр тусгасан.

Хэдийгээр Иргэний хуульд ажил хэргийн хүрээнд тогтсон заншил, талуудын хооронд тогтсон практикийг хэрэглэж болохоор заасан боловч шүүхийн шийдвэрт судалгаа¹⁰ хийхэд маргааны талуудаас эдгээрийг нэхэмжлэл, хариу тайлбарын үндэслэлдээ дурдсан тохиолдол хэд хэд байгаа хэдий ч шүүгч түүнийг хэргийг хянан шийдвэрлэхдээ харгалзан үзээгүй бөгөөд шүүхийн шийдвэрт яагаад хэрэглээгүй гэдгээ тайлбарласан тохиолдол байхгүй байна. Үүнээс үзэхэд шүүгч хэрэг маргааны шийдвэрлэхдээ хуулиас бусад эрх зүйн эх сурвалжийг хэрэглэхээс зайлсхийх хандлагатай байна. Харин арилжааны эрх зүйд, ялангуяа хоёр талт арилжааны хэлцлийн хувьд мэргэшсэн арилжаа эрхлэгчдийн хоорондын харилцааг зөвхөн хуулиар бус гэрээгээрээ болон талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил буюу арилжааны заншлаараа илүү уян хатан зохицуулах боломжийг олгодог. Учир нь арилжаа эрхлэгчид нь иргэний эрх зүйн субъектээс илүү мэргэшсэн, хариуцлагатай субъект болохын хувьд өөрөө өөрсдийнхөө харилцаанд

¹⁰ Арилжааны заншил, тогтсон практикийн талаарх судалгаа. Улаанбаатар хот. 2020 он. "Өмгөөлөл судлалын академи" ТББ.

хэрэглэх хэм хэмжээгээ бүтээхийг тодорхой хэмжээнд зөвшөөрдгөөрөө иргэний эрх зүйгээс ялгардаг. Иймд талуудын хооронд тогтсон практик, арилжааны заншлыг арилжааны эрх зүйн нэгэн эх сурвалж болгож, шүүх эдгээр хэм хэмжээг хэрэглэхийг дэмжих үүднээс эдгээр нэр томъёог тодорхойлж, хууль хэрэглэх тухай зүйлд энэ талаар тусгасан.

“Талуудын хооронд тогтсон практик” гэдгийг тухайн хэлцлийн талуудын хувьд л үйлчлэх онцлог дадлыг ойлгохоор тогтоосон бөгөөд үүнийг талууд урьдчилан харилцан тохиролцож, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад харилцан хүлээн зөвшөөрч тогтоох боломжтой бөгөөд шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ түүнийг нэн түрүүнд харгалзан үзнэ. Харин “арилжааны заншил” гэж зөвхөн хэлцлийн тэрхүү талуудын хувьд бус арай өргөн хүрээнд үйлчлэх, талуудын мэдэж байсан, эсхүл мэдэх ёстой байсан, тийм төрлийн гэрээ байгуулж байгаа этгээдүүдийн нийтээр хүлээн зөвшөөрч тогтмол мөрддөг тэрхүү дадлыг ойлгох тул үүнийг талууд өөрсдөө хүсэл зоригоороо тогтоох боломжгүй байна. Иймд арилжааны заншлыг талууд хэрэглэхгүйгээр тохиролцох боломжийг хуулийн төслөөр олгосон нь Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцод нийцнэ.¹¹ Мөн талуудын хооронд тогтсон практик, арилжааны заншлаас гадна гэрээний эрх чөлөөт байдлыг хангах үүднээс талууд харилцан тохиролцсон тохиолдолд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ, олон улсын худалдааны практикт хүлээн зөвшөөрсөн загвар гэрээ, түүний тогтсон тайлбарыг харгалзан үзэх боломжтой байхаар заасан.

Гэхдээ хуулиас бусад буюу дээрх хэм хэмжээнүүдийн агуулга нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээ, нийтээр зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцэж байгаа тохиолдолд л түүнийг шүүх хэрэглэнэ.

Түүнчлэн, өмчийн хэлбэрийг үл харгалзан Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ашгийн төлөө хуулийн этгээдэд энэ хууль үйлчилэхээр тусгасан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн дагуу гэрээг байгуулах хүртэлх харилцааг захиргааны эрх зүйн харилцаа гэж үзээд түүнээс хойшхи харилцааг хувийн эрх зүйн харилцаа гэж үзэж, арилжааны хуулийг хэрэглэж болохоор тусгасан.

Хоёрдугаар бүлэг. Арилжааны эрх зүйн харилцаанд оролцогч

Арилжааны эрх зүй нь хувийн эрх зүйн тусгайлсан салбар эрх зүй (sonderprivatrecht)-д хамаарах бөгөөд иргэний эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулдаг хэм хэмжээг өөртөө агуулна. Тиймдээ ч арилжааны эрх зүйн харилцааны оролцогч нь иргэний эрх зүйн харилцааны оролцогч нараас илүү тусгайлсан шинжтэй байна.

Тус арилжааны хуулийн төсөлд “арилжааны эрх зүйн харилцаанд оролцогч” нарыг хоёрдугаар бүлэгт төрөлжүүлэн зохицуулсан бөгөөд ингэхдээ өмнө дурдсаны дагуу субъектив шалгуурыг баримталсан болно. Хуулийн төсөлд арилжааны эрх зүйн харилцаанд оролцогч нарыг ерөнхийд нь 1/ арилжаа эрхлэгч (хуулийн төсөлд заасан

¹¹ Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 9 дүгээр зүйлийн (2) дахь хэсэг. 1980 он.

арилжаа эрхлэгчийн шинжийг бүхэлд нь хангасан этгээд), 2/ арилжааны бүртгэлд сайн дурын үндсэн дээр бүртгүүлснээр хувиараа арилжаа эрхлэгч болох этгээд, 3/ эрх зүйн хэлбэрийн хувьд арилжаа эрхлэгч хуулийн этгээд болох этгээд гэсэн үндсэн гурван төрөлд ангилан зохицуулсан.

Арилжааны эрх зүйн харилцаанд оролцогч нарт холбогдох зохицуулалтыг системчлэн тайлбарлавал:

1.Арилжаа эрхлэгч (хуулийн төсөлд заасан арилжаа эрхлэгчийн шинжийг бүхэлд нь хангасан этгээд):

Хуулийн төслийн 4.1-д арилжаа эрхлэгч гэдэг нь арилжааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс¹² эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд байна гэж зохицуулсан. Иймд арилжаа эрхлэгчийг тодорхойлохын тулд “арилжааны үйл ажиллагаа” гэх ойлголтыг тайлбарлах шаардлагатай гэсэн үг.

Хуулийн төслийн 4.2-т “Арилжааны үйл ажиллагаа нь ашиг олох зорилгоор байнга эрхлэх, бие даасан, гадагш чиглэсэн, хуулиар хориглоогүй аж ахуйн аливаа үйл ажиллагаа байна.” гэж зохицуулсан ба тус хэсэгт арилжааны үйл ажиллагаа гэх ойлголтын үндсэн шинжийг зааж өгсөн. Тус үндсэн шинжийг хангасан субъект нь арилжаа эрхлэгч байна гэсэн үг. Үндсэн шинж тус бүрийг дор тайлбарлавал:

- *ашиг олох зорилготой байх*

Энэхүү шинжид тухайн арилжаа эрхлэгч бодит байдал дээр ашиг олсон эсэх нь хамааралгүй. Зорилго гэж тодотгосон байгаа тул ашиг олох үндсэн зорилготой байхыг л шаардана. Ашиг олох зорилго гэдэг нь алдагдлаа хамгийн бага хэмжээнд байлгаж, ашгаа хамгийн их байлгахыг зорьж үйл ажиллагаагаа явуулахыг ойлгоно. Өөрөөр хэлбэл ашиг, алдагдал хоёрын зөрүүнээс эерэг үлдэгдэл буюу ашиг нь илүү давамгайл байх нөхцөл байдлыг өөрийн үйл ажиллагаандаа бий болгохыг зорих явдал болно.

- *байнга эрхлэх*

Энэ нь нэг удаагийн шинжтэй буюу санамсаргүй, тохиолдлын шинжтэй аливаа үйлдлийг арилжааны үйл ажиллагаа байх боломжгүйг илтгэсэн шинж болно. Өөрөөр хэлбэл, тухайн үйл ажиллагаа нь үргэлжилсэн байдлаар, дахин давтагдах шинжтэй байх шаардлагатай бөгөөд арилжаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааг төлөвлөж, тодорхой, эсхүл тодорхой бус хугацаанд үргэлжлүүлэх зорилготой байх нь чухал. Гэвч “байнга” гэх үгийг дундаа ямар ч тасалдалгүй байхыг шаардаж байна гэж ойлгохгүй. Энэ нь хэт өрөөсгөл ойлголт болно. Жишээ нь зөвхөн наадмын өдрүүдэд үйл ажиллагаа явуулдаг, эсхүл улирлын шинжтэй арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг байж болно. Эдгээр тохиолдолд ч гэсэн байнга эрхлэх гэсэн үндсэн шинжийг хангаж байсан гэж тайлбарлах нь зохистой.

- *бие даасан*

¹² Тус 4.1 дэх хэсэгт заасан “өөрийн нэрийн өмнөөс” гэх нөхцөл нь өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аливаа эрх, үүргийг өөрөө хариуцна гэсэн агуулгыг илтгэнэ.

Арилжаа эрхлэгчийг бие даасан байхыг шаарддаг. Энэ нь нэг үгээр хэлбэл “өөрөө өөртөө ажил олгогч” байна гэсэн үг. Харин хэн нэгний удирдлага, зааварчилгааны дор, түүнээс цалин хөлс авч ажиллаж байгаа нь бие даасан гэх уг шинжийг үгүйсгэнэ. Хөдөлмөрийн гэрээ (зарим тохиолдолд хөлсөөр ажиллах гэрээ)-ний дагуу буюу хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд суурилсан үйл ажиллагаа нь бие даасан бус байна гэсэн үг. Гэвч уг бие даасан гэх шинж нь эдийн засгийн хувьд бусдаас хараат байх явдлыг хамрахгүй. Хуулийн төслийн 15.1-д заасан зохицуулалтын агуулгаас бие даасан байх шинжийн зарим нэг агуулгыг харж болно.

- *гадагшаа чиглэсэн*

Энэ нь зөвхөн тодорхой нэг хүрээллийн дунд буюу гэр бүл, хамт олон, гишүүдийн гэх мэт хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулах тохиолдлыг арилжааны үйл ажиллагааны үндсэн шинж биш болохыг илтгэнэ. Өөрөөр хэлбэл арилжааны үйл ажиллагаа нь зах зээлд чиглэсэн байх шаардлагатай. Зах зээл дээрээс хэн ч тухайн үйл ажиллагааг хүлээн авах боломжтой байх нь тус шинжийн гол агуулга болно.

- *хуулиар хориглоогүй*

Хуулиар явуулахыг хориглосон аливаа үйл ажиллагаа нь арилжааны үйл ажиллагаанд хамаарах боломжгүй. Зөвхөн хуулиар хориглоогүй байх шинжийг хангаж байж л арилжааны үйл ажиллагаанд хамаарна.

- *аж ахуйн аливаа үйл ажиллагаа*

Энэ нөхцөл нь арилжааны үйл ажиллагааг тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэхгүй. Харин арилжааны үйл ажиллагаа болон аж ахуйн үйл ажиллагаа гэх хоёр ойлголтын харилцан хамаарлыг тодотгосон нөхцөл болно. Аж ахуйн үйл ажиллагаа гэдэг нь ашгийн төлөө төдийгүй ашгийн бус аливаа зорилготой хуулийн этгээд болон хувь хүний үйл ажиллагааг ойлгох тул аж ахуйн үйл ажиллагаа нь арилжааны үйл ажиллагааг өөртөө багтаасан илүү өргөн хүрээтэй ойлголт болно.

2.Арилжааны бүртгэлд сайн дурын үндсэн дээр бүртгүүлснээр хувиараа арилжаа эрхлэгч болох этгээд:

Хуулийн төслийн 5.1-д зохицуулснаар 4.2-т заасан шинжийг хангаагүй үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн нь хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд сайн дурын үндсэн дээр бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болох бүрэн боломжтой.

Үүний сацуу хуулийн төслийн 4.8-д заасны дагуу Мал аж ахуй, газар тариалан, хүлэмжийн аж ахуй зэрэг хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйн буюу анхдагч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа хувь хүн болон хуулийн төслийн 5.4-т заасан жижиг арилжаа эрхлэгч нь мөн адил өмнө дурдсаны дагуу хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд сайн дурын үндсэн дээр бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болох боломжтой юм.

Сайн дурын үндсэн дээр арилжаа эрхлэгч болох боломжтой этгээдүүдийн хувьд арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэг хүлээхгүй боловч нэгэнт бүртгүүлсэн бол

өөрийгөө арилжаа эрхлэгч биш, эсхүл эрхлэн явуулдаг үйл ажиллагаагаа арилжааны үйл ажиллагаанд хамаарахгүй гэж маргах эрхгүй.

Энэ төрөлд хамаарах этгээдүүдийн хувьд арилжааны бүртгэл нь конститутив эрх зүйн үр дагавартай байна. Учир нь бүртгэл хийгдсэнээс хойш л арилжаа эрхлэгч гэсэн статустай болно. Мөн арилжааны бүртгэлд нэгэнт бүртгэгдсэний дараа өмнө дурдсан арилжаа эрхлэгчтэй ижил эрх, үүрэг, хариуцлагыг хүлээх юм.

3.Эрх зүйн хэлбэрийн хувьд арилжаа эрхлэгч хуулийн этгээд болох этгээд:

Хуулийн төслийн 4.3-т ямар эрх зүйн хэлбэртэй хуулийн этгээд нь арилжаа эрхлэгч болох тухай зохицуулсан. Иймд зөвхөн 4.3-т заасан буюу нөхөрлөл, хоршоо компанийн хэлбэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, байгуулагдсан хуулийн этгээд нь арилжаа эрхлэгчид хамаарна. Бусад эрх зүйн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн хувьд энэ хууль үйлчлэхгүй.

Хоршооны тухайд манай улсад хоршоог Иргэний хуулиар ашгийн төлөө бус хуулийн этгээдийн ангилалд хамруулдаг хэдий ч бусад улс оронд ашгийн болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аль алинд хамаарахгүй дундын хуулийн этгээд гэж үздэг. Хоршоог худалдаа эрхлэгч гэж үзэх, түүний хийж буй хэлцлийг худалдааны хэлцэл гэж үзэх эсэх нь хуулийн тайлбар, тухайн орны онцлогоос хамааралтай байдаг бөгөөд манай орны хувьд худалдаа эрхлэгч гэж үзэхгүй байх шалтгаан төдийлөн ажиглагдахгүй байх тул хоршоог худалдаа эрхлэгч гэж үзэх нь хууль хэрэглээг хялбарчлах, эрх зүйн харилцааг тодорхой болгох давуу талтай гэж үзсэн.¹³ Үүнтэй уялдуулан Иргэний хуульд мөн өөрчлөлт оруулсан.

Арилжаа эрхлэгчийн хүлээх хариуцлагын хувьд компани нь Компанийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу эзэмшиж байгаа бүх эд хөрөнгөөрөө, нөхөрлөл нь Нөхөрлөлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч тус хуулийн 19.1, 27.1, 29.1-д тус тус заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Мөн хоршоо нь Хоршооны тухай хуулийн 13.1-д зааснаар үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг хоршооны эд хөрөнгөөр хариуцна. Харин хувиараа арилжаа эрхлэгч нь хуулийн этгээд бус хувь хүний хувиар арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа тул түүний хариуцлагыг хязгаарлах боломжгүй буюу хариуцлагыг тухайн хувь хүн өөрийн бүх хөрөнгөөр бүрэн хариуцаж барагдуулна.

Гуравдугаар бүлэг.Арилжааны бүртгэл

Арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаа нь гадагш чиглэсэн (зах зээл, хэрэглэгч рүү чиглэсэн) үндсэн шинжтэй бөгөөд арилжааны үйл ажиллагаа буюу арилжаа эрхлэгчийн байгуулж буй гэрээ хэлцлийг баталгаатай, түргэн шуурхай явуулахын тулд арилжаа эрхлэгчийн зарим мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод байлгах шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, арилжаа эрхлэгчтэй гэрээний харилцаанд орж буй иргэдийн хувьд гэрээ хэлцэл байгуулахад шаардлагатай мэдээллийг (арилжаа эрхлэгчийн үндсэн үйл ажиллагааны төрөл, үйл ажиллагаа явуулах газар, төлөөлөх бүрэн эрх зэрэг) мэдэж байх нь гэрээний баталгаат байдлыг

¹³Гадаад орнуудын арилжаа/худалдаа/-ны тухай хуулиудын харьцуулсан судалгаа. Судлаач Н.Норовсамбуу, Г.Давааням, Ж.Содномдаржаа. 2019 он.

хангах нэг нөхцөл юм. Үүнээс арилжааны бүртгэлийн тогтолцооны хэрэгцээ шаардлага, ач холбогдол нь урган гарч байдаг.

Хуулийн төсөлд арилжааны бүртгэлийг:

-Ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэл буюу компани, хоршоо, нөхөрлөлийн бүртгэл;

-Хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэхээр тусгаж өгсөн.

Ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэлийг одоогоор Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулж, ашгийн төлөө хуулийн этгээдийн бүртгэлийг хөтөлж байгаа. Харин арилжаа эрхлэгч хувь хүний бүртгэлийг Монгол Улсад одоогоор хийдэггүй тул үүнийг шинээр бий болгох шаардлагатай болно. Тэгэхээр Монгол Улсад арилжааны бүртгэлийн зарим хэсэг (нөхөрлөл, хоршоо, компанийн бүртгэл) нь хийгддэг, тогтсон зохион байгуулалтад орсон тул түүнийг аль болох өөрчлөхгүйгээр арилжааны бүртгэлийг зохион байгуулах нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд болон төрийн байгууллагад төвөг чирэгдэл багатай байна гэж үзэн арилжааны бүртгэлийг хувь хүн, хуулийн этгээдийн аль нь болохоос хамаарч өөр байгууллагууд тус тусын хуулийн дагуу бүртгэхээр зохицуулсан. Өөрөөр хэлбэл, арилжааны бүртгэлийн ажиллагааг нэгдсэн нэг байгууллага хариуцахгүй.

Арилжааны бүртгэлд бүртгэгдсэн мэдээллийг олон нийтэд нээлттэй байх, эсхүл хаалттай байх мэдээлэл гэж ангилна. Мэдээллийн ангиллыг Арилжааны хуулиар бус улсын бүртгэлийн хууль, шаардлагатай бол дүрэмд дэлгэрүүлэн тусгах нь зохимжтой тул энэ хуулийн төслийг дагалдуулан боловсруулж байгаа Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн төсөлд хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны бүртгэлийн талаар зохицуулсан.

Арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь ашгийн төлөө хуулийн этгээд буюу компани, хоршоо, нөхөрлөл байх бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлсэн цагаас эхлэн арилжаа эрхлэгч болох тул бүртгэл нь конститутив шинжтэй. Харин хувиараа арилжаа эрхлэгчийн хувьд бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй байсан ч тухайн бизнес эрхлэгчийн үйл ажиллагаа нь арилжааны үйл ажиллагааны шинжийг хангасан бол тэр үеэс арилжаа эрхлэгч болно. Иймд хувиараа арилжаа эрхлэгчийн хувьд бүртгэл нь декларатив шинжтэй байна. Ингэж зохицуулахын үр дагавар нь арилжааны бүртгэлд бүртгүүлээгүй байсан хувиараа арилжаа эрхлэгч шүүхээр аливаа маргаан шийдвэрлүүлэх болоход шүүх Арилжааны хуулийг хэрэглэх эсэхтэй холбогдон гарах юм.

Арилжааны хуулийн төсөл батлагдсанаар үүсэх гол үр дагаврын нэг нь арилжаа эрхлэгчийн улсын бүртгэлд бүртгэлтэй мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож байгаа явдал юм. Ингэснээр гэрээ байгуулахаар сонирхож байгаа иргэн, хуулийн этгээдийн бүртгэл дэх (тухайн цаг мөчийн байдлаарх хамгийн үнэн зөв гэдэг нь баталгаатай) мэдээллийг үзэх, харьцуулах, эрсдэлээ тооцоолох боломжтой болно. Гэрээ, хэлцэл нь талууд бие биенийгээ хүлээсэн үүргээ гүйцэтгэнэ гэсэн итгэлд суурилдаг тул арилжааны бүртгэлийг бий болгосноор гэрээний нөгөө талдаа итгэж

болохуйц эсэхийг урьдчилан тооцоолох боломжийг арилжаа эрхлэгчид болон иргэдэд олгож, тэдний үйл ажиллагаанд тусалж байгаа юм.

Иймд дээрх зорилго, ач холбогдолтой холбоотойгоор арилжааны бүртгэл дэх мэдээлэл байнга шинэчлэгдэж, итгэж болохуйц, үнэн зөв байх шаардлагатай тул хэрэв арилжааны бүртгэл дэх мэдээлэл хуучирсан, өөрчлөгдсөн бол зохих өөрчлөлтийг тухай бүр оруулахыг арилжаа эрхлэгчид даалгасан. Энэ үүргийг биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг буруутай арилжаа эрхлэгч хариуцах буюу бүртгэлд байгаа мэдээллийг зөрүүтэй гэдгийг гуравдагч этгээд мэдээгүй тохиолдолд түүний хувьд тухайн бүртгэлтэй мэдээлэл үнэн зөв гэж тооцох байдлаар гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах үр дагавартай байхаар зохицуулсан. Иймд хуулийг хэрэгжүүлэхдээ бүртгэлд оруулах өөрчлөлтийг зайнаас буюу иргэн, хуулийн этгээдэд аль болох хүндрэл чирэгдэл багатай байхаар зохион байгуулах нь өндөр ач холбогдолтой болно.

Дөрөвдүгээр бүлэг. Арилжааны нэр

“Арилжааны нэр” гэх ойлголтыг өмнө нь манай улсын хувьд хуульчилж байгаагүй бөгөөд шинэ нэр томъёо гэж үзэж болно. Арилжааны нэр гэдэг нь арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаандаа ашиглах нэр тул үсгээр илэрхийлэгдсэн байх шаардлагатай бөгөөд зургаар, тэмдэгтээр, эсхүл зураг болон тэмдэгттэй нийлсэн үг, үсэг байж болохгүй. Түүнчлэн хувиараа арилжаа эрхлэгч болон арилжаа эрхлэгч компани биш л бол тэдгээрийн үйл ажиллагаандаа хэрэглэж буй нэрийг арилжааны нэр гэж тооцохгүй. Тухайлбал, холбоо, сан зэрэг төрийн бус байгууллага, төрийн байгууллага, албан газар нь ашгийн төлөө бус хуулийн этгээд болох бөгөөд арилжаа эрхлэгчид хамаарахгүй тул эдгээр хуулийн этгээдийн нэр нь арилжааны нэрэнд хамаарахгүй юм. Мөн хувь хүний овог, нэр нь өөрийгөө бусдаас ялгах, хүн болж төрснийхөө хувьд өөрийгөө илэрхийлэх нэг илэрхийлэл тул амины эрх гэж үздэг тул өөрийн овог, нэрээ бусдад шилжүүлэх боломжгүй байдаг. Харин хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор өөрийн овог, нэрээ арилжааны нэрээр сонгож, арилжааны бүртгэлд бүртгүүлэх эрх нь нээлттэй юм (Хуулийн төслийн 8.2).

Арилжааны нэр нь дээр дурдсанчлан зөвхөн үсгээр илэрхийлэгдэх бол барааны тэмдэгт нь үсгээс гадна, зураг, тэмдэгт, өнгө, үнэр, дуу чимээ зэргийг хослуулах байдлаар хүний мэдрэхүйн тусламжтайгаар бусдаас ялгагдах шинжийг өөртөө агуулж байдгаараа арилжааны нэрээс ялгаатай. Түүнчлэн арилжааны нэрийг хувиараа арилжаа эрхлэгч болон ашгийн төлөөх хуулийн этгээд болох компани, хоршоо, нөхөрлөл л ашиглах эрхтэй бол барааны тэмдэгт нь бараа, ажил үйлчилгээний нэр байдгаараа, барааны тэмдгийн ангилал нь өөр бол ойролцоо байж болдгоороо мөн ялгагдана.

Хувиараа арилжаа эрхлэгч болон арилжаа эрхлэгч ашгийн төлөөх хуулийн этгээд нь арилжааны нэрээ чөлөөтэй сонгох эрхтэй (Арилжааны нэрээ чөлөөтэй сонгох зарчим). Энэ эрхийн хүрээнд арилжааны нэр нь арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаатай шууд хамааралтай байхыг шаардахгүй гэсэн үг. Гэхдээ, арилжааны нэрээ чөлөөтэй сонгох зарчимд тодорхой хязгаарлалтууд байдаг. Тухайлбал ашгийн төлөөх хуулийн этгээдийн зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч, арилжааны нэрний араас ХХК, ХК, ХХН, ББН, ЗБН гэх зэрэг хариуцлагын хэлбэрийг заасан ялгах товчлол, мөн санхүүгийн салбарын зохицуулалттай хуулийн этгээд болох банк,

даатгалын компаниуд л арилжааны нэрийн араас банк, даатгал гэсэн үгийг хэрэглэхийг хуульчилж өгсөн байдаг. Түүнчлэн аливаа этгээд бусад арилжаа эрхлэгчийн арилжааны нэртэй ижил, төстэй болон төөрөгдүүлэхүйц арилжааны нэрийг сонгох, ашиглах нь хориотой байна (Хуулийн төслийн 9.1).

Арилжааны нэр буюу энгийнээр хэлбэл бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаандаа ашигладаг оноосон нэр нь тухайн бизнесийн ашиг орлого, нэр хүндийг тодорхойлж байдаг тул бизнес эрхлэгч үйл ажиллагаагаа энэ нэрээр олон нийтэд зөвөөр таниулан сурталчлах, зах зээлд нэр хүнд олж авахын тулд ихээхэн хэмжээний цаг хугацаа, хөрөнгө, хөдөлмөр зарцуулж, ур чадвараа зориулсан байдаг тул арилжааны нэрийг бизнест нэг төрлийн хөрөнгө гэж үздэг. Иймд бусдын арилжааны нэрийг болон түүнтэй ижил төсөөтэй нэрийг шударга бус зорилгоор (тухайлбал, бусдын олон нийтэд танигдсан арилжааны нэрийг нь ашиглах, хэрэглэгчийг төөрөгдүүлэх замаар бусдын олох байсан ашиг орлогыг олох, арилжааны нэрний нэр хүндийг унагаах гэх мэт) ашиглах нь тухайн арилжааны үйл ажиллагааг бий болгож, арилжаа эрхэлж байгаа этгээдэд болон түүний хэрэглэгчдэд хор хохиролтой тул шударга өрсөлдөөн, шударгаар итгэсэн итгэл болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс арилжааны нэрийг шударга бусаар ашигласан тохиолдолд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тугаж өгсөн (Хуулийн төслийн 9.2).

Компани, нөхөрлөл, хоршооний хувьд тухайн хуулийн этгээдийн оноосон нэр нь түүний арилжааны нэр болох бол хувиараа арилжаа эрхлэгчийн хувьд заавал арилжааны нэртэй байхыг шаардахгүй бөгөөд арилжааны нэр хэрэглэхийг болон хэрэглэж байгаа арилжааны нэрээ бүртгүүлэх үүргийг хуулийн төслөөр хүлээлгээгүй (Хуулийн төслийн 8.2, 8.3). Харин хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны нэр шударга өрсөлдөөн, хэрэглэгчийг хамгаалах, бизнесийн тогтвортой, ёс зүйтэй үйл ажиллагааг дэмжих зорилгын үүднээс бусад арилжаа эрхлэгчийн арилжааны нэр болон бусад хуулийн этгээдийн нэртэй давхардахгүй байх шаардлагатай тул энэхүү өөрчлөлтийг тусгах үүднээс Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 13.7-д заасан Засгийн газраас баталдаг хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журмыг шинэчлэн батлах шаардлагатай болно.

Арилжааны нэрийг дээр дурдсанчлан нэг төрлийн хөрөнгө гэж үзэж байгаа тул үүнийг арилжаа эрхлэгч бусдад тодорхой хугацаа, нөхцөлтэйгээр ашиглуулж, шилжүүлж, өв залгамжлуулах боломжтой болно (Хуулийн төслийн 10.1). Арилжаа эрхлэгч арилжааны нэртэй холбоотой эдгээр эрхээ хэрэгжүүлэхийн тулд арилжааны бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагыг хуулийн төсөлд тусгасан (Хуулийн төслийн 10.2). Учир нь тухайн арилжааны нэрээр явуулсан арилжааны үйл ажиллагаанаас үүсэх эрх зүйн үр дагаврыг хариуцах тул гуравдагч этгээдийн эрх ашгийг хамгаалах үүднээс бүртгүүлсний үндсэн дээр арилжааны нэрээ бусдад ашиглуулах, шилжүүлэх, өв залгамжлуулах шаардлагыг тусгасан болно.

Хуулийн төслөөр зөвхөн хувиараа арилжаа эрхлэгчид арилжааны нэрээ бүртгүүлсэн бол бусдад ашиглуулах, шилжүүлэх, өв залгамжлуулах боломжтой байдлаар зохицуулж өгсөн.

Арилжааны нэрээ бусдад шилжүүлэх тохиолдолд хуулийн төслөөр 2 урьдчилсан нөхцөлийн аль нэгийг хангасан байхаар зохицуулсан. Нэгдүгээрт, арилжааны нэрээ тухайн арилжааны үйл ажиллагаатай хамтад нь шилжүүлэх. Хоёрдугаарт, тухайн

арилжаа эрхлэгч арилжааны үйл ажиллагаагаа зогсоосны үндсэн дээр зөвхөн арилжааны нэрээ шилжүүлэх юм. Эхний тохиолдлын хувьд, арилжааны нэрийг хэрэглэгч танихдаа тухайн үйл ажиллагаа нь гэж бодож үйлчлүүлэх тул арилжааны нэрийг арилжааны үйл ажиллагаанаас нь салгах боломжгүй ба хэрэглэгчийг төөрөгдөлд оруулахгүйн тулд арилжааны нэр болон арилжааны үйл ажиллагааг хамтад нь шилжүүлэх шаардлагатай болдог. Хоёрдугаарт, арилжааны нэрийг шилжүүлэн авч буй этгээд тухайн арилжааны нэрийг ашиглаж ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилготой байтал арилжаа нэрээ шилжүүлж буй этгээд арилжааны үйл ажиллагаагаа зогсоолгүй үргэлжлүүлэн өрсөлдөх үйл ажиллагаагаа явуулах нь арилжааны нэр шилжүүлж авч буй талд ашиггүй, мөн хэрэглэгчийг төөрөгдүүлэх тул арилжааны үйл ажиллагаагаа зогсоосны үндсэн дээр шилжүүлэх шаарлага тавигддаг. Иймд арилжааны нэрийг бусдад төлбөртэй болон төлбөргүйгээр шилжүүлж байгаа, өв залгамжлуулж байгаа тохиолдолд арилжааны үйл ажиллагаатай нь хамт, эсхүл нэрээ шилжүүлсэн хэрнээ өөрөө тухайн үйл ажиллагаагаа эрхэлж өрсөлдөх, хэрэглэгчээ хуваах нь зохисгүй тул өөрөө үйл ажиллагаагаа зогсоосны үндсэн дээр шилжүүлэхээр заасан (Хуулийн төслийн 10.5). Үүнтэй холбоотойгоор арилжааны нэрээ шилжүүлсэн этгээд нэр шилжүүлэн авсан этгээдтэй ижил байршилд 1 жилийн хугацаатай ижил төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглож, үл өрсөлдөх үүргийг тусгаж өгсөн. (Хуулийн төслийн 10.6)

Арилжааны нэрийг бусдад ашиглуулж байгаа этгээд нь тухайн арилжааны нэрийг бусдад ашиглуулснаас үүссэн эрх зүйн үр дагаврыг хамтран хариуцахаар хуулийн төсөлд тусгасан (Хуулийн төслийн 10.4). Учир нь тухайн арилжааны нэрийг сонгож, шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах, гуравдагч этгээд болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах үүднээс хамтран хариуцлага хүлээх нь зохимжтой. Харин арилжааны нэрийг арилжааны үйл ажиллагаатай хамтад нь шилжүүлэн авсан этгээд тухайн арилжааны нэрийг үргэлжлүүлэн ашиглах тохиолдолд тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлж авахаас өмнө үүссэн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээх бөгөөд арилжааны үйл ажиллагааг шилжүүлж авахаас өмнө үүссэн үүргийг хариуцахгүй талаар арилжааны бүртгэлд бүртгүүлсэн тохиолдолд л үүргээс чөлөөлөгдөж болох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан (Хуулийн төслийн 10.7, 10.8).

Тавдугаар бүлэг. Арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх

Иргэний хуульд “төлөөлөл” гэх ерөнхий бүлгийн нэрийн дор “хэлцэлд төлөөлөл” гэх ойлголтыг ашигласан. Тиймдээ ч Иргэний хуулийн 62-70 дугаар зүйлийн зохицуулалт нь хэлцэлд төлөөлөл тохиолдлыг ерөнхийд нь зохицуулсан гэж үзэж болно.

Харин арилжааны хуулийн төслийн хүрээнд өмнө дурдсанчлан ХБНГУ-ын Арилжааны хуулийг голчлон эх сурвалж болгон ашигласан бөгөөд энэхүү тавдугаар бүлгийн хүрээнд ХБНГУ-ын Арилжааны хуулийн 54 дүгээр зүйлээр зохицуулсан Handlungsvollmacht буюу шууд орчуулвал үйлдэлд төлөөлөл бүрэн эрх (хэлцлийн үндсэн дээр олгосон бүрэн эрх) гэх ойлголтод суурилан энэ бүлгийн зохицуулалтыг боловсруулсан болно.

Иймд хуулийн төсөлд заасны дагуу хэлцэлд төлөөлөлөөс гадна тухайн төлөөлөл бүрэн эрх нь “хууль ёсны үйлдэл”-ийн хувьд нэгэн адил үйлчилнэ. Тус “хууль ёсны үйлдэл” гэх нэр томъёогоор дамжуулан Rechtshandlung, erlaubte Rechtshandlung буюу

дотроо хэлцэлтэй төстэй үйлдэл болон бодит актыг багтаасан ерөнхий ойлголтыг хуулийн төсөлд тусгахыг зорьсон болно. Арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх гэж бүлгийн гарчгийг оноосон нь ч тус агуулгатай холбогдоно.

Арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх нь төсөлд тусгагдсанаар дараах гурван төрөлд хуваагдана. Үүнд:

Ерөнхий төлөөлөх бүрэн эрх: Хуулийн төслийн 14.2-т заасан агуулгад үндэслэнэ. Өөрийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг бусдад олгохыг ерөнхий төлөөлөх бүрэн эрх гэж тодорхойлох боломжтой бөгөөд тус бүрэн эрхийг зөвхөн хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь олгох боломжтой. Гол онцлог нь тухайн хувиараа арилжаа эрхлэгчийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л хэлцэл, хууль ёсны үйлдлийг төлөөлөн хийх бүрэн эрхийг олгох явдал бөгөөд энэхүү бүрэн эрхийг зөвхөн иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээдэд олгоно. Түүнчлэн хуулийн төслийн 14.5-д заасны дагуу хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь тухайн ерөнхий төлөөлөх бүрэн эрхийг бусдад олгосон, эсхүл дуусгавар болгосон бол энэ талаар арилжааны бүртгэлд тухай бүр бүртгүүлэх үүрэгтэй байна. Гэхдээ тус бүртгэл нь конститутив үр дагаваргүй буюу декларатив үр дагавартай байна.

Тодорхой төрлийн хэлцэл, үйлдэлд төлөөлөх бүрэн эрх: Хуулийн төслийн 11.1-д “Арилжаа эрхлэгчийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой төрлийн арилжааны хэлцэл болон хууль ёсны үйлдэл” гэж тусгасан байгаа нь тус төлөөлөх бүрэн эрхийг олгож болохыг илэрхийлсэн болно. Тодорхой нэг хэлцэл буюу Б-тэй 2023 оны 01 сарын 01-ний өдөр байгуулах автомашин худалдах, худалдан авах гэрээг бус тодорхой төрлийн арилжааны хэлцэл болон хууль ёсны үйлдлийг төлөөлөн хийх боломжийг олгоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, тус арилжаа эрхлэгчийн хийх бүхий л автомашин худалдах, худалдан авах гэрээг байгуулах бүрэн эрхийг олгож байгаа нь тус төлөөлөх бүрэн эрхийг олгосон тохиолдолд хамаарна.

Тодорхой хэлцэл, үйлдэлд төлөөлөх бүрэн эрх: Хуулийн төслийн 11.1-д “мөн тухайн арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хийх бүрэн эрхийг” гэж тусгасан байгаа нь тус төлөөлөх бүрэн эрхийг олгохыг хүлээн зөвшөөрсөн зохицуулалт болно. Өмнө дурдсанчлан тус бүрэн эрх зөвхөн тодорхой хэлцэл, үйлдэлд л үйлчилнэ. Тийм ч учраас логикийн дагуу тус бүрэн эрх нь тухайн тодорхой хэлцлийг байгуулж, үйлдлийг хийж гүйцэтгэснээр дуусгавар болно.

Хуулийн төслийн 11.5-д заасан ажилтны төлөөлөх бүрэн эрх нь зөвхөн 11.1-д заасан төлөөлөх бүрэн эрхийг олгох тохиолдолд итгэмжлэлтэй эсэхээс үл хамааран үүсэх боломжтой. Харин 11.2-т заасан бүрэн эрхийн хувьд ямар ч тохилдолд заавал бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр олгож, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэг хүлээнэ. 11.8-д заасан хязгаарлалтын хувьд 11.5-д заасны дагуу итгэмжлэлгүйгээр бүрэн эрх нь үүссэн ажилтны хувьд ч нэгэн адил үйлчлэх бөгөөд энэ тохиолдолд ажилтанд тухайн хязгаарлалтад заасан хэлцэл болон үйлдэлд төлөөлөх бүрэн эрхийг олгосон итгэмжлэлийг бичгээр олгосон тохиолдолд л хуулийн төслийн 11.8 дахь хэсэг үйлчлэхгүй гэж ойлгоно.

Зургадугаар бүлэг. Арилжаа эрхлэгчийн ажилтан

Энэ бүлэгт арилжааны эрхлэгчийн ажилтны талаар зохицуулсан бөгөөд манай улсын хувьд тодорхой аж ахуйн нэгжид ажиллаж байсан этгээд тухайн аж ахуйн нэгжээс гарч, адил төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн ажилтан болсон тохиолдолд эсхүл өөрөө тийм төрлийн аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг байгуулсан бол өөрийн өмнө ажиллаж байсан аж ахуйн нэгжтэй өрсөлдөхгүй байх үүргийг ногдуулсан хуулийн зохицуулалт дутмаг байдаг. Ажилтны оролцож байгаа эдийн засгийн харилцаанд бий болох эрсдэлийг ажил олгогч буюу арилжаа эрхлэгч хүлээдэг онцлогтой бөгөөд арилжаа эрхлэгч нь бусдыг авч ажиллуулах тохиолдолд арилжаа эрхлэгчийн ашиг сонирхолыг хамгаалах үүднээс хуулийн төслийн 13 дугаар зүйлд “өрсөлдөхгүй байх үүрэг” хүлээлгэсэн гэрээг байгуулж болохоор тусгасан. Нөгөөтэйшүүр ажилтны эрх ашгийг хамгаалах, үндсэн эрхийг хөндөхгүй байх хүрээнд төслийн 14 дүгээр зүйлд үл өрсөлдөх үүрэг хүлээлгэсэн гэрээ хүчин төгөлдөр бус байх нөхцөлийг тусгалаа.

Долдугаар бүлэг.Арилжааны төлөөлөгч

ХБНГУ-ын хувьд *Hilfspersonen des Kaufmanns* гэх ойлголтын хүрээнд арилжааны төлөөлөгч болон арилжааны зуучлагчийг хамруулан үзэх нь нийтлэг юм. Өөрөөр хэлбэл, арилжаа эрхлэгч нь өөрийн гэсэн дэлгүүр нээж, ажилтныг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахын оронд үйл ажиллагаагаа тэлэхийн тулд арилжааны төлөөлөгч, эсхүл арилжааны зуучлагчийг ашиглах нь санхүүгийн хувьд илүү хэмнэлттэй байхыг үгүйсгэхгүй юм. Нөгөөтэйгүүр, арилжааны төлөөлөгч болон арилжааны зуучлагчийн аль аль нь арилжаа эрхлэгчийн ажилтан бус этгээд байх буюу түүнээс бие даасан байдгаараа онцлогтой. Бусад туслах этгээдүүд (илгээгч, комисс)-тэй харьцуулахад арилжааны төлөөлөгч болон арилжааны зуучлагч нь үйлчлүүлэгчийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг онцлогтой (арилжааны зуучлагчийн хувьд төлөөлөх бүрэн эрх олгогдсон тохиолдолд төлөөлүүлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл хийх боломжтой болдог). Эдгээр шинжийг харгалзан үзэж хуулийн төслийн Нэгдүгээр хэсэг буюу Ерөнхий үндэслэлд арилжааны төлөөлөгч болон арилжааны зуучлагчийн талаар зохицуулсан болно.

Нэр томъёоны хувьд өмнө дурдсанчлан “арилжаа” гэх нэр томъёог ашиглах явдлыг зохистой гэж шийдвэрлэсэн тул Иргэний хуульд байгаа “худалдааны төлөөлөгч” гэх нэр томъёог “арилжааны төлөөлөгч” гэж өөрчилсөн.

Зохицуулалтын бүтцийн хувьд одоогийн Иргэний хуульд нэг дэд бүлэг худалдааны зуучлагч, комисс, худалдааны төлөөлөгчийн талаар зохицуулсан байх боловч энэ нь тус бүрийн онцлог нөхцөл байдлыг харгалзан үзэж тусгайлсан зохицуулалтыг бий болгох нөхцөл боломжийг хязгаарласан төдийгүй, зарим зохицуулалтыг аль тохиолдолд хамаатуулан хэрэглэхийг шийдвэрлэхэд эргэлзээтэй нөхцөл байдлыг бий болгож байна гэж үзсэн болно. Иймд төслийг боловсруулахдаа харьцуулан судлах эх сурвалж болгосон гадаад улс орны жишгийн дагуу тус бүрд нь бүлгээр зохицуулахаар шийдвэрлэсэн.

Одоогийн Иргэний хуулийн 415-419 дүгээр зүйлд худалдааны төлөөлөгчтэй холбоотой зохицуулалтыг 415 дугаар зүйл буюу Худалдааны төлөөлөгч, комисс, 416 дугаар зүйл буюу Хөлс, шагнал, шимтгэлийн хэмжээ, 417 дугаар зүйл буюу Худалдааны төлөөлөгч, комисстой байгуулах гэрээний хугацаа, 418 дугаар зүйл буюу Худалдааны төлөөлөгчид олгох нөхөн олговор, 419 дүгээр зүйл буюу Хариуцлага гэсэн

бүтэцтэйгээр хуульчилсан байна. Хуулийн төсөлд 15 дугаар зүйлд Арилжааны төлөөлөгч, 16 дугаар зүйлд Арилжааны төлөөлөгчийн үүрэг, 17 дугаар зүйлд Үйлчлүүлэгчийн үүрэг, 18 дугаар зүйлд Арилжааны төлөөлөгчийн хөлс, 19 дүгээр зүйлд Арилжааны төлөөлөгчтэй байгуулах гэрээний хугацаа, 20 дугаар зүйлд Арилжааны төлөөлөгчид олгох нөхөн олговор, 21 дүгээр зүйлд Арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүрэг гэсэн дарааллаар зохицуулалтын бүтцийг шинэчилсэн болно.

Юун түрүүнд арилжааны төлөөлөгчийн гэрээний үндсэн нөхцөл нөгөөтээгүүр арилжааны төлөөлөгчийн тодорхойлолт хэсгийг ХБНГУ-ын Арилжааны хуулийн 84 дүгээр зүйлд тулгуурлан шинэчилсэн. Арилжааны төлөөлөгчийн хамгийн гол шинж болох бие даасан байх явдлыг нэмсэн (хуулийн төслийн 15.1). Өмнө нь “бараа, эрх, үйлчилгээг борлуулахад” гэх байдлаар тусгасан байсан нь бүрэн бус, ойлгомжгүй байсан тул энэ нөхцлийг хасаж, хэлцэлд зуучлах, хэлцэл байгуулах гэх байдлаар ерөнхий агуулгыг нь тусгасан.

Мөн түүнчлэн жижиг арилжаа эрхлэгчийн хувьд ч тус зохицуулалт үйлчлэх талаар, үйлчлүүлэгчийн зөвшөөрөлтэйгээр өөр арилжааны төлөөлөгчийг ажиллуулж болох тухай, арилжааны төлөөлөгч нь өөрийгөө бие даан үйл ажиллагаа явуулж байгаа болохоо нотолж чадахгүй бол түүнийг үйлчилгээний ажилтантай адилтгаж үзэх тухай, хэлцэл байгуулахад төлөөлөх бүрэн эрх олгосон тохиолдолд арилжааны төлөөлөгчийн хувьд ч тус хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн зохицуулалт нэгэн адил үйлчлэх талаар тус тус шинэ зохицуулалтыг тусгасан. Ингэснээр арилжааны төлөөлөгчийн талаарх ерөнхий зохицуулалтыг илүү өргөн хүрээнд зохицуулж, одоогийн хуулийн зохицуулалттай харьцуулахад илүү тодорхой, ойлгомжтой болгохыг зорьсон болно.

Одоогийн Иргэний хуульд арилжааны төлөөлөгчийн үүргийн талаар зохицуулаагүй орхигдуулсан тул хуулийн төслийн 16 дугаар зүйлд арилжааны төлөөлөгчийн үүргийн талаарх зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийн 16.1.5-д Иргэний хуулийн 415.3 дахь хэсгийн хоёрдахь өгүүлбэрийг ашиглан комисстой холбоотой хэсгийг хасаж боловсруулсан. Харин 16.1.1-16.1.4 дэх хэсгүүдэд юун түрүүнд арилжааны төлөөлөгчийн гэрээ нь даалгаврын гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний тусгайлсан гэрээнд хамаардаг гол онцлогийг харгалзан үзсэн дараах зохицуулалтыг шинээр тусгасан. Үүнд:

“16.1.1.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй;

16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр нэн даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;

16.1.3.арилжааны төлөөлөгчийн хувьд ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажиллах.”

Мөн арилжааны эрх зүйн харилцаанд арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой нууц нь маш чухал хамгаалалтын объектод хамаардаг тул дараах зохицуулалтыг ХБНГУ-ын Арилжааны хуулийн зохицуулалтад тулгуурлан шинээр тусгасан:

“16.1.4.арилжааны төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн, өөрт нь ил болсон үйлчлүүлэгчийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах үүрэгтэй.”

Түүнчлэн үйлчлүүлэгчийн үүргийн талаарх зохицуулалтыг мөн шинээр тусгасан.
Үүнд:

17.1.1.барааны дээж, зураг, танилцуулга, үнийн жагсаалт, зар сурталчилгааны материал, гэрээний нөхцөл, шаардлагатай мэдээлэл зэрэг арилжааны төлөөлөгч өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлийг ашиглах боломжоор хангах;

17.1.2.арилжааны төлөөлөгчийн зуучилсан хэлцэл, эсхүл хэлцэл байгуулахад төлөөлөх бүрэн эрхгүйгээр байгуулсан хэлцлийг зөвшөөрөх, эсхүл татгалзах эсэх талаар нэн даруй мэдэгдэх;

17.1.3.арилжааны төлөөлөгчийн зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх.

Хуулийн төслийн 17.1.2 дахь хэсгийн зохицуулалт нь арилжааны эрх зүйн харилцаанд хэлцэл байгуулагдах эсэхийг түргэн шуурхай шийдвэрлэх нь арилжаа эрхлэгчийн ашиг олох зорилготой шууд холбоотой байдаг онцлогийг харгалзан үзсэн зохицуулалт болно. Уг 17.1.2 нь Иргэний хуулийн 68 дугаар зүйлээр тогтоосон журмыг өөрчилсөн тохиолдол бөгөөд хэрвээ үйлчлүүлэгч нь арилжааны төлөөлөгч бүрэн эрхгүйгээр бусадтай хэлцэл байгуулсан бол гуравдагч этгээд зөвшөөрөл олгохыг хүсвэл зөвшөөрөл олгох эсэхээ нэн даруй мэдэгдэх үүрэг хүлээнэ. Хэрвээ нэн даруй мэдэгдээгүй бол зөвшөөрөл олгохоос татгалзсанд тооцно гэж тайлбарлана. Өөрөөр хэлбэл Иргэний хуулийн 68.3 дахь хэсгийн хугацааг л өөрчилсөн тохиолдол болно.

Харин 17.1.3 дахь хэсгийн хувьд арилжааны төлөөлөгч нь хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан үүргээ зөрчсөнтэй холбоотойгоор үйлчлүүлэгч үүргийн зөрчлийн улмаас хохирол шаардах гэх мэт тохиолдолд арилжааны төлөөлөгчид хандан түүний байгуулсан эсхүл зуучилсан хэлцлийн нөгөө тал нь үүргийн зөрчил гаргасан болохыг мэдэгдэх үүргийг үйлчлүүлэгчид оноосон тохиолдол болно.

Одоогийн Иргэний хуульд худалдааны төлөөлөгчийн хөлстэй холбоотой зохицуулалт бий боловч хамрах хүрээ нь явцуу байх тул зарим нэг шинэ зохицуулалтыг хуулийн төсөлд оруулсан.

Хуулийн төслийн 18.2 дахь хэсэгт арилжааны төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болсон эсэхээс үл хамааран хөлсөө үйлчлүүлэгчээс шаардах эрхтэй тохиолдлыг тусгайлан зохицуулсан болно. Үүнд үндсэн хоёр тохиолдлыг хамааруулсан.

18.2.1 дэх заалтын хувьд арилжааны төлөөлөгчийн оролцоотойгоор үйлчлүүлэгч нь гуравдагч этгээдтэй гэрээ байгуулсан боловч гэрээг байгуулах үед арилжааны төлөөлөгчтэй үйлчлүүлэгчийн байгуулсан гэрээ дуусгавар болсон байсан тохиолдлыг зохицуулсан.

Харин 18.2.2 дахь заалтын хувьд арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болоогүй байгаа тохиолдолд арилжааны төлөөлөгчийн оролцоотойгоор гуравдагч

этгээдээс гэрээ байгуулах саналыг арилжааны төлөөлөгч эсхүл үйлчлүүлэгч хүлээн авсан бөгөөд арилжааны төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болсны дараа тухайн гэрээг үйлчлүүлэгч болон гуравдагч этгээд байгуулсан бол хөлсөө арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болсны дараа ч шаардах эрхийг олгох агуулгатай. Энд “хөлс шаардах эрх үүсгэхүйц” гэх нөхцөл нь хуулийн төслийн 18.1 дэх хэсгийг заасан болно.

Хуулийн төслийн 18.3-т ХБНГУ-ын Арилжааны хуулийн 87а.3-ын агуулгыг харгалзан үзэж, Иргэний хуулийн 415.5 дахь хэсгийн агуулгыг өөрчлөн найруулсан. Шинээр нэмсэн “үйлчлүүлэгчээс хамаарсан шалтгаанаар” гэх хэсэг нь зуучлалын үндсэн дээр зохих хэлцлийг байгуулаагүй бол, эсхүл гэрээнд заасан нөхцлийг зохих ёсоор биелүүлээгүй нь үйлчлүүлэгчээс хамааралгүй жишээ нь гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бий болсон зэрэг тохиолдлыг ойлгоно. Иргэний хуулийн 415.6, 415.7-г тус бүр хуулийн төслийн 18.4, 18.5 дугаар хэсэгт тусгасан. Ингэхдээ “шагнал” гэх үгийг хассан. Учир төслийн 18.11-ийн хувьд ч хөлс гэсэн нэр томъёог давхар ашигласан байгаа болно.

Мөн Иргэний хуулийн 415.4, 416.1, 416.2, 416.3, 416.4, 419.3 дахь хэсгийн зохицуулалтыг тус бүр хуулийн төслийн 18.6, 18.7, 18.8, 18.9, 18.10, 18.11 дэх хэсэгт хуульчилсан болно.

Харин гэрээний хугацааны хувьд гэрээний хугацаа нэг жил байна гэсэн диспозитив зохицуулалтыг хассан бөгөөд Иргэний хуулийн 417.1 дэх хэсгийн хоёрдахь өгүүлбэрийг хуулийн төслийн 19.1 дэх хэсэгт дараах байдлаар өөрчилсөн.

19.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол тодорхой хугацаатай байгуулагдсан гэрээний талууд гэрээний хугацаа дуусгавар болохоос гурван сарын өмнө түүнийг цуцлах тухай санал гаргаагүй бол гэрээг тодорхойгүй хугацаагаар сунгасанд тооцно.

Түүнчлэн урт хугацаатай гэрээний хувьд Иргэний хуульд зохицуулсан “хүндэтгэн үзэх шалтгаан” гэх нэр томъёог ашиглаж хуулийн төслийн 19.2 дахь хэсэгт дараах зохицуулалтыг шинээр тусгасан. Энэ нь ХБНГУ-ын Арилжааны хуулийн 89а дугаар зүйлийн зохицуулалтын үзэл баримтлалд тодорхой хэмжээнд үндэслэсэн.

19.2.Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд үйлчлүүлэгч болон арилжааны төлөөлөгч нь гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Энэ эрхийг хүчингүй болгох, хязгаарлахыг хориглоно.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлд арилжааны төлөөлөгчид олгох нөхөн олговрын зохицуулалтыг тусгасан. Юун түрүүнд Иргэний хуулийн 418.1.1 дэх хэсгийн “ажил хэргийн харилцаанд давуу эрх олж авсан” гэх хэсэг, 418.1.2 дахь хэсгийн “...хэлцлийг сунгаснаар хөлс, шагнал авах эрхээ алдсан” гэх хэсэг, 418.2 дахь хэсгийн зохицуулалтын агуулга ойлгомжгүй буюу тодорхой бус байдлаар илэрхийлэгдсэн байх тул ХБНГУ-ын Арилжааны хуулийн 89b дугаар зүйлийн үзэл баримтлалд тулгуурлан дараах байдлаар шинэчилсэн болно.

20.1.Арилжааны төлөөлөгч гэрээ дуусгавар болсны дараа үйлчлүүлэгчээс дараах тохиолдолд нөхөн олговор олгохыг шаардах эрхтэй:

20.1.1.арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болохоос өмнө үйлчлүүлэгч арилжааны төлөөлөгчийн зуучлалаар дамжуулан гуравдагч этгээдтэй гэрээ байгуулсан бөгөөд арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болсны дараа ч тухайн гэрээний харилцаанаас үйлчлүүлэгч үргэлжлүүлэн ашиг олсоор байгаа тохиолдолд;

20.1.2.арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болохоос өмнө үйлчлүүлэгчтэй гуравдагч этгээдийн байгуулсан гэрээний харилцааг мэдэгдэхүйц хэмжээнд өргөжүүлсэн тохиолдолд.

Харин одоогийн Иргэний хуулийн 418.3 дахь хэсгийн хувьд хоёрдахь өгүүлбэрийн агуулга нь нэг жилээс доош хугацаатай гэх байдлаар зохицуулсан боловч, 2 жил, 3 жилийн хугацаатай байсан тохиолдолд хэрхэн тооцох нь тодорхойгүй нөхцөл байдал үүсч байх тул хуулийн төслийн 20.2 дахь хэсэгт ХБНГУ-ын Арилжааны хуулийн 89b.2 дахь хэсгийн агуулгад тулгуурлан дараах байдлаар шинэчлэн боловсруулсан болно.

20.2.Нөхөн олговор нь арилжааны төлөөлөгчийн үйл ажиллагааны сүүлийн таван жилд авч байсан хөлсний нэг жилийн дундаж, эсхүл сүүлийн нэг жилд олох хөлсний дундаж хэмжээнээс илүүгүй байна. Таван жилээс доош хугацаатай байгуулсан гэрээнд арилжааны төлөөлөгчийн үйл ажиллагааны хугацаанд олж байсан хөлсний дундаж хэмжээнээс тооцно.

Одоогийн Иргэний хуулийн 418.5 дахь хэсэгт уг зүйлд өмнө тусгагдаагүй “гомдол” гэх нэр томъёог оруулсан нь ойлгомжгүй байгаа төдийгүй үр дагавар нь “хүчин төгөлдөр бус байна” гэж бичсэн байгааг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Иймд ХБНГУ-ын Арилжааны хуулийн 89b.3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийн 20.4 дэх хэсэгт “нөхөн олговор шаардах эрх” гэх нэр томъёог ашигласан бөгөөд үр дагаврын хувьд “шаардах эрх үүсэхгүй” гэх байдлаар томъёоллоо.

Мөн одоогийн Иргэний хуулийн 418.5.1 дэх заалтад “үйлдвэрийн үйл ажиллагаа” гэх нэр томъёо яагаад тусгагдсан нь ихээхэн ойлгомжгүй байгаа төдийгүй, ХБНГУ-ын Арилжааны хуулийн 89b.3.1 дэх заалтад арилжааны төлөөлөгч нь өндөр нас, өвчний улмаас үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсноос гэрээг цуцалсан бол нөхөн олговрыг шаардах эрхтэй байхаар зохицуулсан бол одоогийн Иргэний хуулийн 418.5.1 дэх заалтад эсрэгээр нь боломжгүй байхаар зохицуулсан нь алдаа болжээ. Иймд эдгээр ойлгомжгүй нөхцөл байдлыг өөрчлөх зорилгоор хуулийн төслийн 20.4.1 дэх хэсгийг шинээр боловсруулсан болно.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд Арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийн талаар зохицуулсан. Онцлох өөрчлөлтийг дурдвал одоогийн Иргэний хуулийн 419.6 дахь хэсгийн агуулгыг “өрсөлдөгч байгууллагад ажиллахыг хориглосон нөхцөл” гэдгээс өөрчилж, “үл өрсөлдөх үүрэг хүлээлгэсэн нөхцөл” болгосон. Учир нь өрсөлдөгч байгууллагад ажиллахыг хориглох явдлаар хязгаарлах нь үл өрсөлдөх үүргийг хэт явцуу хүрээнд зохицуулсан байна.

Иймд цаашлаад хуулийн төслийн 21.6 дахь хэсэгт үл өрсөлдөх үүргийг ямар тохиолдолд оноож гэрээнд тусгаж болохыг тодорхой зохицуулсан болно. Энэ нь ХБНГУ-ын Арилжааны хууль, одоогийн Иргэний хуулийн зохицуулалтын агуулгад тулгуурласан болно.

Түүнчлэн одоогийн Иргэний хуулийн 419.7 дахь хэсгийн зохицуулалтын агуулгыг харгалзан үзэж хуулийн төслийн 21.4-т “Гэрээ дуусгавар болсны дараа арилжааны төлөөлөгчийг үйлчлүүлэгчтэй өрсөлдөхийг хориглосон нөхцөлтэй гэрээний хугацаа нэг жилээс илүүгүй байна” гэсэн зохицуулалтыг тусгахаар шийдвэрлэсэн. ХБНГУ-ын хувьд 2 жилээс дээшгүй хугацаагаар тогтоох боломжтойг хуульчилсан байдаг ч манай улсын хувьд зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж илүү богино хугацаагаар буюу одоогийн Иргэний хуульд заасан хугацааг үргэлжлүүлэн баримтлах нь зохистой байх болов уу.

Хуулийн төслийн 21.5-д арилжааны төлөөлөгчид үл өрсөлдөх үүрэг оноосон гэрээний хэлбэрийн талаар тодорхой тусгасан.

Мөн хуулийн төслийн 21.7-д ХБНГУ-ын Арилжааны хуулийн 90а.3 дугаар зүйлийн агуулгад тулгуурлан шинэ зохицуулалтыг тусгалаа.

Наймдугаар бүлэг.Арилжааны зуучлагч

Юун түрүүнд нэр томъёог “худалдааны зуучлагч”-аас “арилжааны зуучлагч” болгож өөрчилсөн. Энэ нь өмнө дурдсанчлан хуулийн нэр томъёог арилжааны гэх байдлаар сонгон хэрэглэсэнтэй шууд холбогдоно.

Одоогийн Иргэний хуулийн 413 дугаар зүйлийн 413.1, 413.2 дахь хэсгийн зохицуулалт нь худалдааны зуучлагчийн хамрах хүрээг хязгаарласан шинжтэй. Гэвч бодит байдал дээр зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг субъектууд нь олон төрлөөр үйл ажиллагаа явуулж байх бөгөөд үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг субъектууд арилжааны үйл ажиллагаа буюу ашиг олох зорилготой үйл ажиллагааг зах зээл дээр өргөн хүрээнд хэрэгжүүлж байна. Түүнчлэн үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгож, хяналт, шалгалтыг хариуцаж байгаа билээ.

Нөгөөтэйгүүр одоогийн Иргэний хуулийн 413.1 дэх хэсгийн хувьд “худалдааны бусад үйл ажиллагаа” гэх мэт агуулгыг нь тодорхойлоход төвөгтэй нөхцлийг ашигласан байх тул хуулийн төсөлд шинэчлэн боловсруулахаар шийдвэрлэсэн болно.

Юун түрүүнд арилжааны зуучлагч гэдгийг хуулийн төслийн 22.1-д “Арилжааны хэлцэлд зуучлах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг этгээдийг арилжааны зуучлагч гэнэ.” гэж шинээр зохицуулсан бөгөөд энэ нь хуулийн төслийн 29.1-д заасан “Арилжааны хэлцэл гэж арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л хэлцлийг ойлгоно.” гэх зохицуулалттай хамтдаа хэрэглэгдэнэ. Тус 29.1-д арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд л хамааралтай байвал бүхий л хэлцлийг арилжаа хэлцэл байхаар зохицуулсан. Иймд тухайн арилжаа эрхлэгчийн эрхлэн явуулдаг үндсэн арилжааны үйл ажиллагаанд хамаарах хэлцэл биш байлаа ч туслах, дагалдах шинжтэй хэлцлийн хувьд ч арилжааны хэлцэлд хамаарна.

Хуулийн төслийн 22.2-т тус хуулийн төслийн онцлогтой холбогдуулан мөн ХБНГУ-ын Арилжааны хуулийн үзэл баримтлалд тулгуурлан шинэ зохицуулалтыг нэмж тусгасан.

Харин төслийн 22.3 дахь хэсгийн хувьд “гэрээнд өөрөөр заагаагүй бол” гэх байдлаар буюу Иргэний хуульд түгээмэл ашиглагддаг нөхцлийг тусгаж өгсөн бол 22.4-ын хувьд “нэн даруй биелэгдэх” гэх нэр томъёог “хиймэгц биелэгдэх” гэж Иргэний хуульд хэрэглэж заншсан нэр томъёогоор өөрчилсөн.

Одоогийн Иргэний хуулийн 413.6, 413.7, 413.8 дахь хэсгийн агуулга ихээхэн ойлгомжгүй байх тул ХБНГУ-ын Арилжааны хуулийн 95 дугаар зүйлийн агуулгад тулгуурлан өөрчилсөн.

413.6 дахь хэсгийн агуулгыг хуулийн төслийн 23.1-д өөрчлөн зохицуулсан. Ер нь арилжааны зуучлагчаар дамжуулан гэрээ байгуулах гэж байгаа тал нь өөрийгөө нөгөө талдаа мэдэгдэхийг хүсэхгүй байх нь бий. Ийм тохиолдолд хэлцлийн нэг талын нэрийг нэрлэн заагаагүй зуучлагчийн баримтыг нөгөө талд өгөх нь бий. Энэ нь гэрээний гол нөхцлийн ерөнхий агуулгыг өөрчилсөн тохиолдол болно. Иймд төслийн 23.1-д хэрвээ ийм нэрлэн заагаагүй баримтыг өгвөл цаашид нэрлэн заагдах ёстой талтай тухайн этгээдийг гэрээ байгуулсанд тооцно гэх байдлаар тодорхой зохицуулсан.

Хуулийн төслийн 23.2 дахь хэсэгт арилжааны заншлын дагуу нэрлэн заах хугацааг тогтоох боломжтойг тусгасан.

Харин хуулийн төслийн 23.3 дахь хэсэгт зохих хугацаанд нэрлэн заагдаагүй этгээдийг нөгөө талд нь илэрхий болгоогүй арилжааны зуучлагч нь нөгөө талын өмнө гэрээний үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээх тухай зохицуулсан.

Төслийн 24.1 дэх хэсэгт ХБНГУ-ын Арилжааны хуулийн 96 дугаар зүйлийн агуулгад тулгуурлан өөрчлөн боловсруулсан. Энэ нь арилжааны заншлын хэрэглээг тодорхой байдлаар тусгаснаараа онцлог.

Хуулийн төслийн 25.1-д “Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны зуучлагчийг мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах болон гэрээгээр тогтоосон бусад үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах бүрэн эрхгүй гэж үзнэ.” гэх байдлаар шинэ зохицуулалт оруулсан. Энэ нь арилжааны зуучлагч нь хэрвээ гэрээний талтай тохиролцоогүй бол үүргийн гүйцэтгэлийг нөгөө талаас хүлээн авах эрхгүй болохыг тодорхой байдлаар зохицуулсан онцлогтой.

Төслийн 27.1 дэх хэсэгт одоогийн Иргэний хуулийн 413.12 дахь хэсгийн зохицуулалтыг өөрчлөн тусгасан. Ингэхдээ тухайн нутаг дэвсгэрийн арилжааны заншлын хэрэглээг нээлттэй байдлаар зөвшөөрсөн.

Одоогийн Иргэний хуулийн 414 дүгээр зүйлийн зохицуулалт нь холбогдох эрх зүйн харилцааг бүрэн зохицуулаагүй, явцуу хүрээнд зохицуулсан байх тул хуулийн төслийн 28 дугаар зүйлд арилжааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэлийн талаарх зохицуулалтыг шинээр тусгасан. Гол агуулгыг тайлбарлавал арилжааны зуучлагч нь тэмдэглэлийг өдөр бүр, цаг, минутын дарааллаар хөтлөх шаардлагыг тавьж, цаасан хэлбэрээр үйлдсэн бол тухай бүр гарын үсгээр баталгаажуулах, цахим хэлбэрээр үйлдсэн тохиолдолд заавал тоон гарын үсгээр баталгаажуулж аль аль тохиолдолд 10 жил хадгалах үүргийг оноосон. Мөн төслийн 28.4 дэх хэсэгт шүүхээс арилжааны зуучлагчаас нотлох баримт гаргуулахтай холбоотой хэсгийг тусгасан.

Есдүгээр бүлэг.Арилжааны хэлцэл

Арилжааны хуулийн үйлчлэх хүрээг тогтоохдоо, субъектив арга буюу арилжаа эрхлэгч субъектийг тодорхойлсны үндсэн дээр энэхүү арилжаа эрхлэгчийн хийж буй хэлцлийг арилжааны хэлцэл гэж тодорхойлох арга болон арилжааны хэлцэл гэх ойлголтыг эхэлж тодорхойлсны үндсэн дээр эдгээр арилжааны хэлцлийг хийж буй этгээдийг арилжаа эрхлэгч гэж тооцох объектив арга байдаг. Мөн энэ хоёр аргыг хослуулах замаар арилжаа эрхлэгч, арилжааны хэлцлийг тодорхойлох дундын хувилбар ч байдаг.

Арилжааны хуулийн хуулийн төслийг боловсруулахад субъектив арга буюу арилжаа эрхлэгчийг тодорхойлсны үндсэн дээр түүний арилжааны үйл ажиллагааны хүрээнд хийж буй бүхий л хэлцлийг арилжааны хэлцэл гэж үзэх аргыг ашигласан. ХБНГУ-ын Арилжааны хуулийн 343 дугаар зүйлд “арилжааны хэлцэл”-ийг тодорхойлж өгсөн бөгөөд энэхүү тодорхойлолтод тулгуурлан арилжааны хэлцлийг хуулийн төсөлд тодорхойлж өгсөн. Өөрөөр хэлбэл арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л хэлцлийг арилжааны хэлцэл гэж үзнэ. Энэхүү тодорхойлолтоос “арилжааны үйл ажиллагаа” гэх ойлголтыг тодорхойлох хэрэгцээ шаардлага урган гарах бөгөөд үүнийг хуулийн төслийн 6.2 дугаар зүйлд тодорхойлж өгсөн (Хуулийн төслийн 2 дугаар бүлгийн танилцуулгаас дэлгэрэнгүй үзнэ үү).

Арилжааны хэлцлийн оролцогч талуудаас хамаарч арилжааны хэлцлийг нэг талт арилжааны хэлцэл, хоёр талт арилжааны хэлцэл гэж ангилдаг. Арилжааны хэлцлийн нэг талт арилжаа эрхлэгч бус этгээд байвал үүнийг нэг талт арилжааны хэлцэл гэх ба арилжааны хэлцлийн хоёр тал нь хоёулаа арилжаа эрхлэгч бол тухайн хэлцлийг хоёр талт арилжааны хэлцэл гэж үздэг. Ингэж ангилахын ач холбогдол нь арилжааны хэлцлийн ерөнхий ангийн зарим зохицуулалт зөвхөн хоёр талт арилжааны хэлцэлд хэрэглэгдэх онцлогтой байдагт оршино. Учир нь арилжаа эрхлэгч нь илүү мэргэшсэн, хариуцлагатай байх тул үүргээ гүйцэтгэхдээ хурдан шуурхай, болгоомжтой хандах боломжтой гэж үзэн хоёр талт арилжааны хэлцэлд илүү хүндрүүлсэн үүргийг талуудад хүлээлгэх боломжтой байдагт оршино. Тухайлбал хоёр талт арилжааны хэлцэлд барьцааны зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг талууд тохиролцож болдог бол нэг талт арилжааны хэлцэлд энэхүү журмыг хэрэглэдэггүй.

Хуулийн төсөлд “... гэрээ нь хоёр талт арилжааны хэлцэл бол” гэж тодотгосон зохицуулалтыг зөвхөн гэрээний талууд бүгд арилжаа эрхлэгч байгаа тохиолдолд хэрэглэнэ. Харин ингэж тодотгоогүй тохиолдолд нэг талт арилжааны хэлцэлд үйлчлэх буюу гэрээний нэг тал нь арилжаа эрхлэгч байгаа бүх тохиолдлуудад хэрэглэнэ. Түүнчлэн хэлцлийн нэг талд хэд хэдэн этгээд байгаа тохиолдолд тэдгээрийн нэг нь арилжаа эрхлэгч бол тухайн хэлцэлд арилжааны хуулийн зохицуулалт үйлчлэхээр тусгасан. Учир нь нэг гэрээ хэлцэлд арилжаа эрхлэгч талд нь арилжааны хуулийн зохицуулалт үйлчилж, арилжаа эрхлэгч биш этгээдэд иргэний хуулийн зохицуулалт үйлчлэх байдлаар ялгамжтай зохицуулах боломжгүй тул нэг талт арилжааны хэлцэл байсан ч арилжааны хэлцэл үйлчилдэг байхаар төсөлд тусгасан.

Иргэний хуулиас ялгагдах арилжааны эрх зүйн хэлцлийн дараах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан. Үүнд:

Одоогийн Иргэний хуулийн 196.2-т аж ахуй эрхлэгч нь ажил төрлийн байнгын холбоо бүхий этгээдээс тухайн төрлийн үйл ажиллагаа гүйцэтгүүлэх тухай гэрээний саналыг хүлээн авсан бол ердийн боломжит хугацааны дотор хариу явуулах үүрэгтэй

бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол түүнийг гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөнд гэж үзэхээр зохицуулсан. Энэ зохицуулалтыг өөрчилж “аж ахуй эрхлэгч”-ийг “арилжаа эрхлэгч” болгон өөрчилж өөрчлөн найруулж хуулийн төслийн 31 дүгээр зүйлд гэрээний саналыг дуугүй хүлээн зөвшөөрөх гарчигтайгаар оруулж өгсөн.

Одоогийн Иргэний хуулийн 196.3-т агуулгын хувьд “Гэрээний саналтай хамт хүлээн авсан барааг хадгалах үүрэг”-ийн талаар явцуу байдлаар зохицуулж өгсөн бөгөөд энэ зохицуулалтыг өөрчлөн хуулийн төслийн 32 дугаар зүйлээр өөрчлөн найруулж “Гэрээний саналтай хамт илгээсэн барааг хадгалах үүрэг”-ийг арилжаа эрхлэгчид үүсэхээр зохицуулж өгсөн. Арилжаа эрхлэгч нь саналтай хамт илгээсэн барааг санал гаргасан талын зардлаар хадгалах үүрэгтэй бөгөөд барааг хадгалах нь өөрт хохиролтой бол барааг хадгалах үүрэг хүлээхгүй байхаар хуулийн төсөлд тусгасан.

Одоогийн Иргэний хуулийн 200.4-т гэрээний санал хүлээн авагч тал нь арилжаа эрхлэгч байх тохиодолд гэрээний стандарт нөхцөл гэрээний салшгүй хэсэг болох зохицуулалтыг хуулийн төслийн 33 дугаар зүйлд шилжүүлэн тусгасан. Ингэхдээ “аж ахуй эрхлэгч” гэх нэр томъёог “арилжаа эрхлэгч” болгон өөрчилсөн.

Одоогийн Иргэний хуулийн 232.8-д “Анзын хэмжээ илт их байвал хэргийн нөхцөл байдлыг харгалзан шүүх түүнийг багасгаж болно” гэж заасан байх бөгөөд ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 348 дугаар зүйлд арилжаа эрхлэгч нь өөрийн арилжааны үйл ажиллагаатай холбоотойгоор төлөхөөр тохиролцсон анзын хэмжээг багасгаж болохгүй талаар зохицуулсан байдаг. Иймд арилжаа эрхлэгчийг хариуцлагажуулах, өөрийн эрхлэн явуулж буй арилжааны үйл ажиллагаанд мэргэшсэн этгээд гэдэг агуулгаар арилжаа эрхлэгчийн анзын хэмжээг бууруулахгүй байх зохицуулалтыг хуулийн төслийн 34 дүгээр зүйлд оруулж өгсөн.

Одоогийн Иргэний хуулийн 460.1-т батлан даагч нь нөхөх хариуцлага хүлээхээр зохицуулсан байсныг өөрчилж, хэрэв тухайн батлан даалт нь батлан даагчийн хувьд арилжааны хэлцэлд хамаарч байвал үүрэг гүйцэтгүүлэгч нь батлан даагчаас үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь шаардаж болохоор хуулийн төслийн 35 дугаар зүйлд зохицуулж өгсөн. Үүний үр дүнд арилжааны хэлцлийн үүргийн гүйцэтгэл түргэн шуурхай, баталгаатай явагдах үр дагавар үүснэ.

Одоогийн Иргэний хуулийн 459.1-т батлан даалтын гэрээг бичгээр байгуулах хэлбэрийн шаардлагыг хуульчилж өгсөн бөгөөд, 459.2-т “Ажил үүргийнхээ хүрээнд батлан даалт гаргасан бол батлан даалтын гэрээг бичгээр байгуулахгүй байж болно” гэж заасан нь батлан даалтын гэрээ нь арилжааны гэрээ бол бичгээр байгуулахгүй байж болохоор зохицуулж өгсөн байдаг. ХБНГУ-ын Арилжааны хуулийн 350 дугаар зүйлд мөн батлан даалтын гэрээ нь батлан даагчийн хувьд, үүргийг хүлээн зөвшөөрсөн амлалт, гэрээ нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд арилжааны хэлцэлд хамаарч байх бол бичгээр байгуулах хэлбэрийн шаардлага үйлчлэхгүй байхаар хуульчилж өгсөн байдаг. Иймд ХБНГУ-ын Арилжааны хуулийн 350 дугаар зүйлд суурилан хуулийн төслийн 36 дугаар зүйлд гэрээний хэлбэрийн чөлөөт байдлыг тусгаж өгсөн.

Одоогийн Иргэний хуульд хуульд заасан хүүгийн зохицуулалт байхгүй бөгөөд Иргэний хуулийн 222.5-д Мөнгөн төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн хугацаанд тохирсон хүү төлөх үүрэгтэй гэсэн зохицуулалтыг

хэрэглэж, хүү тохиролцоогүй байсан ч зах зээл дээрх хүүгийн хэмжээг нотлох байдлаар хүү шаардах эрхийг хэрэгжүүлдэг. Гэхдээ энэхүү зохицуулалт нь ерөнхий зохицуулалт бөгөөд иргэд хоорондын гэрээнд ч хамаарна. ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 352 дугаар зүйл, Япон Улсын Иргэний хуулийн 404 дүгээр зүйлүүдэд хуульд заасан хүүгийн талаар зохицуулж өгсөн байх бөгөөд гол зорилго нь үүрэг гүйцэтгүүлэгчийн эдийн засгийн алдагдлыг аль болох бага байлгах зорилготой. Иймд арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах үүднээс, хоёр талт арилжааны хэлцлээр талууд хүү тохиролцоогүй байсан ч Монголбанкнаас зарласан жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр хүү шаардах эрхтэй байхаар хуулийн төслийн 37 дугаар зүйлд хуульд заасан хүүг зохицуулж өгсөн. Түүнчлэн, хоёр талт арилжааны хэлцэлийн хувьд мөнгөн төлбөрийн үүрэг гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн бол хүүгийн хэмжээ нь хуульд заасан хүүгийн хэмжээтэй тэнцүү байхаар хуулийн төслийн 38 дугаар зүйлд зааж өгсөн

Иргэний хуулиар, талууд хөлс тохиролцоогүй бол хөлс шаардах эрхгүй. Гэхдээ Иргэний хуулийн 422 дугаар зүйлийн 422.2-т "...хэрэв хадгалагч хадгалалтыг аж ахуйн үндсэн үйл ажиллагааны хүрээнд явуулж байгаа бол урьдчилан тохиролцоогүй ч хадгалалтын хөлсийг харилцан тохиролцсон гэж үзнэ" гэж талууд хөлс тохиролцоогүй ч хөлс шаардах эрхтэй байхаар зохицуулж өгсөн байдаг. Гэхдээ манай Иргэний хуульд хөлс шаардах ерөнхий зохицуулалт байхгүй. ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 354 дүгээр зүйл, Япон Улсын Арилжааны хуулийн 512 дугаар зүйлд арилжаа эрхлэгч нь өөрийн арилжааны үйл ажиллагааны хүрээнд бусдын төлөө гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсийг тохиролцоогүй байсан ч шаардах эрхтэй байхаар хөлс шаардах эрхийг хуульчилж өгсөн байдаг. Энэ нь арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах зорилготой. Иймд хуулийн төслийн 39 дүгээр зүйлд арилжаа эрхлэгчийн хөлс шаардах эрх, бусдын өмнөөс төлсөн мөнгөн төлбөрөөс хүү шаардах эрхтэй байхаар хуульчилж өгсөн.

Иргэний хуулиар барьцааны зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг хориглодог. Учир нь үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг гүйцэтгэгчийн эрх ашгийг балансалж, үүрэг гүйцэтгэгчийн буюу барьцаалуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилготой байдагт оршино. Харин арилжааны хуулиар, хоёр талт арилжааны хэлцлээс үүсэх үүргийг барьцаагаар баталгаажуулсан бол талууд барьцааны зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах, захиран зарцуулах журмыг зөвшөөрдөг. Учир нь гэрээний хоёр тал хоёул арилжаа эрхлэгч байх бөгөөд арилжаа эрхлэгч үүргээ гүйцэтгэхгүй бол хүлээх эрсдэлийг урьдчилан тооцоолох, эрсдэл даах, мэргэшсэн этгээд байдаг тул барьцааны зүйлийг худалдан борлуулах журам хэрэглэхийг зөвшөөрдөг. ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 368 дугаар зүйл, Япон Улсын Арилжааны хуулийн 515 дугаар зүйлээр барьцааны зүйлийг худалдан борлуулах журмыг зөвшөөрсөн байдаг. Иймд энэ жишгийн дагуу хуулийн төслийн 40 дүгээр зүйлд хоёр талт арилжааны хэлцлээс үүсэх үүргийг баталгаажуулсан барьцааны зүйлийг худалдан борлуулах журмыг хэрэглэж болохоор зохицуулж өгсөн.

Саатуулан барих эрх нь өөрийн авах ёстой хөлс төлбөрийг төлүүлэх зорилгоор эрх бүхий этгээдэд эд хөрөнгийг шилжүүлэхгүй байх эрх бол хуульд зааснаар үүсэх барьцааны тухайд (тухайлбал, тээвэрлэлтийн гэрээнд бий) түүнийг саатуулан барихаас гадна, хөлс төлбөрийг төлөхгүй бол өөрийгөө хохиролгүй болгох үүднээс худалдан борлуулах эрхтэй байдгаараа эдгээр ойлголтууд ялгаатай. Манай иргэний хуульд саатуулан барих эрхийг тодорхойлж өгөөгүй ч, Иргэний хуулийн 301 дүгээр зүйлд хөлслүүлэгчийн саатуулан барих эрхийг зохицуулж өгсөн байдаг. Иргэний

хуульд заасан саатуулан барих эрх нь зөвхөн тухайн гэрээний үндсэн дээр эзэмшил шилжсэн эд юмсад үйлчилж байдаг бол арилжааны эрх зүйн саатуулан барих эрх нь зөвхөн нэг арилжааны гэрээгээр бус талуудын хооронд үүссэн өөр бусад арилжааны гэрээний үндсэн дээр эзэмшил шилжсэн эд хөрөнгөд мөн үйлчилж байдгаараа ялгаатай. ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 369 дүгээр зүйл, Япон Улсын Арилжааны хуулийн 521 дүгээр зүйлд хоёр талт арилжааны хэлцлээс үүдэх саатуулан барих эрхийг хуульчилж өгсөн байдаг. Иймд хуулийн төслийн 41 дүгээр зүйлд хоёр талт арилжааны хэлцлээс үүсэх саатуулан барих эрхийг зохицуулж өгсөн.

Иргэний хуулийн үндсэн зарчмаар хамтран үүрэг гүйцэтгэгч нар нь тэнцүү үүрэг гүйцэтгэдэг бол арилжааны эрх зүйд хэд хэдэн үүрэг гүйцэтгэгчийн хэн нэгнийх нь хувьд тухайн хэлцэл арилжааны хэлцэлд хамаарах бол тухайн арилжааны хэлцлээс үүсэх үүргийг үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчийн хэнээс нь ч бүхэлд нь шаардах эрхтэй байдгаар ялгаатай. Үүний үр дүнд арилжааны хэлцлийн үүргийн гүйцэтгэл илүү баталгаатай болох бөгөөд арилжаа эрхлэгчийг илүү хариуцлагатай байлгах зорилготой. Иймд хуулийн төслийн 42 дугаар зүйлд хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хамтын хариуцлагын талаар зохицуулж өгсөн.

Аравдугаар бүлэг.Худалдах, худалдан авах гэрээ

Иргэний хуулийн худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтаас гадна арилжааны хэлцлийн хувьд хэрэглэх нэмэлт, нарийвчилсан зохицуулалтуудыг тусгасан. Тухайлбал:

Хуулийн төслийн 43 дугаар зүйлд ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 375 дугаар зүйлийг үндэслэн Гэрээний зүйлийн шинж чанарыг тодорхойлох заалтыг оруулж өгсөн. Энэхүү зохицуулалтаар хөдлөх эд хөрөнгө худалдах худалдан авах арилжааны гэрээгээр худалдан авагч тал гэрээний зүйлийн шинж чанарын талаар худалдан авагч талд зааварчилгаа өгөх тохиолдолд хэрэглэгдэх заалт бөгөөд худалдан авагч тал гэрээний зүйлийн шинж чанарыг тохиролцсон хугацааны дотор тодорхойлж өгөх үүргээ гүйцэтгээгүй бол худалдан авагч тал ИХ-ийн 225 дугаар зүйлд заасны дагуу гэрээнээс татгалзах, аль эсвэл ИХ-ийн 219.2-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийн оронд хохирол шаардах эрхийг тусгаж өгсөн. Түүнчлэн, гэрээний зүйлийн талаар худалдан авагчийн хүсэл зориг тодорхой байх тохиолдолд худалдагч тал гэрээний зүйлийг өөрөө тодорхойлж энэ талаар мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд хариу өгөөгүй бол худалдагч тал өөрийн тодорхойлсон гэрээний зүйлийг худалдан авагчид шилжүүлэн үүргээ гүйцэтгэх боломжийг олгосон. Энэ зохицуулалт нь гэрээ хэлцлийг түргэн шуурхай байгуулах замаар эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, арилжаа эрхлэгчийг эрх ашгийг хамгаалах зорилготой болно.

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлд ХБНГУ-ийн Арилжааны хуулийн 380 дугаар зүйлийг үндэслэн Барааны жингээр үнийг тодорхойлох тохиолдолд тухайн газарт мөрдөгддөг арилжааны заншилд өөр байдгаас бусад тохиолдолд тухайн барааны сав, баглаа боодлын жинг барааны жинд оруулж тооцохгүй талаар тусгаж өгсөн. Үүний үр дүнд барааны жин, гэрээний үнийн талаар маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх бөгөөд илүү тодорхой зохицуулалт болж өгөх юм.

Хуулийн төслийн 45 дугаар зүйлд Үүрэг гүйцэтгэх хугацаа заасан худалдах, худалдан авах гэрээний талаар зохицуулж өгсөн. Худалдах, худалдан авах гэрээ нь

хоёр талын хувьд арилжааны гэрээ байх бөгөөд үүрэг гүйцэтгэх хугацааг хатуу тохиролцсон ба үүргээ хугацаандаа гүйцэтгэх нь тухайн гэрээний ач холбогдлыг бий болгож байгаа тохиолдолд энэхүү заалт хэрэглэгдэнэ. Өөрөөр хэлбэл гэрээний зүйлийг худалдагч тал хоцроож нийлүүлэх нь худалдан авагч талд гэрээ байгуулах ач холбогдлыг үгүй болгох тохиолдол юм. Түүнчлэн, энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч тал буюу худалдан авагч тал гэрээнээс татгалзсанд тооцогдох эрх зүйн үр дагаврыг үүсгэнэ.

Хуулийн төслийн 46 дугаар зүйлд худалдах, худалдан авах гэрээний зүйлийг Нэн даруй шалгах, мэдэгдэх үүргийг зохицуулж өгсөн. Одоогийн Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.2-т аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг худалдан авагч нь уг үйл ажиллагаатай холбоотой эд хөрөнгийг шилжүүлэн авах үедээ нэн даруй шалган авах үүргээ биелүүлээгүй бол шаардлага гаргах эрхээ алдах хуульчилж өгсөн байдаг. Энэ зохицуулалтыг илүү тодорхой болгож Арилжааны хуулийн төсөлд тусгаж өгсөн бөгөөд ингэхдээ доголдлыг барааг шалгах үед илрүүлэх боломжгүй байсан тохиолдолд доголдлыг хожим илрүүлсэн даруйд худалдагчид доголдлын талаар мэдэгдэх үүрэгтэй байхаар зохицуулж өгсөн. Хэрэв доголдлын талаар шалгах үүрэг, доголдлын талаар нэн даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол барааг хүлээн авсанд тооцохоор үр дагаврыг нь зохицуулсан. Гэхдээ худалдагч эд хөрөнгийн доголдлын талаар мэдсээр байж нуун дарагдуулсан бол энэ зохицуулалт үйлчлэхгүй.

Арваннэгдүгээр бүлэг. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа

Иргэний хуулийн 286 дугаар зүйлийг өөрчлөлтгүйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан. Ийм учраас Арилжааны хуулийн төслийг дагалдуулан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Арванхоёрдугаар бүлэг. Санхүүгийн түрээс

Иргэний хуулийн 26 дугаар бүлэг буюу санхүүгийн түрээсийн гэрээтэй холбоотой 312-317 дугаар зүйлийг зарим өөрчлөлттэйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан.

Юун түрүүнд санхүүгийн түрээсийн гэрээний талуудын хүлээх үүргийг тодорхойлсон зохицуулалтыг одоогийн Иргэний хуулийн 312.1, 312.2 болон Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 3.1, 6.1 дэх хэсгийн зохицуулалтад тус тус тулгуурлан шинэчлэн боловсруулсан. Арилжааны хуулийн онцлогтой холбогдуулан шинээр төсөлд 48.3, 48.4 дэх хэсгийн зохицуулалтыг тусгасан.

Харин одоогийн Иргэний хуулийн 312.4 дэх хэсгийн зохицуулалт нь заавал хуульчлах шаардлагагүй агуулгыг тусгасан байх тул хассан болно.

Хуулийн төслийн 49.2 дахь хэсэгт одоогийн Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн агуулгыг судалгаанд үндэслэн өөрчлөн тусгасан.

Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д санхүүгийн түрээсийн гэрээ нь дараах 3 шаардлагын аль нэгийг нь хангах ёстой байдлаар хуульчилсан бөгөөд үүнд, 5.1.1-д "гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн

зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр гэрээнд тусгасан байх” 5.1.2-т “гэрээний хугацааг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн ашиглалтын хугацааны дөрөвний гурваас багагүй байхаар тогтоосон байх” 5.1.3-т “гэрээний нийт үнийг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн үнийн дүнгийн 90 болон түүнээс дээш хувьтай тэнцүү байхаар тогтоосон байх” гэж тус тус заасан.

Санхүүгийн түрээсийн гэрээний хувьд түрээсийн гэрээ, зээлээр худалдах, худалдан авах гэрээтэй адил төстэй бөгөөд үүнийг ялгахад зарим тохиолдолд хүндрэл үүсдэг бөгөөд зээлээр худалдах, худалдан авах гэрээний гол шинж нь санхүүгийн түрээсийн тухай хуулийн 5.1.1-д заасан санхүүгийн түрээсийн гэрээний шинжтэй адил төстэй байгаа юм.¹⁴ Иймд санхүүгийн түрээсийн гэрээ нь хуулийн 5.1-д заасан бүх шаардлагуудыг зэрэг хангаж байх шаардлагыг хуулийн төсөд тусгасан.

Арвангуравдугаар бүлэг.Франчайз, мерчандайз

Иргэний хуулийн 29 дүгээр бүлэг буюу франчайз, мерчандайзын гэрээтэй холбоотой 333-338¹ дугаар зүйлийг зарим өөрчлөлттэйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан. Мөн Соёлын тухай хуулийн 35 дугаар зүйлд мерчандайзийн гэрээгээр соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах эрхийн талаар зохицуулж өгсөн бөгөөд тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д мерчандайзийн гэрээнд тусгах зүйлсийн талаар тухайлан хуульчилж өгсөн. Эдгээр зүйлсийг мерчандайзийн гэрээний хэсэгт нэмж тусгасан.

Арвандөрөвдүгээр бүлэг.Комисс

Иргэний хуулийн 39 дүгээр бүлгийн Хоёрдугаар дэд бүлэг буюу Худалдааны зуучлагч, комисстой холбоотой 413-419 дүгээр зүйлээс комиссын харилцаанд хамааралтай зарим зүйл, хэсэг, заалтуудыг Арилжааны хуулийн төсөлд зохих өөрчлөлттэйгээр шилжүүлэн тусгасан.

Юун түрүүнд комиссын тодорхойлолтыг одоогийн Иргэний хуулийн 415 дугаар зүйлийн 415.2-ын агуулгыг өөрчлөх замаар шинэчилсэн. Ингэхдээ ХБНГУ-ын Арилжааны хуулийн 383.1, Япон улсын Арилжааны хуулийн 551 дүгээр зүйлийн зохицуулалтын агуулгад суурилсан. Одоогийн хуулийн 415.2-т “барааг борлуулж, эрх хэрэгжүүлэх” гэх байдлаар томъёолсныг хуулийн төслийн 61.1 дэх хэсэгт “барааг худалдах, худалдан авах” гэх байдлаар өөрчлөн боловсруулсан.

Арилжааны хуулийн онцлогтой холбоотойгоор 61.2 дахь хэсгийг нэмж тусгасан. Түүнчлэн хуулийн төслийн 62 дугаар зүйлд комиссын үүргийн талаар зохицуулсан. Комиссын гэрээ нь даалгаврын гэрээний үндсэн шинжийг агуулдаг боловч хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээний шинжийг мөн өөртөө агуулдаг холимог шинжтэй гэрээ болно. Иймд уг шинжийг нь харгалзан үзэж 62 дугаар зүйлд анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажиллах үүрэг, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн, үйлчлүүлэгчийн зааврын дагуу үйл ажиллагаа явуулах үүрэг, үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөх, гэрээ хэлцэл байгуулагдсан тохиолдолд нэн даруй мэдэгдэх үүрэг, олсон орлого, худалдаж авсан барааны өмчлөх эрхийг үйлчлүүлэгчид шилжүүлэх үүрэг, гэрээ хэлцэл байгуулсан нөгөө талыг нэрлэн заагаагүй бол үүргийн гүйцэтгэлтэй холбоотой хариуцлага хүлээх үүрэг,

¹⁴ Санхүүгийн түрээсийн гэрээ судалгаа. 2025 он

үйлчлүүлэгчийн зааврыг зөрчсөн тохиолдолд хохирол нөхөн төлөх үүргийн талаар зохицууллаа.

Комисс өөрийн мэдэлд байгаа бараа устсан болон гэмтсэний хариуцлагыг өөрөө хүлээх бөгөөд ямар тохиолдолд уг хариуцлагыг хүлээхгүй байх талаар мөн тусгасан. Түүнчлэн комисс нь барааг даатгалд даатгуулах зааврыг үйлчлүүлэгчээс хүлээж авсан бол уг зааврыг зөрчсөний улмаас хариуцлага хүлээх боломжтой талаар мөн зохицууллаа.

Мөн комисс нь худалдан авсан бараа нь ил доголдолтой байсан тохиолдолд худалдагчийн эсрэг гаргах шаардлагаа хангаж, үйлчлүүлэгчид нэн даруй мэдэгдэх үүргийг хүлээлгэсэн. Учир нь комисс нь бараа худалдах, худалдан авах үүргийг үйлчлүүлэгчийн өмнө хүлээдэг учраас худалдах, худалдан авах гэрээний доголдолтой холбоотой асуудлыг зохицуулах нь чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Хуулийн төслийн 62.4-т ХБНГУ-ын Арилжааны хуулийн 391 дүгээр зүйлийн агуулгад суурилан үйлчлүүлэгчийн хувьд хуулийн төслийн 46 дугаар зүйл, Иргэний хуулийн 259.3 дахь хэсгийн зохицуулалт үйлчлэхээр тусгасан. Иргэний хуулийн 259.3 дахь хэсгийг ХБНГУ-ын Арилжааны хуулийн 379 дүгээр зүйлийн 379.2 дахь хэсгийн агуулгад суурилан өөрчилсөн болохыг энд бас дурдая.

Түүнчлэн комисс нь гэрээг өөрийн нэрийн өмнөөс байгуулдаг боловч, үйлчлүүлэгчийн зааврын дагуу гүйцэтгэдэг онцлогтой. Үүнийг академик түвшинд шууд бус төлөөлөл гэж нэрлэх нь ч бий. Иймд комиссын гэрээний хувьд үйлчлүүлэгч шууд төлөөллийн нэгэн адил гуравдагч этгээдийн эсрэг комиссын хэрэгжүүлэх боломжтой шаардах эрхийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэх хамгийн чухалд тооцогддог. Энэ шалтгааны улмаас хуулийн төслийн 63 дугаар зүйлд комиссын шаардах эрхтэй холбоотой зохицуулалтыг тусгасан болно. Энэхүү зохицуулалт нь ХБНГУ-ын Арилжааны хуулийн 392 дугаар зүйлийн агуулгад үндэслэсэн болно.

Мөн хуулийн төслийн 65 дугаар зүйлд комиссын барьцааны эрхийн талаарх зохицуулалт, 66 дугаар зүйлд комисс өөрөө гэрээний нэг тал болж өөрөө худалдагч болох тохиолдолд өөрөө худалдан авагч нь болж, өөрөө худалдан авагч болох тохиолдолд өөрөө худалдагч болох тохиолдлын талаар зохицуулсан хэм хэмжээг тус тус шинээр тусгасан.

Арвантавдугаар бүлэг.Аялал жуулчлал

Иргэний хуулийн 34 дүгээр бүлэг буюу аялал жуулчлалын гэрээтэй холбоотой 370-379 дүгээр зүйлийг зарим өөрчлөлттэйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан.

Арванзургаадугаар бүлэг.Илгээмжийн гэрээ

Иргэний хуулийн 38 дугаар бүлэг буюу илгээмжийн гэрээтэй холбоотой 408-409 дүгээр зүйлийг зарим өөрчлөлттэйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан.

Илгээмжийн гэрээг нэг удаагийн шинжтэй байгуулсан бол үүнийг илгээмжийн гэрээ гэж үзэхгүй бөгөөд арилжааны үйл ажиллагааны хүрээнд илгээмжийн үйлчилгээг

эрхэлж байгаа тохиолдолд үйлчлэхээр заасан. Энэ арилжааны хуулийн төслөөр арилжаа эрхлэгчийг субъектив байдлаар тодорхойлсонтой холбоотой. Өөрөөр хэлбэл арилжаа эрхлэгч биш этгээд илгээмжийн гэрээг нэг удаа тохиолдлын шинжтэй байгуулснаар түүнд арилжааны хуулийг хэрэглэх нь зохимжгүй билээ. Мөн түүнчлэн, илгээмжийн үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэгч нь жижиг арилжаа эрхлэгч байсан ч Арилжааны хуульд заасан бүртгүүлэх, баланс хөтлөх үүрэг зэрэг бүх үүргийг нэгэн адил хүлээхээр төсөлд тусгасан. Учир нь илгээмжийн үйл ажиллагааг тээвэр ложистикийн талаар мэргэшсэн этгээд эрхлэн явуулдаг тул илүү хариуцлагатай байхыг шаарддаг.

Хуулийн төслийн 78 дугаар зүйлийн 78.1-т илгээгчийн үүргийг жагсаах байдлаар одоогийн ИХ-д зааснаас илүү тодорхой тусгаж өгсөн. Ингэхдээ илгээгчийн дараах үүргүүдийг нэмж өгсөн.

78.1.3.илгээхэд шаардлагатай тээвэрлэлтийн, хадгалалтын, илгээмжийн гэрээг байгуулах;

78.1.4.захиалагчид хохирол шаардах эрхийг шилжүүлэх;

Дээрх үүргүүдийг нэмж өгснөөр, илгээгч нь өөрийн нэрийн өмнөөс захиалагчийн төлөө тээвэрлэлтийн гэрээ, хадгалалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ хэлцэл байгуулж байдаг илгээмжийн гэрээний шинж, илгээгчийн үүргийг илүү тодорхой болгож өгсөн.

Одоогийн Иргэний хуулийн 408.2-408.7 дахь заалтуудыг хуулийн төслийн 78.2-78.7 хүртэл өөрчлөлтгүйгээр тусгаж өгсөн.

Иргэний хуулийн 408 дугаар зүйлийн 408.8-д илгээгч өөрөө тээвэрлэлтийг гүйцэтгэх талаар зохицуулж өгсөн байх бөгөөд үүнийг хуулийн 79 дүгээр зүйлд “Илгээгч өөрөө тээвэрлэлтийг гүйцэтгэх” гэсэн гарчигтайгаар тусгаж өгсөн. Мөн хуулийн 79.2-т илгээгч өөрөө тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа тохиолдолд илгээмжийн хөлснөөс гадна, тээвэрлэлтийн хөлсийг шаардаж болох зохицуулалтыг тусгаж өгсөн. Өөрөөр хэлбэл илгээмжийг хүлээн авч буй тал тээврийн хөлсийг төлөх тохиолдолд илгээгч нь илгээмж хүлээн авагчаас тээврийн хөлсийг шаардах эрхтэй байх нь зүйтэй.

Хуулийн төслийн 80 дугаар зүйлд Илгээгчийн хүлээх хариуцлагыг зохицуулж өгсөн бөгөөд, ИХ-ийн 408.9, 408.10, 408.11 дэх заалтуудыг шилжүүлэн тусгасан. Илгээгчийн хүлээх хариуцлагад ХБНГУ-ын 461.2 дахь хэсэгт заасан үзэл баримтлалд тулгуурлан “80.2.Илгээгч хяналтандаа байгаа илгээмж алдагдсан, дутсан, гэмтсэний хариуцлагыг хүлээнэ. Үүнээс бусад хохирлыг илгээгч нь энэ хуулийн 78.1-д заасан үүргээ зөрчсөн нөхцөлд хариуцна. Илгээгч нь ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажилласан ч энэ хохирол учрахаар байсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.” гэсэн хариуцлага хүлээх заалт болон хариуцлагаас чөлөөлөх заалтыг нэмж тусгаж өгсөн.

Хуулийн төслийн 81 дүгээр зүйлд Захиалагчийн үүргийг одоогийн ИХ-ийн 409.1-409.7 хүртэлх заалтыг шилжүүлэн тусгасан. Түүнчлэн ИХ-ийн 409.8 болон 409.9 дэх хэсгийг хуулийн төслийн 82 дугаар зүйлд Хөлс төлөх зохицуулалт болгон тусдаа зүйл болгосон.

Хуулийн төслийн 83 дугаар зүйлд Захиалагчийн шаардах эрхээ хэзээ хэрэгжүүлэх талаар зохицуулж өгсөн. Өөрөөр хэлбэл илгээмжийн гэрээгээр илгээгч нь өөрийн нэрийн өмнөөс илгээмжийн үйл ажиллагаатай холбоотой гэрээнүүдийг байгуулж байдаг тул илгээгчийн байгуулсан гэрээнээс үүссэн шаардах эрхийг өөртөө шилжүүлж авсаны дараа хэрэгжүүлэх шаардлагатай болно.

Хуулийн төслийн 84 дүгээр зүйлд илгээгчийн саатуулан барих эрхийг тусгаж өгсөн.

Арвандолдугаар бүлэг.Тээвэрлэлт

Иргэний хуулийн 35 дугаар бүлэг буюу тээвэрлэлтийн гэрээтэй холбоотой 380-398 дугаар зүйлийг зарим өөрчлөлттэйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан. Ингэхдээ Тээвэрлэлтийн гэрээний нийтлэг үндэслэл, Зорчигч тээвэрлэлтийн гэрээ, Ачаа тээвэрлэлтийн гэрээ гэсэн 3 дэд бүлэгтэй байхаар боловсруулсан.

Зорчигч тээвэрлэлтийн хөгжлийн явцад энэ төрлийн гэрээнд пайз, тасалбар гардуулах гэсэн хэлбэрийн шаардлага тавих нь ач холбогдолгүй болж байгаа буюу нийтийн тээвэрт карт уншуулж хөлсөө төлснөөр гэрээ байгуулагдаж байгаа, бусад төрлийн тээврийн хэрэгслээр зорчиход ч мөн тасалбар өгөх нь ховор болсон тул Иргэний хуулийн 382 дугаар зүйлийг хассан. Ингэснээр зорчигч тээвэрлэлтийн гэрээнд хэлбэрийн шаардлага тавигдахгүй, аль ч хэлбэрээр байгуулах боломжтой болно. Мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой болгох үүднээс тээвэрлэлтийн гэрээний бүлгийг тус гэрээний нийтлэг зохицуулалт, зорчигч тээвэрлэлт болон ачаа тээвэрлэлттэй холбоотой онцлог зохицуулалт бүрээр ялгаж дэд бүлгүүдэд хуваасан.

Тээвэрлэлтийн үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд арилжааны хуулийн зохицуулалт үйлчлэхээр хуулийн төсөлд тусгаж өгсөн. Өөрөөр хэлбэл нэг удаагийн шинжтэй тээвэрлэлтийн гэрээ байгуулахад арилжааны хууль үйлчлэх нь хууль хэрэглээний зөрчил үүсгэх юм. Учир нь Арилжааны хуулийн төслөөр субъектив байдлаар арилжаа эрхлэгчийг тодорхойлж, зөвхөн арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааны хүрээнд хийж буй хэлцэл нь арилжааны хэлцэл байхаар системчилж өгсөнтэй холбоотой. Мөн тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй этгээд нь жижиг арилжаа эрхлэгч байсан ч арилжааны хууль бүхэлдээ үйлчилнэ. Энэ нь тээвэрлэлтийн үйл ажиллагаа нь тодорхой хэмжээнд мэргэшсэн этгээд байхыг шаардаж, арилжаа эрхлэгчийг хариуцлагажуулж буй хэлбэр юм.

Түүнчлэн тээвэрлэгч, зорчигч, тээвэрлүүлэгч нарын үүрэг, хариуцлагын хэмжээг зохих байдлаар тэнцвэржүүлсэн буюу шударга хуваарилахад анхаарч зарим зохицуулалтуудыг нэмж, өөрчилсөн. Тухайлбал зорчигч тээвэрлэлтийн гэрээний тээвэрлэгчийн хариуцлага хэсэгт дараах агуулга бүхий заалтуудыг нэмсэн:

89.3.Тээвэрлэгч нь зорчигчийн хүлээлгэн өгсөн тээшний хувьд уг тээшийг тээвэрлэхтэй холбогдуулан нэмэлт хөлс авах эсэхээс үл хамааран ачаа тээвэрлэлтийн гэрээний тээвэрлэгчтэй адил хариуцлага хүлээнэ.

89.4.Тээвэрлэгчийн санаатай буюу болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй бол зорчигчийн хүлээлгэн өгөөгүй гар тээш болон биедээ авч яваа эд зүйлс устаж гэмтсэний улмаас үүссэн хохирлыг тээвэрлэгч хариуцахгүй.

89.5.Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.

Ачаа тээвэрлэлтийн гэрээний хувьд одоогийн иргэний хуулийн 386.1-т ачаа тээвэрлэлтийн гэрээг дагалдах бичгийн хэлбэрээр байгуулахаар зохицуулсан хэлбэрийг шаардлагыг байхгүй болгосон. Харин тээвэрлэгч нь ачаа илгээгчээс дагалдах бичиг үйлдэхийг шаардах эрхтэй байхаар тээвэрлэлтийн гэрээний холбогдох хэсгүүдийг өөрчлөн найруулсан.

Ачаа тээвэрлэлтийн гэрээнд дараах зохицуулалтыг нэмж тусгасан. Үүнд:

93.11.Тээвэрлэх ачаа нь шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай ачаа байгаа тохиолдолд ачаа илгээгч нь энэ талаар болон ачааны нэр төрөл, шинж чанар болон тухайн ачааг аюулгүй тээвэрлэхтэй холбоотой мэдээллийг ачааг хүлээлгэж өгөхөөс өмнө тээвэрлэгчид өгөх үүрэгтэй.

Арваннаймдугаар бүлэг.Хадгалалт

Иргэний хуулийн 41 дүгээр бүлэг буюу хадгалалтын гэрээтэй холбоотой 422-430 дугаар зүйлийг зарим өөрчлөлттэйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан. Ингэхдээ Хадгалалтын гэрээний нийтлэг үндэслэл, Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэсэн 2 дэд бүлэгтэй байхаар боловсруулсан.

Арван есдүгээр бүлэг.Даатгал

Иргэний хуулийн 43 дугаар бүлэг буюу даатгалын гэрээтэй холбоотой 431-444 дүгээр зүйлүүдийг ямарваа өөрчлөлтгүйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан. Энэ гэрээтэй холбоотой харилцаа нь энэ хуулийн эдгээр зохицуулалтаас гадна нарийвчилсан зохицуулалт бүхий бусад хуулиар зохицуулагддаг тул өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Хорьдугаар бүлэг.Зээл тооцооны үүрэг

Иргэний хуулийн 44 дүгээр бүлэг буюу зээл тооцооны үүрэгтэй холбоотой 445-457 дугаар зүйлүүдийг мөн өөрчлөлтгүйгээр Арилжааны хуулийн төсөлд шилжүүлэн тусгасан. Энэ бүлэг нь Иргэний хуульд байсантай адилаар дотроо Төлбөр тооцоо, Банк зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох, Мөнгөн хадгаламж, Банкны баталгаа гэсэн 4 дэд бүлэгтэй. Эдгээр гэрээтэй холбоотой харилцаа нь мөн энэ хуулийн эдгээр зохицуулалтаас гадна нарийвчилсан зохицуулалт бүхий бусад хуулиар зохицуулагддаг тул өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Харин Банк зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох харилцааг тусгасан 451-453 дугаар зүйлийг шилжүүлэн тусгахдаа үүрэг гүйцэтгэх дарааллийг нэмж тусгасан болно.

Тодруулбал, 451 дүгээр зүйлийн 451.1 дэх хэсэгт заасан банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээний дагуу зээлдэгч нь гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу үндсэн зээл болон хүүгийн төлбөр төлөх

үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас хэтэрсэн хугацааны хүү болон нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэг үүссэн тохиолдолд зээлийн гэрээний хугацаа дууссанаас хойш зээлдэгчийн төлсөн төлбөр нь үндсэн зээл, үндсэн хүү, хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг бүхэлд нь төлөхөд хүрэлцэхгүй үед эдгээр үүргийг ямар дарааллаар гүйцэтгэхтэй холбоотой Иргэний хуулийн 216 дугаар зүйлийн 216.4 дэх хэсгийн зохицуулалтын талаар шүүхүүд нэг мөр ойлголтод хүрээгүй, уг зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэдэг¹⁵ байна. Зээлийн гэрээний дагуу зээлдэгчийн хүлээх үүргийн хэмжээг тогтоохын тулд тухайн гэрээний хугацаа, төлбөр хийсэн огноо тус бүрийг харгалзан үзэхээс гадна төлөгдсөн төлбөр чухамхүү гэрээний аль үүрэгт хамаарахыг тодорхой болгох шаардлагатай гэж үзэн хуулийн төслийн 132.2-т тусгалаа. Түүнчлэн, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгээр зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаа буюу зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хугацаанаас өмнө хэдийд ч зээлийн гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэх эрхийг зээлдэгчид олгосон боловч зээлдэгчийн хэсэгчлэн төлсөн төлбөрөөс дарааллын хувьд эхний ээлжинд зээлийн гэрээний аль үүргийг гүйцэтгүүлэхийг тодорхойгүй үлдээжээ. Тодруулбал, зээлдэгчийн урьдчилж төлсөн төлбөрийг үндсэн зээлийн үлдэгдэл болон төлбөр төлсөн өдөр хүртэл бодогдсон байгаа хүүгийн төлбөрийн алинаас хасаж тооцохтой холбоотой хуулийн зохицуулалт байхгүй бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 216 дугаар зүйл үйлчлэхээргүй байх тул энэ талаарх нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төслийн 132.2-т тусгалаа. Энэ нь нэг талаас зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө зээлдэгч зээлийн гэрээний үүргээ хэсэгчлэн гүйцэтгэхтэй холбоотойгоор гэрээний талуудын хооронд үүсэх харилцааг цогц байдлаар зохицуулах, нөгөө талаас талуудын хооронд энэ талаар маргаан гарах, гэрээний аль нэг талд давуу байдал бий болгож, нөгөө талын эрх ашгийг хохироох зэрэг үр дагавар гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Хорин нэгдүгээр бүлэг.Тооцоо нийлэх

Иргэний хуулийн 46 дугаар бүлэг буюу тооцоо хийлэх гэрээтэй холбоотой 466 дугаар зүйлийг зарим өөрчлөлттэйгээр хуулийн төсөлд тусгалаа. Тодруулбал, 466 дугаар зүйлийн 466.1 дэх хэсгийн зохицуулалт нь тооцоо нийлэх гэрээний үндсэн шинжийг бүрэн дүүрэн илэрхийлэхгүй байна гэж судлаач дүгнэж байгаа тул юун түрүүнд “харилцан бие биедээ үүссэн” гэх нөхцлийг нэмлээ.

Шүүхийн практикт зөвхөн нэг талд үүссэн шаардах эрхийг тооцоо нийлэх гэрээний дагуу хаах боломжтой гэж дүгнэх тохиолдол байна. Гэвч тооцоо нийлэх гэрээ нь Иргэний хуулийн 238 дугаар зүйл буюу харилцан шаардлага бүхий үүргийг тооцож дуусгавар болгох талаар талууд зайлшгүй тохиролцсон байх шаардлагатай онцлог бүхий гэрээ болно. Гэхдээ ингэж шинэчиллээ гээд иргэд болон хуулийн этгээдүүд нэг талд үүссэн шаардлагын хувьд дахин шинэ агуулгаар тохиролцох боломжгүй гэсэн үг биш. Талууд өмнөх үүргийг шинэ үүргээр солихоор тохиролцох боломж бий.

¹⁵ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зарим үйл ажиллагаатай холбоотой хувийн эрх зүйн хууль тогтоомжийн судалгаа. хуульч Л.Анхбаяр, хуульч Э.Мөнх-эрдэнэ. 2025 он

Нөгөөтэйгүүр ийм тохиролцоог шүүхийн зүгээс Иргэний хуулийн 186.1 дэх хэсэгт хамаарах хэлцэл гэж дүгнээд хүлээн зөвшөөрөх практик түгээмэл байна.

Дараа нь 466.1 дэх хэсэгт шаардлага гэж байсныг шаардах эрх болон үүрэг, түүний хүү гэх байдлаар өөрчиллөө. Учир нь шаардах эрх байгаа бол нөгөө талд нь үүнд харгалзах үүрэг зайлшгүй байх нь тодорхой. Нөгөөтэйгүүр жишээ нь зээлийн гэрээний үүргээ тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан тохиолдолд хүү тооцсон байхыг үгүйсгэхгүй юм. Өөр тохиолдолд жишээ нь зээлээр худалдах, худалдан авах гэрээний үүргийн хувьд мөн адил хүү тохиролцсон байх шаардлага үүснэ. Иймд тооцоо нийлэх гэрээний хувьд нийлмэл хүү буюу хүүгээс хүү тооцож болохыг мөн чанарын хувьд угаас хүлээн зөвшөөрөх шаардлагатай онцлог бүхий гэрээний харилцаа болно.

Мөн шүүхийн практикт иргэд хоорондын харилцаа нь ажил хэргийн харилцаанд хамаарахгүй өөрөөр хэлбэл хоёр тал нь заавал аж ахуй эрхлэгч байх шаардлагатай гэсэн агуулгаар тооцоо нийлэх гэрээний субъектуудыг тайлбарлах явдал гарч байна. Иймд үүнийг тодотгох үүднээс “Гэрээний дор хаяж нэг тал нь аж ахуй эрхлэгч байна.” гэсэн агуулгыг нэмж оруулах нь зохистой гэж үзлээ. Учир нь тооцоо нийлэх гэрээ нь зарим тохиолдолд банк болон түүний харилцагчийн хооронд байгуулагдах боломжтой байдаг тул зөвхөн аж ахуй эрхлэгч нарын хооронд гэж явцуу хүрээнд тайлбарлавал бодит нөхцөл байдалтай төдийлөн нийцэхгүй болж хувирах болно.

Одоогийн 466.6 дахь хэсгийн зохицуулалт нь агуулгын хувьд ойлгомжгүй байх тул ХБНГУ-ын Арилжааны хуулийн 356 дугаар зүйлийн агуулгад түшиглэн хэрэглэхэд ойлгомжтой, хоёрдмол утгагүй байх талаас нь анхаарч шинэчиллээ. Улмаар 466.5 болон 466.6 дахь хэсгийн зохицуулалтыг шинээр боловсруулсан болно.

Харин одоогийн Иргэний хууль дахь 466.3 дахь хэсгийн зохицуулалтыг хаслаа. Учир нь логикийн хувьд ойлгомжтой агуулга байх тул заавал тусгайлан хуульчлах хэрэгцээ, шаардлага байхгүй гэж үзсэн болно.

Хорин хоёрдугаар бүлэг.Бусад зүйл

Хууль хүчин төгөлдөр болох огноо нь ... оны ... дүгээр сарын ...-ний өдөр байна.

Арилжааны хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан хуулийн төслүүд

Нэг.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Арилжааны хуулийн төслийг боловсруулсантай холбогдуулан Иргэний хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг орууллаа.

Юун түрүүнд Түрээсийн гэрээг Арилжааны хууль руу шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн. Энэ нь ХБНГУ-ын Иргэний хуулийн бүтэц, үүргийн эрх зүйн тусгай ангийн агуулгад суурилсан болно. Гэхдээ түрээсийн гэрээний хувьд “аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж” гэх хэсгийг хасаж, Иргэний хуулийн 318.1 болон 318.2 дахь хэсгийн агуулгыг нэгтгэсэн. Энэ нь эд хөрөнгө хөлслөх гэрээ болон түрээсийн гэрээг ялгах гол шинжийг илүү тодорхой

болгох ач холбогдолтой юм. Түүнчлэн 318.3 дахь хэсгийн агуулгыг өөрчилж, бичгээр байгуулах хэлбэрийн шаардлагыг тавихаар тусгасан. Энэхүү түрээсийн гэрээний өөрчлөлттэй холбогдуулан академик түвшинд шууд бус үр шим гэх ойлголтыг зарим сурах бичигт хүлээн зөвшөөрдөг нөхцөл байдлыг харгалзан үзэж ХБНГУ-ын Иргэний хуулийн агуулгад тулгуурлан Иргэний хуулийн 88.3 дахь хэсэгт шинэ зохицуулалт нэмсэн. 88.3, 88.4 дэх хэсгийг дугаарлалтыг 88.4, 88.5 болгон өөрчилнө. 88.1 дэх хэсгийн хувьд “бүтээгдэхүүн” гэх үг орсон байгаа нь тухайн үр шимийн утга агуулгыг ойлгомжгүй болгож байх тул өөрчилсөн.

Түүнчлэн Иргэний хуулийн 3.3 дахь хэсгийн зохицуулалт ихээхэн ойлгомжгүй агуулгатай байх тул Арилжааны хуулийн төсөл боловсруулсантай холбогдуулан *lex specialis derogat legi generali* гэх зарчимд тулгуурлан 3.3 дахь хэсгийн агуулгыг өөрчлөн найруулав.

Мөн Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1.1 болон 255.2 дахь хэсгийн агуулгыг ХБНГУ-ын Иргэний хуулийн 442 дугаар зүйлийн агуулгад суурилан өөрчлөн найрууллаа.

Иргэний хуулийн 257 дугаар зүйлийн агуулга нь худалдан авагч талын эрхийг хязгаарласан, явцууруулсан шинжтэй байх тул худалдан авагч талын эрхийг хамгаалах үүднээс өөрчлөн найруулсан. Өөрөөр хэлбэл доголдолтой тохиолдолд худалдагч заавал хариуцлага хүлээдэг байх үзэл баримтлалд суурилсан гэсэн үг.

Хуулийн төслийг Арилжааны хууль гэж нэрлэсэн тул Иргэний хуулийн 274, 275 дугаар зүйлийн агуулгыг “солилцооны” гэж өөрчилсөн болно.

237 дугаар зүйлийн 237.1 дэх хэсэгт “үүрэгтэй” гэж заасан байгааг “шилжүүлж болно” гэж өөрчилсөн. Учир нь өөрөө хадгалах боломжтой тохиолдолд заавал хадгалалтад шилжүүлэхийг үүрэг болгох зохисгүй гэж үзлээ. Иргэний хуулийн 224.2 дахь хэсэгт хадгалсантай холбоотой зардлыг нөхөн төлөхийг хугацаа хэтрүүлсэн үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах боломжийг үүрэг гүйцэтгэгчид олгосон байгааг мөн харгалзан үзэх шаардлагатай. Уг өөрчлөлттэй холбогдуулан ХБНГУ-ын Иргэний хуулийн 372 дугаар зүйлийг харьцуулан үзнэ үү.

Иргэний хуулийн 251.3 дахь хэсгийн агуулгыг шүүхийн практик зөвхөн тухайн хэсгийг л доголдолтой гэж үзнэ гэх агуулгаар бус, бүхэлдээ доголдолгүй гэх байдлаар буруу тайлбарлан хэрэглэж байх тул ХБНГУ-ын Иргэний хуулийн агуулгад тулгуурлан ялимгүй буюу үүргийн гүйцэтгэлд ноцтой нөлөө үзүүлэхээргүй бол “худалдан авагч гэрээнээс татгалзаж болохгүй” гэх агуулгыг 251.3 дахь хэсэгт тусгасан.

Иргэний хуулийн 256 дугаар зүйлийн 256.1 хэсгийн дагуу худалдагчид гэрээнээс татгалзах боломжийг олгосон байгаа нь ойлгомжгүй байх тул “худалдагч, худалдан авагчийн аль нь ч” гэснийг “худалдан авагч” гэж өөрчилсөн болно.

Иргэний хуулийн 259.3 дахь хэсгийг ХБНГУ-ын Арилжааны хуулийн 379 дүгээр зүйлийн 379.2 дахь хэсгийн агуулгад суурилан өөрчилсөн болохыг өмнө дурдсан.

Түүнчлэн арилжааны эрх зүйн нэр томъёо, агуулгыг тусгасан байх тул Иргэний хуулийн 42.3, 196.1.7, 196.2, 196.3, 200.4, 255.1.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцохоор тусгалаа.

Иргэний хуулийн III хэсэг буюу Гэрээний эрх зүйгээс хэд хэдэн гэрээний хувьд хамгийн багадаа нэг тал нь заавал арилжаа эрхлэгч байх буюу арилжааны хэлцэл болох гэрээнүүдийг мөн ялгаж, зарим хэсэгт зохих нэмэлт, өөрчлөлтийг хийж Арилжааны хуулийн төсөлд тусгасан. Иргэний хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дээрх шалтгаанаар хүчингүй болгоно:

- 42 дугаар зүйлийн 42.3
- 196 дугаар зүйлийн 196.1.7, 196.2, 196.3
- 200 дугаар зүйлийн 200.4
- 255 дугаар зүйлийн 255.1.2
- Барьцаалан зээлдүүлэх журмаар болон иргэнээс байнга, ашиг олох зорилгоор зээл олгох 286 дугаар зүйл
- Санхүүгийн түрээс 312-317 дугаар зүйл
- Франчайзын гэрээ, Мерчандайзын гэрээ 333-338¹ дугаар зүйл
- Аялал жуулчлалын гэрээ 370-379 дүгээр зүйл
- Тээвэрлэлтийн гэрээ 380-398 дугаар зүйл
- Илгээмжийн гэрээ 407-409 дүгээр зүйл
- Худалдааны зуучлагч, төлөөлөгч, комисс 413-419 дүгээр зүйл
- Хадгалалтын гэрээний зарим хэсэг, заалт 422.2, 427 дугаар зүйл
- Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ 428-430 дугаар зүйл
- Даатгалын гэрээ
- Зээл тооцооны үүрэг 445-457 дугаар зүйл
- Тооцоо нийлэх 466 дугаар зүйл.

Эдгээр гэрээний хувьд Арилжааны хуулийн төсөлд шилжүүлснээрээ Арилжааны хуулийн хувьд нэрлэсэн гэрээнд хамаарах боловч Иргэний хуулийн хувьд нэрлэгдээгүй гэрээнд хамаарах, эсхүл ерөнхий бусад гэрээний зохицуулалт үйлчлэх /жишээ нь тээвэрлэлтийн гэрээ нь аль аль тал нь иргэн байсан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалтын дагуу шийдвэглэгдэх гэх мэт/ үр дагавартай.

Хоёр.Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн төсөл

Арилжааны хуулийн төсөлд “Арилжааны бүртгэл нь хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бүрдэнэ.” гэж тусгасан. Иймд үүнд тулгуурлан “Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хууль”-ийн төслийг боловсруулсан. Энэхүү хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл болно.

Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн төсөл нь дараах бүтэцтэй байна.

- Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл
- Хоёрдугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд шинээр бүртгэх
- Гуравдугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн хувийн хэрэг
- Дөрөвдүгээр бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх
- Тавдугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэлээс хасах

- Зургадугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн улсын бүртгэл хөтлөх байгууллага
- Долдугаар бүлэг.Бусад зүйл

Иймд дор тус хуулийг бүлэг тус бүрээр нь багцлан танилцуулъя.

Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл

Юун түрүүнд хуулийн зорилтыг тусгасан. Энэ нь тус хуулийн бүлэг бүрээр зохицуулж буй харилцааг цогцоор нь хамруулан бичсэн агуулгатай.

Төслийн 2 дугаар зүйлд Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн хууль тогтоомжийн талаар зохицуулсан. Арилжааны хууль нь тус бүртгэлийн хувьд хамгийн гол эх сурвалж нь болно. Учир нь Арилжааны хуулийн төсөлд тусгасан агуулгад тулгуурлан тус Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн агуулгыг тодорхойлно. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хууль нь төрөлжсөн бүртгэлийн талаар зохицуулсан байх тул тус хуулийн хувьд чухал эх сурвалж болно.

Мөн хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг 3 дугаар зүйлд тусгасан бол хэн бүртгүүлэх боломжтой талаар 4 дүгээр зүйлд зохицуулсан. Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн төслийн хувьд Арилжааны хуульд заасан арилжааны үйл ажиллагааг эрхэлж эхэлсэн үеэс хувь хүн бүртгүүлэх эсхүл арилжааны үйл ажиллагаа эрхэлдэггүй боловч Арилжааны хуулийн төсөлд заасны дагуу сайн дураар бүртгүүлэх боломжтой хувь хүмүүс уг бүртгэлд бүртгүүлснээр хувиараа арилжаа эрхлэгч болох боломжийг олгосон /сайн дураараа бүртгүүлсэн тохиолдолд бүртгэл нь конститутив үр дагавартай байна/.

Бүртгэлийг цаасан болон цахим хэлбэрээр авах боломжтой байхаар хуулийн төсөлд тусгасан. Энэ нь хувиараа арилжаа эрхлэгч нарын хувьд чирэгдэл учруулахгүй байх, цаг зав, зардал хэмнэх зорилготой.

Хоёрдугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд анхлан бүртгэх

Энэ бүлэгт хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэлд анхлан бүртгэх тохиолдлын талаар зохицуулсан. Анхлан бүртгэхдээ бүртгүүлэх өргөдлийг холбогдох баримт бичгийн хамт бүрэн гүйцэд хүлээн авснаас хойш өргөдөл гаргагчийг бүртгэх эсэх талаар ажлын 2 өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ гэх байдлаар журамласан. Мөн бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар тухайн мэдэгдэлд дурдахыг зохицуулсан.

Мөн энэ бүлгээр арилжааны нэрийн бүртгэлийн талаар зохицуулсан. Арилжааны хуулийн төсөлд тусгаснаар хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ бүртгүүлсэн тохиолдолд л арилжааны нэрээ бусад хувь хүнд ашиглуулж, шилжүүлж, өв залгамжлуулах боломж нээгдэнэ. Иймд үүнтэй холбогдуулан Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн төсөлд арилжааны нэрээ бусад хувь хүнд ашиглуулсны, шилжүүлсний, өвлүүлсний бүртгэлийн талаар тус тус зохицуулсан. Арилжааны нэр нь амины эрхийн төдийгүй хөрөнгийн шинжийг өөртөө агуулна гэж нийтлэг байдлаар олон улсад тайлбарлагдах нь бий. Гэвч улс орнууд ямар тохиолдолд, ямар шалгуураар хөрөнгийн шинжийг нь бий болгох талаар харилцан адилгүй бөгөөд маргаан бүхий байсаар иржээ. Арилжааны хуулийн төсөлд арилжааны

нэрийг бүртгүүлснээр хөрөнгийн шинжийг нь ашиглах боломжийг хувь хүнд олгосон. Энэ нь арилжааны нэрийн бүртгэлийн ач холбогдлыг тодруулсан буюу бүртгүүлээгүй болон бүртгүүлсэн тохиолдлын ялгааг тодорхой болгосон гэж үзэж байна.

Гуравдугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн хувийн хэрэг

Хувийн хэргийг бүрдүүлэн хадгалах нь манай улсын бүртгэлийн тогтолцооны хувьд нийтлэг байдлаар хэрэгждэг. Иймд бүртгэлийн байгууллага нь хувиараа арилжаа эрхлэгчийн хувийн хэргийг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлж мэдээллийн санд хөтөлнө.

Дөрөвдүгээр бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх

Хувиараа арилжаа эрхлэгчийн улсын бүртгэлд бүртгэлтэй мэдээлэлд өөрчлөлт орсон бол арилжаа эрхлэгч тухай бүр нэн даруй тус өөрчлөлтийг улсын бүртгэлд тусгуулах үүргийг хүлээх бөгөөд хувиараа арилжаа эрхлэгч улсын бүртгэлд бүртгүүлсэн мэдээлэлд өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргаж байгаа бол мэдээлэл өөрчлөгдсөнийг нотолсон баримтыг хавсаргахаар тусгасан.

Тавдугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийг бүртгэлээс хасах

Хувиараа арилжаа эрхлэгчийг тухайн бүртгэлээс ямар тохиолдолд хасах болохыг Арилжааны хуулийн төсөлтэй уялдуулан тусгасан.

Зургадугаар бүлэг.Хувиараа арилжаа эрхлэгчийн улсын бүртгэл хөтлөх байгууллага

Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим улсын хэмжээнд хөтлөхөөр зохицуулсан. Мөн тус бүлэгт бүртгэлийн байгууллагын чиг үүргийг тусгасан. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд зааснаар “танхим нь аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдаа, үйлдвэрлэл эрхлэхтэй холбогдсон нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор байгуулсан ашгийг төлөө бус хуулийн этгээд” байх тул энэ үндсэн чиг үүрэг нь хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийг хөтлөхөд тохиромжтой этгээд болохыг илтгэж байна гэж үзсэн.

Долдугаар бүлэг. Бусад зүйл

Энэ бүлэгт гомдол хянан шийдвэрлэх, хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх, хууль хүчин төгөлдөр болох талаар тусгасан.

Гурав.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Арилжааны хуулийн төслийг боловсруулсантай холбоотойгоор хуулиудын уялдаа холбоог хангах үүднээс Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуульд дараах нэмэлтийг оруулсан. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ашгийн төлөөх хуулийн этгээд буюу компани, нөхөрлөлийн бүртгэл нь арилжааны бүртгэлд хамаарах тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2.1 дэх хэсэгт “Арилжааны хууль”-ыг нэмж өгсөн.
- Ашгийн төлөөх хуулийн этгээд буюу компани, нөхөрлөлийн нэрийн баталгаажуулалт хийхэд Арилжааны хуульд заасан арилжааны нэрийн зохицуулалт мөн хамаарах тул “Арилжааны хуулийн 11 дүгээр зүйл”-д заасан шаардлагыг мөн хангах талаар нэмж өгсөн.
- Хувиараа арилжаа эрхлэгчийн нэрийн баталгаажуулалт нь Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалттай төстэй харилцаа тул Хуулийн этгээдийн болон хувиараа арилжаа эрхлэгчийн нэрийн баталгаажуулалтын журмыг Засгийн газар батлахаар нэмж өгсөн.

Дөрөв.Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Нөхөрлөл нь Арилжааны хуулийн төсөлд заасны дагуу эрх зүйн хэлбэрийн хувьд арилжаа эрхлэгч болох этгээдэд хамаарах тул Нөхөрлөлийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийг “Нөхөрлөл оноосон нэртэй байна. Нөхөрлөлийн оноосон нэр нь бусад хуулийн этгээдийн нэр, хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны нэртэй давхардаагүй байна” гэж өөрчлөн найруулсан. Хуулийн этгээдийн хувьд тухайн хуулийн этгээдийн нэр нь өөрөө арилжааны нэр байх боломжтой. Нөгөөтэйгүүр хуулийн этгээдийн нэр нь арилжааны нэрээс өргөн агуулгатай байх тул “бусад хуулийн этгээдийн нэр” гэх байдлаар, харин хувиараа арилжаа эрхлэгчийн хувьд арилжааны нэрийг тусгасан.

Тав.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Компанийн нэр, хуулийн этгээдийн нэр, арилжааны нэр зэрэг хоорондоо төсөөтэй боловч ялгаатай ойлголтууд гарч ирж байгаа тул үүнтэй холбогдуулан өөрчлөлт оруулсан. Ингэхдээ компанийн нэр нь бусад хуулийн этгээдийн болон арилжааны нэрээ бүртгүүлсэн хувиараа арилжаа эрхлэгчийн нэртэй давхардаж болохгүй гэсэн агуулгыг нэмж өгсөн.

Зургаа.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Санхүүгийн түрээсийн гэрээний харилцааг Иргэний хуулиас гадна Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд эдгээр хуулиудад санхүүгийн түрээсийн гэрээг ялгаатай байдлаар тодорхойлсон байгааг уялдуулж Иргэний хууль дахь санхүүгийн түрээсийн гэрээний заалтуудыг Арилжааны хуулийн төслийн 10 дугаар бүлэгт оруулахдаа хуулиудын уялдааг хангаж зарим өөрчлөлтүүдийг тусгасан.

Юун түрүүнд Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 2 дугаар зүйлд Санхүүгийн түрээсийн хууль тогтоомжид Арилжааны хуулийг нэмсэн. Мөн 5 дугаар зүйлд Арилжааны хуульд зарим зохицуулалтыг шилжүүлсэнтэй холбогдуулан зарим өөрчлөлтийг хийсэн.

Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Түрээслүүлэгч, түрээслэгчийн аль нэг нь гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд гэрээнээс татгалзах, ийнхүү татгалзсанаас үүсэх үр дагаврыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг Иргэний хуулийн 204, 205 дугаар зүйлд заасны

дагуу зохицуулна.” гэж заасан байгаа нь үргэлжилсэн шинжтэй үүргийн эрх зүйн харилцааны хувьд тохиромжгүй байна гэж үзсэн тул дараах байдлаар өөрчлөн найруулсан.

16.2.Түрээслүүлэгч, түрээслэгчийн аль нэг нь гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд ийнхүү цуцалснаас үүсэх үр дагаврыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцаанд Иргэний хуулийн 295.1, 295.4 болон бусад холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ.

Мөн Иргэний хуулиас Арилжааны хуульд зарим зохицуулалтыг шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн шилжсэн зохицуулалтыг эшлэсэн хэсгийг өөрчилсөн.

Долоо.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай

Арилжааны хуулийн хуулийн төсөл боловсруулагдсантай холбоотойгоор Хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэн нь хувиараа арилжаа эрхлэгч болох тул мөн бүртгүүлэх шаардлагатай. Иймд “байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн бол хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлсэн байх” гэсэн хэсгийг нэмж өгсөн.

Түүнчлэн мөнгөн зээлийн үйл ажиллагаа нь бүхэлдээ арилжааны үйл ажиллагаа болох тул Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж нь мөн Арилжааны хуулиас бүрдэх ба “Арилжааны хууль” гэж нэмж өгсөн.

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн нэрийг Арилжааны хуульд заасан нэрийн зохицуулалттай уялдуулж “Хэрэв зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн арилжааны нэртэй бол үйл ажиллагаандаа арилжааны нэрээ хэрэглэж болно.” гэсэн хэсгийг нэмж өгсөн.

Найм.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Ес.Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арав.Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван нэг.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван хоёр.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван гурав.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван дөрөв.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Тус хуулийн зохицуулалт нь арилжаа эрхлэгчтэй хамааралтай байх тул өөрслөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван тав.Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван зургаа.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван долоо.Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван найм.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай

Арилжааны хуулийн төслийн зохицуулалт нь тус хуульд зохих хамааралтай байх тул нэмэлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Арван ес.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Хорь.Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Хорин нэг.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

Хорин хоёр.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Иргэний хуулиас зарим зохицуулалтыг Арилжааны хуулийн төсөлд шилжүүлсэнтэй холбогдуулан тус хуульд өөрчлөлт оруулсан. Ингэхдээ Иргэний хуулиас иш татсан холбогдох хэсгийг Арилжааны хууль болгон өөрчилсөн.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРИЛЖААНЫ ХУУЛЬ

I ХЭСЭГ
ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг дэмжих, шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах, арилжааны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Арилжааны хууль тогтоомж, түүнийг хэрэглэх, үйлчлэх хүрээ

2.1.Арилжаа эрхлэхтэй холбоотой харилцааг тухайлсан хуулиар зохицуулна. Арилжаа эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан тухайлсан хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг хэрэглэнэ.

2.2.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол тухайлсан хууль болон энэ хуульд арилжаа эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулснаас бусад харилцааг энэ хуулийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр Иргэний хуулийг хэрэглэнэ.

2.3.Энэ хуулиар зохицуулсан харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулсан бол тухайлсан хуулийг хэрэглэх бөгөөд тухайн харилцааг хэд хэдэн тухайлсан хуулиар зохицуулсан бол илүү нарийвчлан зохицуулсан хуулийг хэрэглэнэ.

2.4.Тухайлсан хууль болон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг арилжааны заншил, талуудын хооронд тогтсон практикийн дагуу, тийм заншил, практик байхгүй, эсхүл талууд түүнийг хэрэглэхгүй талаар хүсэл зоригоо тодорхой илэрхийлсэн тохиолдолд энэ хуулийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр Иргэний хуулийг хэрэглэнэ.

2.5.Арилжааны заншил /ажил хэргийн хүрээнд тогтсон заншил/ гэж талууд гэрээ байгуулах үедээ мэдэж байсан, эсхүл мэдэх ёстой байсан тухайн төрлийн гэрээний харилцаанд оролцогчид нийтээр хүлээн зөвшөөрч, тогтмол дагаж мөрддөг бөгөөд хууль болон талуудын гэрээ, хэлцлийн агуулгад харшлаагүй дадлыг ойлгоно.

2.6.Талуудын хооронд тогтсон практик гэж хуульд заавал дагаж мөрдөх шинжтэй хэм хэмжээгээр зохицуулаагүй харилцааны талаар талуудын хэлэлцэн тохиролцсон, хоорондын харилцаандаа тогтоож мөрддөг аливаа дадлыг ойлгоно.

2.7.Талууд харилцан тохиролцсон бол хуульд заавал дагаж мөрдөх шинжтэй хэм хэмжээгээр зохицуулаагүй хоорондын харилцааны талаар олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ, олон улсын худалдааны практикт хүлээн зөвшөөрөгдсөн загвар гэрээ, түүний тогтсон тайлбарыг харгалзан үзэж болно.

2.8.Талуудын хооронд тогтсон практик, арилжааны заншил, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээ, олон улсын худалдааны практикт хүлээн зөвшөөрөгдсөн загвар гэрээ болон түүний тогтсон тайлбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хуульд нийцээгүй, эсхүл харшилсан гэж Үндсэн хуулийн цэцээс, эсхүл шүүхээс тогтоосон шийдвэр байгаа бол хэрэглэхгүй.

2.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн дагуу гэрээг байгуулах хүртэлх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй. Хуульд өөрөөр заагаагүй бол дээрх хууль тогтоомжийн дагуу байгуулах гэрээнд энэ хуулийг хэрэглэнэ.

2.10.Арилжааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Иргэний хууль, энэ хуулийн 2.1-д заасан тухайлсан хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.11.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Арилжааны эрх зүйн зарчим

3.1.Арилжааны эрх зүйн харилцаанд Иргэний хуульд заасан зарчмыг хөндөхгүйгээр дараах зарчмыг баримтална:

3.1.1.арилжаа эрхлэгчийн ашгийн төлөөх зорилгыг хангах;

3.1.2.гадаад нөхцөл байдалд үнэнч шударгаар итгэсэн итгэлийг хамгаалах;

3.1.3.арилжаа эрхлэгч нь үүргээ биелүүлэхдээ мэргэшсэн, хариуцлагатай хандах;

3.1.4.арилжааны үйл ажиллагааны хялбар, шуурхай байдлыг хангах.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан зарчим нь дараах байдлаар хэрэгжинэ:

3.2.1.арилжааны хэлцэлд талууд хүүгийн хэмжээг тохиролцоогүй бол хуульд заасан хүүгийн хэмжээг баримтлан хүү тооцох;

3.2.2.арилжаа эрхлэгч ажил, үйлчилгээ үзүүлсэн, эсхүл бусдын үүргийг гүйцэтгэсэн бол зохих хөлс шаардах;

3.2.3.арилжааны үйл ажиллагаанд хамаарах ажил үүргийг гүйцэтгэж байгаа ажилтныг арилжаа эрхлэгчийг төлөөлөх бүрэн эрхтэйд тооцох;

3.2.4.арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлийн мэдээллийг үнэн зөв мэдүүлэх, мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр бүртгэлд тусгуулах;

3.2.5.арилжаа эрхлэгчийн олон нийтэд нээлттэй арилжааны бүртгэлийн мэдээллийг үнэн зөв гэж тооцох;

3.2.6.арилжаа эрхлэгч нь арилжааны үйл ажиллагаатай холбоотойгоор төлөхөөр тохиролцсон анзын хэмжээг бууруулахгүй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧ

4 дүгээр зүйл.Арилжаа эрхлэгч

4.1.Арилжааны үйл ажиллагааг өөрийн нэрийн өмнөөс эрхэлдэг хувь хүн болон хуулийн этгээд нь арилжаа эрхлэгч байна.

4.2.Арилжааны үйл ажиллагаа нь ашиг олох зорилгоор байнга эрхлэх, бие даасан, гадагш чиглэсэн, хуулиар хориглоогүй аж ахуйн аливаа үйл ажиллагаа байна.

4.3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлд компани, нөхөрлөл, хоршоо хэлбэрээр бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбоо, сан хэлбэрээр бүртгүүлсэн хуулийн этгээд нь хууль болон дүрэмд заасны дагуу үндсэн зорилгоо дэмжих зорилгоор арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа бол арилжаа эрхлэгчид тооцно.

4.4.Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн энэ хуулийн 4.2-т заасан үйл ажиллагааг эрхлэн явуулж эхэлсэн үеэс хувиараа арилжаа эрхлэгч болно. Хувиараа арилжаа эрхлэгч нь иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байна.

4.5.Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны хүн энэ хуулийн 4.2-т заасан арилжааны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд уг үйл ажиллагааг эрхлэн явуулж эхлэхээсээ өмнө хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулж арилжааны бүртгэлд бүртгүүлнэ.

4.6.Энэ хуулийн 4.4-т заасан арилжаа эрхлэгч нь хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй. Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд бүртгүүлээгүй нь түүнийг арилжаа эрхлэгч биш гэж үзэх үндэслэл болохгүй.

4.7.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны үйл ажиллагаанаас үүсэх үр дагаврыг арилжааны бүртгэлд эд хөрөнгийн хариуцлага хүлээхгүйгээр бүртгүүлсэн хөрөнгөөс бусад хөрөнгөөр бүрэн хариуцна.

4.8.Мал аж ахуй, газар тариалан, хүлэмжийн аж ахуй зэрэг хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйн зэрэг анхдагч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэлж байгаа хувь хүн энэ хуульд заасан арилжаа эрхлэгчид хамаарахгүй.

4.9.Арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь арилжааны үйл ажиллагаанаас үүсэх үр дагаврыг хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрээс хамааран холбогдох хуульд заасны дагуу хариуцна.

4.10.Арилжааны бүртгэлд бүртгэлтэй аливаа этгээд өөрийн эрхлэн явуулдаг аж ахуйн үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагаанд хамаарахгүй гэж маргах эрхгүй.

4.11.Хувиараа арилжаа эрхлэгч нь орлого, зарлага, ашиг, алдагдал, өөрийн хөрөнгийн хэмжээг тооцоолох, хянах зорилгоор орлого, зарлагаа бүртгэж, бусдад худалдсан бараа, эсхүл үзүүлсэн үйлчилгээний орлого болон арилжааны үйл ажиллагаатай холбоотой зарлага гарсныг нотлох гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт зэргээр нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлж, журналд тэмдэглэх, баланс гаргах үүрэг хүлээнэ.

4.12.Арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэг хүлээнэ.

Тайлбар: -Энэ хуульд заасан “гадагш чиглэсэн” гэж зах зээлд үйл ажиллагаагаа буюу бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээгээ санал болгохыг ойлгоно.

-“байнга эрхлэх” гэж тухайн үйл ажиллагаа нь үргэлжилсэн, дахин давтагдах шинжтэй байхыг ойлгоно.

5 дугаар зүйл.Арилжааны бүртгэлд сайн дураар бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болох этгээд

5.1.Энэ хуулийн 4.2-т заасан шинжийг хангаагүй үйл ажиллагаа эрхлэгч хувь хүн нь энэ хуульд заасан арилжааны бүртгэлд сайн дураар бүртгүүлж арилжаа эрхлэгч болж болно.

5.2.Энэ хуулийн 4.8-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг этгээд сайн дураараа арилжааны бүртгэлд бүртгүүлснээр арилжаа эрхлэгч болж болно.

5.3.Хувиараа арилжаа эрхлэгчийн өмнөх санхүүгийн жилийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ, эсхүл арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлээд нэг санхүүгийн жил өнгөрөөгүй байгаа тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа явуулж эхлэх үеийн балансад тусгагдсан нийт хөрөнгийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хэмжээнээс доогуур байвал түүнийг жижиг арилжаа эрхлэгч гэж үзнэ.

5.4.Жижиг арилжаа эрхлэгчид энэ хуулийн 4.5, 4.11, 6 дугаар зүйл, 7 дугаар зүйл, 8.2, 10.2, 10.7, 11.2 дахь хэсэг хамаарахгүй.

5.5.Энэ хуулийн 5.3-т заасан шаардлагыг хангасан эсэхээ арилжаа эрхлэгч өөрөө нотлох үүрэгтэй.

5.6.Жижиг арилжаа эрхлэгч нь арилжааны бүртгэлд сайн дураараа бүртгүүлж болно.

5.7.Жижиг арилжаа эрхлэгч энэ хуулийн 5.6-д заасны дагуу сайн дураараа бүртгүүлсэн бол түүнд энэ хуулийн 5.4, 5.5 дахь хэсэг хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ АРИЛЖААНЫ БҮРТГЭЛ

6 дугаар зүйл.Арилжааны бүртгэл

6.1.Арилжааны бүртгэл нь хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон ашгийн төлөө хуулийн этгээдийн улсын бүртгэлээс бүрдэнэ.

6.2.Хувиараа арилжаа эрхлэгчийн төрөлжсөн бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн харилцааг хуулиар зохицуулна.

6.3.Бүртгэлийн байгууллага арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд шинээр бүртгүүлсэн болон хасагдсан, бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт орсон тухай нийтэд мэдээлнэ.

6.4.Арилжааны бүртгэл дэх арилжаа эрхлэгчийн мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх болон хаалттай байх мэдээллээс бүрдэнэ.

6.5.Арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгэгдэх мэдээллийн төрөл, нээлттэй болон хаалттай байх мэдээллийн агуулга, бүртгэл хөтлөх журмыг холбогдох хуулиар зохицуулна.

6.6.Хувиараа арилжаа эрхлэгч дахин давтагдашгүй бүртгэлийн дугаартай байна. Энэ хуулийн 9 дүгээр зүйлийг тус бүртгэлийн дугаарын хувьд нэгэн адил хэрэглэнэ.

6.7.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол бүртгэгдсэн болохыг илэрхийлсэн “Х.А.Э” буюу хувиараа арилжаа эрхлэгч гэсэн ялгах тэмдгийг арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа хэрэглэнэ.

6.8.Арилжааны бүртгэл нь хуульд заасан хүрээнд ил тод, нээлттэй байна.

7 дугаар зүйл.Арилжааны бүртгэлийн үр дагавар

7.1.Арилжааны бүртгэл дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр арилжаа эрхлэгч зохих өөрчлөлтийг арилжааны бүртгэлд тусгуулж, арилжааны бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах үүрэгтэй. Арилжааны бүртгэлд холбогдох өөрчлөлтөө тусгуулаагүйгээс гарах үр дагаврыг арилжаа эрхлэгч хариуцна.

7.2.Арилжаа эрхлэгч заавал бүртгүүлэх мэдээллийг бүртгүүлээгүй бол тухайн мэдээллийн талаар мэдээгүй гуравдагч этгээдийн эсрэг тус бүртгүүлээгүй мэдээллийг ашиглах эрхгүй.

7.3.Арилжаа эрхлэгч санаатай, эсхүл болгоомжгүйгээр арилжааны бүртгэлд буруу ташаа мэдээлэл бүртгүүлсэн бол тухайн бүртгэлийн зөрүүтэй байдлын талаар мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдийн хувьд хэлцэл хийх үед олон нийтэд нээлттэй байсан арилжааны бүртгэлийн мэдээллийг үнэн зөв гэж тооцно.

7.4.Гуравдагч этгээд нь арилжааны бүртгэлд бүртгэгдээгүй мэдээллийн талаар, эсхүл арилжааны бүртгэл дэх нээлттэй мэдээлэл буруу ташаа, зөрүүтэй байсан талаар мэдэж байсан, эсхүл илт болгоомжгүйгээс мэдээгүй бол энэ хуулийн 7.2, 7.3 дахь хэсэг үйлчлэхгүй. Энэ тохиолдолд бүртгүүлэх үүрэг хүлээсэн арилжаа эрхлэгч тухайн мэдээллийг гуравдагч этгээд мэдэж байсан, эсхүл илт болгоомжгүйгээс мэдээгүй болохыг нотлох үүрэгтэй.

7.5.Арилжаа эрхлэгч арилжааны бүртгэлд заавал бүртгүүлэх мэдээллийг зохих журмын дагуу бүртгүүлсний дараа тухайн мэдээллийг гуравдагч этгээдийн эсрэг ашиглах эрхтэй болно. Бүртгэгдсэн мэдээлэл нь зүй ёсны шалтгааны улмаас энэ талаар мэдээгүй, эсхүл мэдэх боломжгүй байсан гуравдагч этгээдийн хувьд эрх зүйн үр дагавар үүсгэхгүй.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасан тохиолдолд гуравдагч этгээд нь зүй ёсны шалтгааны улмаас энэ талаар мэдээгүй гэдгээ нотлох үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АРИЛЖААНЫ НЭР

8 дугаар зүйл.Арилжааны нэр

8.1.Арилжаа эрхлэгч нь хэлцэл хийх, арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулахдаа өөрийн арилжааны нэрийг хэрэглэнэ. Арилжааны нэр нь арилжаа эрхлэгч нэхэмжлэл гаргах, хариуцагчаар татагдах тохиолдолд хэрэглэгдэж болно.

8.2.Хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ төрөлжсөн бүртгэлд бүртгүүлж болно.

8.3.Арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн нэр байна.

8.4.Аливаа этгээд өөрийгөө арилжаа эрхлэгч гэж бусдыг төөрөгдүүлэхээр нэр, ялгах тэмдэг, цахим хаяг, цахим платформ ашиглахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Шударга бусаар бусдын арилжааны нэрийг ашиглахыг хориглох

9.1.Аливаа этгээд шударга бус зорилгоор бусад арилжаа эрхлэгчийн арилжааны нэртэй давхардсан, эсхүл бусдыг төөрөгдүүлэхүйц ижил, төсөөтэй нэр ашиглахыг хориглоно.

9.2.Арилжаа эрхлэгч арилжааны нэрийг энэ хуулийн 9.1-д заасныг зөрчиж ашигласан этгээдийн эсрэг уг үйлдлийг таслан зогсоох, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Хохирол нөхөн төлүүлэхээр шаардах тохиолдолд Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ.

Тайлбар: -Энэ хуульд заасан “төөрөгдүүлэхүйц ижил, төсөөтэй” гэж арилжааны нэрийн өмнө болон хойно зохион байгуулалтын хэлбэрийг тусгасан, эсхүл нэрийн хойно тоо бичсэн, эсхүл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэрээр ялган бичсэн, эсхүл бичвэр, хэлбэр, авианы дуудлагын хувьд үгийн үндэс, үеэр төсөөтэй байдлыг ойлгоно.

10 дугаар зүйл.Арилжааны нэрийг бусдад ашиглуулах, шилжүүлэх болон холбогдох хариуцлага

10.1.Хувиараа арилжаа эрхлэгч өөрийн арилжааны нэрийг бүртгүүлсэн бол арилжааны нэрээ бусад хувь хүнд ашиглуулж, шилжүүлж, өв залгамжлуулж болно.

10.2.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг шилжүүлэх, өв залгамжлуулах тохиолдолд энэ талаар арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй.

10.3.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад ашиглуулах гэрээг бичгээр байгуулж, арилжааны бүртгэлд бүртгүүлэх үүрэгтэй бөгөөд энэ шаардлагыг зөрчсөн гэрээ хүчин төгөлдөр бус байна.

10.4.Хувиараа арилжаа эрхлэгч өөрийн арилжааны нэрээ бусдад ашиглуулсан тохиолдолд өөртэй нь хэлцэл хийсэн гэж төөрөгдөж арилжааны нэрийг ашиглаж байгаа этгээдтэй хэлцэл хийсэн гуравдагч этгээдийн өмнө тухайн хэлцлээс үүссэн үүргийг арилжааны нэрийг ашиглаж байгаа этгээдтэй хамтран хариуцна. Энэ хуулийн 10.3-т заасныг зөрчсөн тохиолдолд нэгэн адил хэлцлээс үүссэн үүргийг арилжааны нэрийг ашиглаж байгаа этгээдтэй хамтран хариуцна.

10.5.Хувиараа арилжаа эрхлэгч арилжааны нэрийг бусдад шилжүүлэх бол арилжааны үйл ажиллагаатай нь хамт, эсхүл өөрийн арилжааны үйл ажиллагааг бүрмөсөн зогсоосны дараа шилжүүлнэ.

10.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны нэрээ бусдад шилжүүлсэн хувиараа арилжаа эрхлэгч нь арилжааны нэрээ шилжүүлсэн өдрөөс хойш нэг жилийн хугацаанд арилжааны нэрийг шилжүүлэн авсан этгээд арилжааны үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг сум, дүүрэгт ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

10.7.Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь тухайн арилжаа эрхлэгчийн арилжааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэх тохиолдолд шилжүүлэн авсан арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

10.8.Энэ хуулийн 10.7-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсны дараа даруй тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авахаас өмнө үүссэн үүргийг хариуцахгүй болохоо арилжааны бүртгэлд бүртгүүлсэн бол тухайн үүргийг гүйцэтгэх үүрэг хүлээхгүй.

10. 10.9.Энэ хуулийн 10.6-д заасан тохиолдолд арилжааны үйл ажиллагаагаа шилжүүлсэн болон шилжүүлэн авсан этгээд нь гуравдагч этгээдэд хандан тухайн арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг шилжүүлэн авагч цаашид хариуцахгүй тухай мэдэгдсэн бол тухайн үүргийг шилжүүлэн авагч гүйцэтгэх үүрэг хүлээхгүй.

10.10.Хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд нь тухайн арилжаа эрхлэгчийн арилжааны нэрийг үргэлжлүүлэн хэрэглэхгүй тохиолдолд ч тухайн арилжааны үйл ажиллагаанаас үүссэн үүргийг өөртөө шилжүүлэн авсан бол тухайн арилжаа эрхлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн арилжааны үйл ажиллагааг шилжүүлэн авагчид хандан үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй. Энэ тохиолдолд Иргэний хуулийн 124 дүгээр зүйлийн зохицуулалтыг нэгэн адил хэрэглэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТӨЛӨӨЛӨХ БҮРЭН ЭРХ

11 дүгээр зүйл.Арилжааны үйл ажиллагаанд төлөөлөх бүрэн эрх

11.1.Арилжаа эрхлэгчийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой төрлийн арилжааны хэлцэл болон хууль ёсны үйлдэл, эсхүл тухайн арилжааны үйл ажиллагаанд хамаарах тодорхой хэлцэл болон хууль ёсны үйлдлийг хийх бүрэн эрхийг арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь бусад этгээдэд олгож болно.

11.2.Хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь энэ хуулийн 11.1-д зааснаас гадна өөрийн эрхлэн явуулдаг арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг бусад этгээдэд олгож болно.

11.3.Арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчөөс энэ хуулийн 11.1-д заасан төлөөлөх бүрэн эрхийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн болон хуулийн этгээдэд бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр олгоно.

11.4.Арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчөөс энэ хуулийн 11.2-т заасан бүрэн эрхийг иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэнд бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр олгоно.

11.5.Арилжааны үйл ажиллагаанд хамаарах ажил үүргийг хөдөлмөр эрхлэлтийн харилцааны үндсэн дээр гүйцэтгэж байгаа ажилтан нь тухайн ажлын байрны чиг үүргийн дагуу гүйцэтгэж байгаа хууль ёсны үйлдэл, байгуулах хэлцлийн хувьд энэ хуулийн 11.3-т заасан итгэмжлэл байгаа эсэхээс үл хамааран арилжаа эрхлэгчийг төлөөлөх эрхтэй гэж үзнэ. Нөхөрлөлийг удирдах, төлөөлөх эрхтэй гишүүн, Компанийн тухай хуулийн 83.8-д заасан гүйцэтгэх захирал үүнд хамаарахгүй.

11.6.Хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь энэ хуулийн 11.2-т заасан арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг бусдад олгосон, эсхүл бүрэн эрхийг дуусгавар болгосон бол энэ талаар арилжааны бүртгэлд тухай бүр бүртгүүлэх үүрэгтэй.

11.7.Хувиараа арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь энэ хуулийн 11.2-т заасан арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрх олгосон талаар арилжааны бүртгэлд бүртгүүлээгүй нь арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрх олгоогүй гэж үзэх үндэслэл болохгүй.

11.8.Итгэмжлэлд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 11.1, 11.2-т заасан төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд, энэ хуулийн 14.5-д заасан ажилтан нь үл хөдлөх эд хөрөнгийг захиран зарцуулах, Иргэний хуулийн 231 дүгээр зүйлд заасан аргаар үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээх, вексель бичих, зээлийн гэрээ байгуулах, аливаа маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөх эрхгүй байна.

11.9.Энэ хуулийн 11.1, 11.2, 11.5-д заасан төлөөлөх бүрэн эрхэд тогтоосон энэ хуулийн 11.8-д зааснаас бусад аливаа хязгаарлалт нь гуравдагч этгээдийн хувьд ямар нэгэн эрх зүйн үр дагавар үүсгэхгүй. Гуравдагч этгээд нь энэ хязгаарлалтын талаар мэдсэн, эсхүл илт болгоомжгүйгээс мэдээгүй бол үүнд хамаарахгүй болно.

11.10.Энэ хуулийн 11.1, 11.2, 11.5-д заасан төлөөлөх бүрэн эрхтэй этгээд нь арилжаа эрхлэгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр төлөөлөх бүрэн эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН АЖИЛТАН

12 дугаар зүйл.Арилжаа эрхлэгчийн ажилтан

12.1.Арилжаа эрхлэгчийн ажилтан гэж арилжаа эрхлэгчтэй хөдөлмөрийн гэрээ болон түүнтэй адилтгах гэрээ байгуулсан, арилжааны үйл ажиллагаанд хамаарах хөдөлмөр эрхэлж байгаа этгээдийг ойлгоно.

12.2.Арилжаа эрхлэгчийн ажилтан нь энэ хуулийн 11.5-д заасны дагуу тухайн ажлын байрны чиг үүргийн дагуу гүйцэтгэж байгаа хууль ёсны үйлдэл, байгуулах хэлцэлд арилжаа эрхлэгчийг төлөөлөх эрхтэй.

13 дүгээр зүйл.Хөдөлмөрийн гэрээ болон түүнтэй адилтгах бусад гэрээ дуусгавар болсны дараа үл өрсөлдөх үүрэг

13.1.Арилжаа эрхлэгч болон ажилтан нь хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос хойш нэг жил хүртэл, эсхүл тодорхой үйл ажиллагаа, үйл явдал болох хүртэлх хугацааны турш ажилтанд үл өрсөлдөх үүргийг хүлээлгэсэн гэрээг бичгээр байгуулж болно. Энэ тохиолдолд гэрээний нэг хувийг ажилтанд хүлээлгэн өгсөн байхыг шаардана.

14 дүгээр зүйл.Үл өрсөлдөх үүрэг хүлээлгэсэн гэрээ хүчин төгөлдөр бус байх

14.1.Үл өрсөлдөх үүрэг хүлээлгэсэн гэрээ дараах тохиолдолд хүчин төгөлдөр бус байна:

14.1.1.арилжаа эрхлэгчийн явуулдаг арилжааны үйл ажиллагааг хамгаалах зайлшгүй шаардлага байхгүй бол;

14.1.2.хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсноос хойш нэг жилээс дээш хугацаагаар өрсөлдөхгүй байх үүрэг ногдуулсан бол;

14.1.3.ажилтан нь өөрийнхөө оронд гуравдагч этгээдэд өрсөлдөхгүй байх үүргийг ногдуулсан бол;

14.1.4.хуульд заасан бусад нөхцөл.

14.2.Энэ хуулийн 14.1.1-д заасан нөхцөлийг тогтоохдоо хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсны дараах ажилтны байр суурь, албан тушаал, гүйцэтгэдэг ажил, үүрэг, арилжаа эрхлэгчийн болон өрсөлдөхгүй байх үүрэг хүлээсэн ажилтан өөрийн арилжааны үйл ажиллагаагаа явуулж байгаа газар нутгийн байршил, хориглосон үйлдэл, үйл ажиллагааны хүрээ зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж, тухайн ажилтны /ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох/ эрхийг зөрчсөн эсэхийг харгалзан шүүх шийдвэрлэнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ АРИЛЖААНЫ ТӨЛӨӨЛӨГЧ

15 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгч

15.1.Арилжаа эрхлэгч /цаашид “үйлчлүүлэгч” гэх/-ийн нэрийн өмнөөс, түүний зардлаар хэлцэл байгуулах, зуучлах үйл ажиллагааг бие даан явуулж байгаа

этгээдийг арилжааны төлөөлөгч гэнэ. Бие даан явуулж байгаа гэдэгт арилжааны төлөөлөгч өөрийн үйл ажиллагаа болон ажлын цагаа чөлөөтэй шийдвэрлэх боломжтой байхыг ойлгоно.

15.2.Үйлчлүүлэгч, арилжааны төлөөлөгч нь энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байгаа эсэхээс үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

15.3.Арилжааны төлөөлөгч нь өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ үйлчлүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр өөр арилжааны төлөөлөгчийг ажиллуулж болно. Энэ тохиолдолд бусдыг ажиллуулж байгаа арилжааны төлөөлөгчийг үйлчлүүлэгч гэж үзнэ.

15.4.Арилжааны төлөөлөгч нь өөрийн үйл ажиллагаагаа бие даан явуулж байгаа гэдгээ нотолж чадахгүй бол түүнийг үйлчлүүлэгчийн ажилтан гэж үзнэ.

15.5.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 11 дүгээр зүйл нь арилжаа эрхлэгчийн нэрийн өмнөөс хэлцэл байгуулах бүрэн эрхтэй арилжааны төлөөлөгчийн хувьд нэгэн адил үйлчилнэ.

16 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчийн үүрэг

16.1.Арилжааны төлөөлөгч нь дараах үүрэгтэй:

16.1.1.үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах;

16.1.2.хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тухай бүр даруй үйлчлүүлэгчид мэдэгдэх;

16.1.3.арилжааны төлөөлөгчийн хувьд ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажиллах;

16.1.4.арилжааны төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн, өөрт нь ил болсон үйлчлүүлэгчийн арилжааны үйл ажиллагаатай холбоотой нууцыг хадгалах;

16.1.5.Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны төлөөлөгч улирал бүрийн сүүлчийн 10 хоногт өөрийн үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээний хөлс зэрэг мэдээлэл бүхий тайланг үйлчлүүлэгчид хүргүүлэх.

17 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн үүрэг

17.1.Үйлчлүүлэгч нь дараах үүрэгтэй:

17.1.1.барааны дээж, зураг, танилцуулга, үнийн жагсаалт, зар сурталчилгааны материал, гэрээний нөхцөл, шаардлагатай мэдээлэл зэрэг арилжааны төлөөлөгч өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлийг ашиглах боломжоор хангах;

17.1.2.арилжааны төлөөлөгчийн зуучилсан хэлцэл, эсхүл хэлцэл байгуулахад төлөөлөх бүрэн эрхгүйгээр байгуулсан хэлцлийг зөвшөөрөх, эсхүл татгалзах эсэх талаар даруй мэдэгдэх;

17.1.3.арилжааны төлөөлөгчийн зуучилсан, эсхүл байгуулсан хэлцлийн хувьд үүргийн зөрчил гарсан тухай бүр арилжааны төлөөлөгчид мэдэгдэх.

18 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчийн хөлс

18.1.Арилжааны төлөөлөгч нь өөрийн үүргийг гүйцэтгэж хэлцэлд зуучилсан, хэлцэл байгуулсан тохиолдолд үйлчлүүлэгчээс хөлс шаардах эрхтэй.

18.2.Арилжааны төлөөлөгч нь арилжааны төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болсон эсэхээс үл хамааран дараах тохиолдолд хөлсөө шаардах эрхтэй:

18.2.1.гэрээнд зуучлах, гэрээ байгуулахад арилжааны төлөөлөгчийн оролцоо голлох нөлөөтэй байсан бөгөөд арилжааны төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ердийн боломжит хугацааны дотор тухайн гэрээг үйлчлүүлэгч гуравдагч этгээдтэй байгуулсан бол;

18.2.2.арилжааны төлөөлөгчийн бүрэн эрх дуусгавар болохоос өмнө арилжааны төлөөлөгч болон үйлчлүүлэгчийн гуравдагч этгээдээс хүлээн авсан арилжааны төлөөлөгчид хөлс шаардах эрх үүсгэхүйц гэрээний саналын үндсэн дээр тухайн гэрээг байгуулсан бол.

18.3.Үйлчлүүлэгчээс хамаарсан шалтгаанаар зуучлалын үндсэн дээр зохих хэлцлийг байгуулаагүй бол, эсхүл гэрээнд заасан нөхцөлийг зохих ёсоор биелүүлээгүй бол арилжааны төлөөлөгч хөлс шаардах эрхтэй.

18.4.Хэлцлийг үйлчлүүлэгчийн бус гуравдагч этгээдээс хамаарсан шалтгааны улмаас байгуулаагүй бол арилжааны төлөөлөгч үйлчлүүлэгчээс хөлс шаардах эрхгүй байна.

18.5.Гуравдагч этгээд үүргээ гүйцэтгэж чадахгүй болох нь тодорхой болсон бол арилжааны төлөөлөгч нь хөлс шаардах эрхээ алдах бөгөөд өмнө авсан хөлсийг үйлчлүүлэгчид буцаан өгнө.

18.6.Гэрээнд өөрөөр заагаагүй бол үйлчлүүлэгч сар бүрийн эцэст арилжааны төлөөлөгчид тохиролцсон үйлчилгээний хөлс төлнө.

18.7.Үйлчилгээний хөлсний хэмжээг талууд харилцан тохиролцоогүй бол үйлчилгээний хөлсийг тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.

18.8.Хөлсийг төлбөр төлөх талын төлбөрийн дүнгээс тооцох бөгөөд төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэсний хөнгөлөлт, төлбөр тооцоо, савлалт, гаалийн хураамж, татвар төлөх болон бусад нэмэлт зардлыг хасаж бодно.

18.9.Нэмэлт зардлыг гуравдагч этгээд хариуцан төлсөн тохиолдолд энэ хуулийн 18.8-д заасан хасагдах зардал хамаарахгүй.

18.10.Гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын гэрээний хувьд арилжааны төлөөлөгчийн хөлсийг даатгалын хураамжаас тооцно.

18.11.Арилжааны төлөөлөгч нь өөрийн зуучилсан, байгуулсан тодорхой хэлцэл, эсхүл гуравдагч этгээдтэй байгуулсан тодорхой хэлцлээс үүсэх бүх үүргийг хариуцахаар үйлчлүүлэгчид урьдчилан бичгээр баталгаа гаргаж тусгай шагнал буюу үүргийн гүйцэтгэлийн баталгаа гаргасны хөлс авч болно.

19 дүгээр зүйл.Арилжааны төлөөлөгчтэй байгуулах гэрээний хугацаа

19.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол тодорхой хугацаатай байгуулагдсан гэрээний талууд гэрээний хугацаа дуусгавар болохоос гурван сарын өмнө түүнийг цуцлах тухай санал гаргаагүй бол гэрээг тодорхойгүй хугацаагаар сунгасанд тооцно.

19.2.Хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд үйлчлүүлэгч болон арилжааны төлөөлөгч нь гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Энэ эрхийг хүчингүй болгох, хязгаарлахыг хориглоно.

20 дугаар зүйл.Арилжааны төлөөлөгчид олгох нөхөн олговор

20.1.Арилжааны төлөөлөгч гэрээ дуусгавар болсны дараа үйлчлүүлэгчээс дараах тохиолдолд нөхөн олговор олгохыг шаардах эрхтэй:

20.1.1.арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болохоос өмнө үйлчлүүлэгч арилжааны төлөөлөгчийн зуучлалаар дамжуулан гуравдагч этгээдтэй гэрээ байгуулсан бөгөөд арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болсны дараа ч тухайн гэрээний харилцаанаас үйлчлүүлэгч үргэлжлүүлэн орлого олсоор байгаа тохиолдолд;

20.1.2.арилжааны төлөөлөгчийн гэрээ дуусгавар болохоос өмнө үйлчлүүлэгчтэй гуравдагч этгээдийн байгуулсан гэрээний харилцааг мэдэгдэхүйц хэмжээнд өргөжүүлсэн тохиолдолд.

20.2.Нөхөн олговор нь арилжааны төлөөлөгчийн үйл ажиллагааны сүүлийн таван жилд авч байсан хөлсний нэг жилийн дундаж, эсхүл сүүлийн нэг жилд олох хөлсний дундаж хэмжээнээс илүүгүй байна. Таван жилээс доош хугацаатай байгуулсан гэрээнд арилжааны төлөөлөгчийн үйл ажиллагааны хугацаанд олж байсан хөлсний дундаж хэмжээнээс тооцно.

20.3.Нөхөн олговор олгохыг шаардах эрхээс татгалзах, гэрээ дуусгавар болохоос өмнө түүнийг урьдчилан олгохыг хориглоно.

20.4.Нөхөн олговор шаардах эрх дараах тохиолдолд үүсэхгүй:

20.4.1.үйлчлүүлэгчээс хамаарсан шалтгаанаар гэрээг цуцалсан, эсхүл арилжааны төлөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болсноос бусад тохиолдолд арилжааны төлөөлөгч нь өөрийн санаачилгаар гэрээг дуусгавар болгосон бол;

20.4.2.арилжааны төлөөлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас үйлчлүүлэгч гэрээг цуцалсан;

20.4.3.үйлчлүүлэгч, арилжааны төлөөлөгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу арилжааны төлөөлөгч өөрийнхөө оронд өөр этгээдийг оруулахаар тохиролцсон тохиолдолд.

20.5.Энэ хуулийн 20.4.3-т заасан хэлцлийг гэрээ дуусгавар болохоос өмнө байгуулж үл болно.

20.6.Нөхөн олговор авах эрхийг гэрээ дуусгавар болсон үеэс эхлэн нэг жилийн дотор хэрэгжүүлнэ.

21 дүгээр зүйл.Арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүрэг

21.1.Арилжааны төлөөлөгч нь үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр өрсөлдөгч этгээдийн ашиг сонирхлыг төлөөлөхийг хориглох бөгөөд харин гэрээ байгуулах үед арилжааны төлөөлөгч нь өрсөлдөгч этгээдийн ашиг сонирхлыг төлөөлж байгааг үйлчлүүлэгч мэдэж байсан бол зөвшөөрөл олгосон гэж үзнэ.

21.2.Арилжааны төлөөлөгч энэ хуулийн 21.1-д заасан нөхцөлийг зөрчвөл үйлчлүүлэгч учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

21.3.Гэрээ дуусгавар болсны дараа үл өрсөлдөх үүрэг хүлээлгэсэн нөхцөлийг гэрээнд тусгасан бол энэ тохиролцоо нь үйлчлүүлэгч нөхөн олговор олгох тохиолдолд хүчинтэй байх бөгөөд нөхөн олговрын хэмжээг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмаар тооцно.

21.4.Гэрээ дуусгавар болсны дараа арилжааны төлөөлөгчийг үйлчлүүлэгчтэй өрсөлдөхийг хориглосон нөхцөлтэй гэрээний хугацаа нэг жилээс илүүгүй байна.

21.5.Энэ зүйлд заасан арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг талууд бичгээр байгуулсан гэрээнд тусгаж, талууд гарын үсэг зурж, тус бүр нэг хувийг хадгална.

21.6.Арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийг тухайн арилжааны төлөөлөгчийн ажиллаж байсан нутаг дэвсгэр, арилжааны төлөөлөгчийн зуучилж, байгуулж байсан хэлцлийн төрөл, харилцаж байсан гуравдагч этгээдийн хүрээ, өрсөлдөгч байгууллагад ажиллах тохиолдлоор хязгаарлана.

21.7.Арилжааны төлөөлөгчийн гэрээний нэг тал нөгөө талын буруугаас шалтгаалан гэрээг цуцалсан бол тухайн гэрээг цуцалснаас хойш нэг сарын дотор арилжааны төлөөлөгчийн үл өрсөлдөх үүргийн тохиролцоог цуцлах талаар нөгөө талд бичгээр мэдэгдсэнээр үл өрсөлдөх үүрэг дуусгавар болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ АРИЛЖААНЫ ЗУУЧЛАГЧ

22 дугаар зүйл.Арилжааны зуучлагч

22.1.Арилжааны хэлцэлд зуучлах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг этгээдийг арилжааны зуучлагч гэнэ.

22.2.Арилжааны зуучлагч нь энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч эсэхээс үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

22.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэлцэл байгуулагдсаны дараа зуучлагч нь гэрээний талуудад хэлцлийн зүйл, нөхцөл, оролцогч тал, бараа, үнэт цаас худалдах худалдан авах гэрээ байсан бол тэдгээрийн төрөл, тоо, хэмжээ, гэрээний үнэ, хугацаа зэргийг тусгасан баримтыг гарын үсэг зурж олгоно.

22.4.Хиймэгц биелэгдэхээс бусад хэлцэлд энэ хуулийн 22.3-т заасан баримт бичигт хэлцлийн талууд гарын үсэг зурна. Тус гарын үсэг зурсан баримтыг хэлцлийн талуудад тус бүр илгээнэ.

22.5.Хэрэв хэлцлийн нэг тал баримтад гарын үсэг зурахаас, эсхүл түүнийг хүлээн авахаас татгалзвал арилжааны зуучлагч нөгөө талд энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

23 дугаар зүйл.Хэлцлийн талыг нэрлэн заагаагүй зуучлагчийн баримт

23.1.Хэлцлийн нэг талын нэрийг заагаагүй арилжааны зуучлагчийн баримтыг нөгөө тал нь хүлээн авсан бол зуучлалын баримтад нэр нь хожим нэрлэн заагдах ёстой талтай гэрээг байгуулсанд тооцно. Харин хэлцлийн талууд үндэслэл бүхий гомдол гаргасан бол энэ хэсэг хамаарахгүй.

23.2.Арилжааны зуучлагч нь зуучлагчийн баримтад нэрлэн заагаагүй талыг тухайн нутаг дэвсгэрийн арилжааны заншилд үндэслэн тогтоосон хугацаанд нэрлэн заах үүрэгтэй. Тогтооёон хугацаа байхгүй тохиолдолд зуучлагч тухайн нөхцөл байдалд тохирсон ердийн боломжит хугацаанд баримтад тусгах үүрэгтэй.

23.3.Арилжааны зуучлагч нь 23.2-т заасан хугацаанд нэрлэн заагаагүй талыг нөгөө талд илэрхий болгоогүй, эсхүл нэрлэгдсэн этгээдийн эсрэг гомдол гаргах зохих үндэслэл байгаа бол нөгөө тал нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг арилжааны зуучлагчаас шаардах эрхтэй. Хэлцлийн талууд нь арилжааны зуучлагчийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш үүргийн гүйцэтгэлийг арилжааны зуучлагчаас шаардах эрхээ хэрэгжүүлэх эсэхээ даруй илэрхийлээгүй бол уг шаардах эрхээ алдана.

24 дүгээр зүйл.Барааны дээжийг хадгалах

24.1.Дээж авах замаар барааг худалдаж байгаа тохиолдолд хэлцлийн талууд тухайн үүргээс зуучлагчийг чөлөөлсөн, эсхүл тухайн хэлцлийн зүйл болох эд юмсын шинж чанараас хамааран тухайн нутаг дэвсгэрийн арилжааны заншлын дагуу зуучлагчийг үүргээс чөлөөлөхөөс бусад тохиолдолд арилжааны зуучлагч нь барааны дээжид тусгай тэмдэг тавих, худалдан авагч барааны чанарт гомдол гаргалгүйгээр хүлээж авах хүртэл дээжийг хадгалах үүрэгтэй.

25 дугаар зүйл.Үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах эрхгүй байх

25.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол арилжааны зуучлагчийг мөнгөн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах болон гэрээгээр тогтоосон бусад үүргийн гүйцэтгэлийг хүлээж авах бүрэн эрхгүй гэж үзнэ.

26 дугаар зүйл.Талуудын өмнө хүлээх хариуцлага

26.1.Арилжааны зуучлагч өөрийн буруугаас үүссэн хохирлыг талуудын өмнө бүрэн хариуцна.

27 дугаар зүйл.Хэлцлийн талуудаас хөлс шаардах эрх

27.1.Арилжааны зуучлагчид олгох зуучлалын хөлсийг талуудын хэн төлөх талаар тохиролцоогүй бөгөөд тухайн нутаг дэвсгэрт өөр арилжааны заншил байхгүй бол гэрээний талууд тогтоосон хөлсийг тэнцүү хэмжээгээр төлөх үүрэгтэй.

28 дугаар зүйл.Арилжааны зуучлагчийн хөтлөх тэмдэглэл

28.1.Арилжааны зуучлагч өдөр бүр дэс дараатай тэмдэглэл хөтөлж, түүнд байгуулсан бүх хэлцлээ бүртгэж, цаасан хэлбэрээр үйлдсэн тохиолдолд тухай бүр гарын үсэг зурах, эсхүл цахим хэлбэрээр үйлдсэн тохиолдолд тоон гарын үсэг зурж баталгаажуулна. Тэмдэглэлийг цаг, минутын дарааллаар хөтөлнө. Тэмдэглэлд энэ хуулийн 22.3-т заасан баримтын агуулгыг тэмдэглэх үүрэгтэй.

28.2.Арилжааны зуучлагч гэрээний талуудын шаардсан үед тэмдэглэлээс зуучлалын тусламжтайгаар байгуулсан хэлцлийн тухай мэдээллийг агуулсан өөрийн гарын үсэгтэй баримтыг олгох үүрэгтэй.

28.3.Арилжааны зуучлагч нь 28.1-д заасан шаардлагыг хангасан тэмдэглэлээ цаасан хэлбэрээр, эсхүл цахим хэлбэрээр үйлдсэн эсэхээс үл хамааран 10 жил хадгалах үүргийг хүлээнэ.

II ХЭСЭГ АРИЛЖААНЫ ХЭЛЦЭЛ

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

29 дүгээр зүйл.Арилжааны хэлцэл

29.1.Арилжааны хэлцэл гэж арилжаа эрхлэгчийн арилжааны үйл ажиллагаанд хамаарах бүхий л хэлцлийг ойлгоно.

29.2.Арилжаа эрхлэгчийн хийсэн хэлцлийг арилжааны үйл ажиллагаанд хамаарах эсэх талаар эргэлзээ үүсвэл тус хэлцлийг арилжааны хэлцэл гэж үзнэ.

30 дугаар зүйл.Нэг талт арилжааны хэлцэл

30.1.Хэлцлийн нэг талын хувьд тухайн хэлцэл нь арилжааны хэлцэл болж байвал арилжааны хэлцлийн талаарх энэ хуулийн зохицуулалтыг тухайн хэлцлийн бүх талуудад нэгэн адил хэрэглэнэ.

30.2.Хэлцлийн нэг талд хэд хэдэн этгээд байгаа тохиолдолд тэдгээрийн нэг нь арилжаа эрхлэгч бол тухайн хэлцэлд энэ хуулийн зохицуулалтыг хэрэглэнэ.

31 дүгээр зүйл.Гэрээний саналыг дуугүй хүлээн зөвшөөрөх

31.1.Бусдад үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг арилжаа эрхлэгч нь ажил хэргийн харилцаа бүхий этгээдээс тухайн төрлийн үйл ажиллагааг гүйцэтгүүлэх тухай саналыг хүлээн авсан бол ердийн боломжит хугацааны дотор хариу явуулах үүрэгтэй.

31.2.Энэ хуулийн 31.1-д заасан санал хүлээн авсан тал ердийн боломжит хугацааны дотор хариу явуулаагүй бол гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

32 дугаар зүйл.Гэрээний саналтай хамт хүлээн авсан барааг хадгалах үүрэг

32.1.Арилжаа эрхлэгч нь өөрийн арилжааны үйл ажиллагааны хүрээнд гэрээ байгуулах саналыг бараатай хамт хүлээн авсан боловч тухайн гэрээний саналд татгалзсан хариу өгсөн бол санал гаргагчийн зардлаар тухайн барааг хадгална.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасан барааны үнэ нь барааг хадгалах зардлаас бага, эсхүл арилжаа эрхлэгчид хадгалалтын улмаас хохирол үүсэхээр бол санал гаргагчийн барааг хадгалах үүрэг хүлээхгүй.

33 дугаар зүйл.Стандарт нөхцөл гэрээний салшгүй хэсэг болох

33.1.Гэрээ байгуулах санал хүлээн авагч тал нь арилжаа эрхлэгч бөгөөд ажил хэргийн онцлогоос хамаарч гэрээний стандарт нөхцөлийг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан бол стандарт нөхцөл нь гэрээний салшгүй хэсэг болно.

34 дүгээр зүйл.Анз

34.1.Арилжаа эрхлэгч нь өөрийн арилжааны үйл ажиллагаатай холбоотойгоор төлөхөөр тохиролцсон анзын хэмжээг Иргэний хуулийн 232.8-д заасны дагуу багасгах эрхгүй.

35 дугаар зүйл.Батлан даалт

35.1.Батлан даалт нь батлан даагчийн хувьд арилжааны хэлцэлд хамаарч байвал Иргэний хуулийн 460.1-д заасныг үл харгалзан үүрэг гүйцэтгүүлэгч батлан даагчаас үүргийн гүйцэтгэлийг шууд шаардах эрхтэй.

36 дугаар зүйл.Гэрээний хэлбэрийн чөлөөт байдал

36.1.Батлан даалт нь батлан даагчийн хувьд, нэгэнт үүссэн үүргийн харилцааг гэрчлэх гэрээ нь үүрэг гүйцэтгэгчийн хувьд арилжааны хэлцэлд хамаарч байвал Иргэний хуулийн 199.1, 459.1-д заасан бичгээр байгуулах хэлбэрийн шаардлага хамаарахгүй.

37 дугаар зүйл.Хуульд заасан хүү

37.1.Хуульд заасан хүүгийн хэмжээ нь хоёр талт арилжааны хэлцлийн хувьд Монголбанкнаас зарласан жигнэсэн дундаж хүүгийн хэмжээтэй тэнцүү байна. Хоёр талт арилжааны хэлцлийн үүргийн хувьд талууд хүүгийн хэмжээг тохиролцоогүй бол хуульд заасан хүүгийн хэмжээг баримтална.

38 дугаар зүйл.Хугацаа хэтрүүлсний хүүгийн хэмжээ

38.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хоёр талт арилжааны хэлцлийн мөнгөн төлбөрийн үүргийн хугацаа хэтрүүлсний хүүгийн хэмжээ нь хуульд заасан хүүгийн хэмжээтэй ижил байна.

39 дүгээр зүйл.Хөлс, шагнал, хүү шаардах эрх

39.1.Өөрийн арилжааны үйл ажиллагааны хүрээнд бусдын төлөө бусдын үүргийг гүйцэтгэсэн, эсхүл ажил, үйлчилгээ үзүүлсэн арилжаа эрхлэгч нь талууд тохиролцоогүй байсан ч зохих хөлс шаардах эрхтэй.

39.2.Зээл, урьдчилгаа төлбөр, бусдын өмнөөс мөнгөн төлбөр төлсөн болон бусад зардал гаргасан арилжаа эрхлэгч нь тухайн төлбөрийг төлсөн, зардлыг гаргасан өдрөөс эхлэн энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан хүү тооцож болно.

40 дүгээр зүйл.Барьцааны зүйлийг худалдан борлуулах

40.1.Хоёр талт арилжааны хэлцлээс үүсэх үүргийг баталгаажуулсан барьцааны гэрээний зүйлийг талууд гэрээгээр харилцан тохиролцсон бол шүүхийн бус журмаар худалдан борлуулж болно.

41 дүгээр зүйл.Хоёр талт арилжааны хэлцлээс үүсэх саатуулан барих эрх

41.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хоёр талт арилжааны хэлцлээс үүссэн үүргийг гүйцэтгэх хугацаа болсон тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь тухайн үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах хүртэл тухайн үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан арилжааны хэлцлээс үүдэн өөрийн эзэмшилд шилжсэн үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлийн эд зүйлс болон үнэт цаасыг саатуулан барих эрхтэй.

42 дугаар зүйл.Хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хамтын хариуцлага

42.1.Хэд хэдэн этгээд тэдний хэн нэгний, эсхүл бүх этгээдийн хувьд арилжааны хэлцэл болох хэлцлийг байгуулж, бусдын өмнө үүрэг хүлээсэн бол тухайн үүргийг хамтран гүйцэтгэх үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь хамтран үүрэг гүйцэтгэгчдийн хэнээс ч үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь шууд шаардах эрхтэй.

АРАВДУГААР БҮЛЭГ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

43 дугаар зүйл.Гэрээний зүйлийн шинж чанарыг тодорхойлох

43.1.Хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний хувьд гэрээний зүйлийн хэлбэр, загвар, өнгө, материал болон эдгээртэй адилтгах бусад шинж чанарыг худалдан авагч тодорхойлохоор талууд тохиролцсон бол худалдан авагч тохиролцсон хугацааны дотор гэрээний зүйлийн шинж чанарыг тодорхойлох үүрэгтэй.

43.2.Худалдан авагч энэ хуулийн 43.1-д заасан үүргээ тохиролцсон хугацааны дотор гүйцэтгээгүй бол худалдагч нь Иргэний хуулийн 225 дугаар зүйлийн дагуу гэрээнээс татгалзах, эсхүл Иргэний хуулийн 219.2-т заасны дагуу үүргийн гүйцэтгэлийн оронд хохирол нэхэмжлэх эрхтэй.

43.3.Гэрээний зүйлийн талаар худалдан авагчийн хүсэл зориг харьцангуй тодорхой бол худалдагч түүнд нийцсэн шинж чанар бүхий гэрээний зүйлийг өөрөө тодорхойлж, энэ талаар худалдан авагчид мэдэгдэж болно. Худалдан авагч ердийн боломжит хугацааны дотор тус мэдэгдлийн талаар хариу ирүүлээгүй бол худалдагч өөрийн тодорхойлсон шинж чанар бүхий эд хөрөнгийг худалдагчид шилжүүлнэ.

44 дүгээр зүйл.Барааны жингээр үнийг тодорхойлох

44.1.Худалдах, худалдан авах гэрээний үнийг барааны жингээр тодорхойлох тохиолдолд гэрээнд өөрөөр заасан, эсхүл үүрэг гүйцэтгэх газарт мөрдөгддөг арилжааны заншилаас өөр байх бусад тохиолдолд тухайн барааны баглаа, сав, боодлын жинг барааны жинд оруулж тооцохгүй.

45 дугаар зүйл.Үүрэг гүйцэтгэх хугацаа заасан худалдах, худалдан авах гэрээ

45.1.Хоёр талт арилжааны хэлцлийн хувьд үүрэг гүйцэтгэх хугацааг тодорхой тогтоосон бөгөөд тухайн хугацаанд үүргийг гүйцэтгээгүй нь гэрээний биелэлтийг үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд ач холбогдолгүй болгохоор байвал хугацаа хоцроосон үүрэг гүйцэтгэгчийг үүргээ заавал гүйцэтгэхийг үүрэг гүйцэтгүүлэгч шаардсанаас бусад тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийг гэрээнээс татгалзсанд тооцно.

46 дугаар зүйл.Нэн даруй шалгах, мэдэгдэх үүрэг

46.1.Худалдах, худалдан авах гэрээ нь хоёр талт арилжааны хэлцэл бол худалдан авагч нь худалдагчийг барааг шилжүүлсэн даруйд ердийн боломжит хугацааны дотор шалгаж, доголдол илэрвэл худалдагчид даруй мэдэгдэнэ.

46.2.Худалдан авагч нь барааг шалгаж, даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол барааг шалгаж хүлээн авсанд тооцох боловч барааны доголдлыг барааг шалгах үед илрүүлэх боломжгүй байсан тохиолдолд барааг шалгаж хүлээн авсанд тооцохгүй.

46.3.Шалгах үед илрүүлэх боломжгүй байсан барааны доголдлыг худалдан авагч хожим илрүүлсэн бол илрүүлсэн даруйд худалдагчид доголдлын талаар мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдэх үүргээ худалдан авагч даруй биелүүлээгүй бол барааны доголдлыг хүлээн зөвшөөрсөнд тооцож, шаардлага гаргах эрхээ алдана.

46.4.Энэ зүйлд заасан мэдэгдлийг худалдан авагч илгээснээр мэдэгдэх үүргээ хэрэгжүүлсэнд тооцно.

46.5.Худалдагч эд хөрөнгийг шилжүүлэх үед түүний доголдлыг мэдсээр байж нуун дарагдуулсан бол энэ зүйлийн зохицуулалт түүнд хамаарахгүй.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

47 дугаар зүйл.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа

47.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох мөнгөн зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

47.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зөвхөн хөдлөх эд хөрөнгө барьцаална.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТҮРЭЭС /ЛИЗИНГ/

48 дугаар зүйл.Санхүүгийн түрээсийн гэрээ

48.1.Санхүүгийн түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалгын дагуу ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алддаггүй, үндсэн хөрөнгөд хамаарах биет эд хөрөнгийг гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, эсхүл түүнээс худалдан авч тодорхой хугацаанд, төлбөртэйгээр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

48.2.Түрээслэгч гэрээний хугацаа дууссаны дараа гэрээний зүйл болох эд хөрөнгийг худалдан авах, эсхүл үргэлжлүүлэн түрээслэхээр санхүүгийн түрээсийн гэрээнд зааж болно.

48.3.Энэ бүлгийн зохицуулалт нь санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд үйлчилнэ.

48.4.Энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байхаас үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

49 дүгээр зүйл.Санхүүгийн түрээсийн гэрээний хэлбэр, нөхцөл

49.1.Хуульд өөрөөр заагаагүй бол санхүүгийн түрээсийн гэрээг бичгээр хийнэ.

49.2.Санхүүгийн түрээсийн гэрээ дараах шаардлагыг хангасан байна:

49.2.1.гэрээний хугацаа дуусгавар болоход түрээсийн зүйлийг түрээслэгчийн өмчлөлд шилжүүлэхээр гэрээнд тусгасан байх;

49.2.2.гэрээний хугацааг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн ашиглалтын хугацааны дөрөвний гурваас багагүй байхаар тогтоосон байх;

49.2.3.гэрээний нийт үнийг тухайн түрээсийн зүйл болох эд хөрөнгийн үнийн дүнгийн 90 болон түүнээс дээш хувьтай тэнцүү байхаар тогтоосон байх.

49.3.Гэрээнд гэрээний нийт үнэ, түрээсийн төлбөр, хүү, түүнийг төлөх журам, хугацаа, гэрээ хугацаанаас өмнө дуусгавар болох тохиолдолд гэрээний үнийг төлж дуусах журмыг заана.

50 дугаар зүйл.Түрээслүүлэгчийн хүлээх хариуцлага

50.1.Түрээслүүлэгч нь гэрээний зүйл болох эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлээгүй, хугацаа хоцорч шилжүүлсэн, эсхүл шаардлага хангаагүй эд юмсыг шилжүүлсний хариуцлагыг эд хөрөнгө хөлслөх гэрээний нэг адил хүлээнэ.

50.2.Гэрээнд заасан бол түрээслэгч нь түрээслүүлэгчид гомдлын шаардлага тавихаас өмнө эд хөрөнгийг худалдагч, эсхүл тээвэрлэгчээс өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардаж болно.

51 дүгээр зүйл.Түрээслүүлэгчийн шаардлагын хэмжээг тодорхойлох

51.1.Түрээслэгчийн гэм буруугаар санхүүгийн түрээсийн гэрээ хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд түрээслүүлэгчээс тавих шаардлагын хэмжээг тодорхойлохдоо түрээсэлсэн эд юмсын элэгдлийг тооцсон үнэ, төлөгдөөгүй төлбөр болон хэмнэгдсэн бусад зардлыг харгалзан үзнэ.

52 дугаар зүйл.Санхүүгийн түрээсийн гэрээнд гуравдагч этгээдийн эрх, үүрэг

52.1.Гэрээнд заасан бол гуравдагч этгээд түрээслэгчийн захиалгаар гэрээний зүйл болох эд юмсыг үйлдвэрлэх, нийлүүлэх, түрээслүүлэгчээс зохих хөлс, зардлыг шаардах эрхтэй.

52.2.Гэрээнд заасан бол гуравдагч этгээд нь гэрээний зүйлд засвар үйлчилгээ хийх, түүнийг тохируулах, суурилуулах, ашиглахтай холбоотой үнэн зөв мэдээллийг түрээслэгчид өгөх үүрэгтэй.

53 дугаар зүйл.Санхүүгийн түрээсийн гэрээнд хамаарах бусад зүйл

53.1.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол санхүүгийн түрээсийн гэрээнд эд хөрөнгө хөлслөх гэрээний талаарх Иргэний хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ФРАНЧАЙЗ, МЕРЧАНДАЙЗ

54 дүгээр зүйл.Франчайзын гэрээ

54.1.Франчайзын гэрээгээр эрх шилжүүлэгч нь өөрийн арилжааны нэр, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, баглаа, боодол, түүнчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бус хөрөнгийг цогцоор нь ашиглуулахаар тогтоосон журмаар бүрдүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжүүлэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түүнд зохих шагнал, хураамж, эсхүл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг хүлээнэ.

55 дугаар зүйл.Гэрээний талуудын үүрэг

55.1.Эрх шилжүүлэгч дараах үүрэгтэй:

55.1.1.хамтын ажиллагааны хөтөлбөрийг гуравдагч этгээдийн оролцооноос хамгаалах;

55.1.2.хөтөлбөрийг байнга боловсронгуй болгох;

55.1.3.эрх хүлээн авагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

55.1.4.эрх хүлээн авагчид техникийн туслалцаа үзүүлэх;

55.1.5.эрх хүлээн авагчийн ажиллах хүчнийг сургах.

55.2.Эрх хүлээн авагч дараах үүрэгтэй:

55.2.1.гэрээгээр хүлээж авсан эрх, эд хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах;

55.2.2.зохих шагнал, хураамж, орлогын тодорхой хувийг тогтоосон хугацаанд төлөх;

55.2.3.гэрээнд заасан бол шилжүүлэн авсан эрх, эд хөрөнгийг эрх шилжүүлэгчид ашигтайгаар даатгуулах;

55.2.4.эрх шилжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр лиценз болон франчайзийн гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх;

55.2.5.гэрээнд заасан бол эрх шилжүүлэгчээс хэрэгжүүлж байгаа сургалтад ажиллагсдыг хамруулах, холбогдох зардлыг төлөх;

55.2.6.эрх шилжүүлэгчийн барааны болон ажил үйлчилгээний тэмдгийг хэрэглэхдээ лицензээр хэрэглэж байгаа тухай харилцагч болон үйлчлүүлэгчид заавал мэдэгдэх.

55.3.Талууд гэрээ байгуулахдаа шаардлагатай бүхий л мэдээллийг шударгаар харилцан солилцох, гэрээ байгуулагдахгүй тохиолдолд мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

56 дугаар зүйл.Франчайзын гэрээний хэлбэр

56.1.Хуульд өөрөөр заагаагүй бол франчайзын гэрээг бичгээр хийнэ.

56.2.Франчайзын гэрээнд гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээ цуцлах, хугацаа сунгах журам, талуудын хүлээх үүрэг, бусад гол нөхцөл болон франчайзыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг бүрэн тусгана.

57 дугаар зүйл.Франчайзын гэрээний хугацаа

57.1.Франчайзын гэрээний хугацааг тухайн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний эрэлт хэрэгцээ, борлуулалтын зах зээлээс шалтгаалан талууд тохиролцон тогтооно.

57.2.Франчайзын гэрээг арван жилээс дээш хугацаагаар байгуулсан бол 10 жил өнгөрсний дараа талуудын аль нэг нь гэрээг цуцлах хүсэлтээ нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш нэг жилийн дараа гэрээг цуцалж болно. Гэхдээ гэрээг цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш үлдсэн гэрээний хугацаа нь нэг жилээс бага бол тухайн хугацааны дараа цуцалж болно.

58 дугаар зүйл.Өрсөлдөөнийг хязгаарлах

58.1.Эрх шилжүүлэгч нь франчайзын гэрээ дуусгавар болсны дараа эрх хүлээн авагчийг тодорхой нутаг дэвсгэрт өөртэйгээ өрсөлдөхийг нэг жил хүртэлх хугацаагаар хориглох эрхтэй.

58.2.Энэ хуулийн 58.1-д заасан хориг нь эрх хүлээн авагчийн арилжааны үйл ажиллагаанд хохирол учруулахаар бол эрх шилжүүлэгч түүнд зохих мөнгөн төлбөр төлөх үүрэгтэй.

59 дүгээр зүйл.Талуудын хүлээх хариуцлага

59.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэл болон өгсөн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

59.2.Эрх хүлээн авагч франчайзын гэрээний үүрэгтэй холбоотой эрх шилжүүлэгчид учруулсан хохирол, зардлыг түүнд нөхөн төлөх үүрэгтэй.

59.3.Эрх шилжүүлэгч нь франчайзын гэрээний үр дүнд эрх хүлээн авагчийн олох орлогын талаар баталгаа гаргахгүй, хариуцлага хүлээхгүй.

59.4.Эрх хүлээн авагчийн гэм буруутай үйл ажиллагаанаас болж үйлчлүүлэгчид учирсан хохирлыг эрх шилжүүлэгч хариуцахгүй.

59.5.Эрх шилжүүлэгч хууль болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл өгсөн удирдамж, заавар, мэдээлэл нь буруу, алдаа дутагдалтай байснаас эрх хүлээн авагчид хохирол учруулсан бол хохирлыг эрх шилжүүлэгч хариуцна.

60 дугаар зүйл.Мерчандайзын гэрээ

60.1.Мерчандайзын гэрээгээр бие хүний нэр, төрх, дуу хоолой болон утга зохиол, урлагийн бүтээл, эд зүйлийн дүр, зургийг бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах эрхийг өмчлөгч, эзэмшигчээс үйлдвэрлэгч, борлуулагчид олгох ба үйлдвэрлэгч, борлуулагч нь өмчлөгч, эзэмшигчид борлуулалтын орлогоос нэр, төрх, дуу, хоолой, дүр, зургийг ашигласны төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

60.2.Хуульд өөрөөр заагаагүй бол мерчандайзын гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр байгуулж, дараах зүйлийг тусгана:

60.2.1.мерчандайзын зүйлийн хэмжээ, загвар, өнгө, материалын дэлгэрэнгүй тодорхойлолт;

60.2.2.мерчандайзын гэрээний дагуу үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний тоо хэмжээ;

60.2.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах борлуулагч, борлуулах цэгийн мэдээлэл;

60.2.4.мерчандайзийн зүйлийг үйлдвэрлэх, борлуулахад шаардлагатай санхүүжилтийн хэлбэр, нөхцөл;

60.2.5.мерчандайзийн зүйлийг гэрээнд заасны дагуу үйлдвэрлэх, борлуулах болон чанарын баталгаа;

60.2.6.загвар ашигласны төлбөрийн хэмжээ, нөхцөл;

60.2.7.мерчандайзийн гэрээний хугацааг сунгах, гэрээний эрх, үүргийг шилжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, мерчандайзийн гэрээ ба холбогдох бусад гэрээ хоорондын харилцаа, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, үүргээ биелүүлээгүй тохиолдол, гэрээ цуцлах, дуусгавар болох үндэслэл, маргаан шийдвэрлэх журам;

60.2.8. талууд харилцан тохиролцсон бусад зүйл.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ КОМИСС

61 дүгээр зүйл. Комисс

61.1. Өөрийн нэрийн өмнөөс, гэхдээ үйлчлүүлэгчийн зардлаар барааг худалдах, худалдан авах арилжааны үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг комисс гэнэ.

61.2. Комисс нь энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байхаас үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

62 дугаар зүйл. Комиссын үүрэг

62.1. Комисс нь дараах үүрэгтэй:

62.1.1. комисс нь ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажиллах ба үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн, түүний зааврын дагуу үйл ажиллагаагаа явуулах;

62.1.2. комисс нь үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөх, гэрээ хэлцэл байгуулсан бол даруй мэдэгдэх;

62.1.3. комисс нь олсон орлого болон худалдаж авсан барааны өмчлөх эрхийг үйлчлүүлэгчид шилжүүлэх үүрэгтэй. Гэрээнд өөрөөр заагаагүй бол комисс нь энэ үүргээ сар бүрийн эцэст гүйцэтгэнэ;

62.1.4. комисс нь гэрээ, хэлцэл байгуулсан мэдэгдэлтэй нэгэн зэрэг тухайн байгуулсан гэрээ хэлцлийн нөгөө тал болох гуравдагч этгээдийг нэрлэн заагаагүй бол үйлчлүүлэгчийн өмнө тухайн гэрээ хэлцлийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой хариуцлага хүлээх.

62.1.5. комисс нь үйлчлүүлэгчийн зааварт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулаагүйгээс түүнд хохирол учруулсан бол учруулсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Энэ тохиолдолд комиссын байгуулсан гэрээ, хэлцлийг үйлчлүүлэгчийн зардлаар байгуулсанд тооцохгүй. Иргэний хуулийн 400.2-т заасан тохиолдол үүнд хамаарахгүй.

62.2. Комисс нь барааг үйлчлүүлэгчийн тогтоосон үнээс өөр үнээр худалдах тохиолдолд түүнд энэ тухай даруй мэдэгдэх бөгөөд энэ тохиолдолд үйлчлүүлэгч даруй хариу өгөөгүй бол түүнийг зөвшөөрсөнд тооцно. Барааг илүү ашигтайгаар худалдсан тохиолдолд олсон ашгийг үйлчлүүлэгч хүртэнэ.

62.3. Комиссын худалдан авсан бараа нь ил доголдолтой байсан тохиолдолд комисс нь гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах эрхээ хэрэгжүүлж, холбогдох нотлох баримтыг бэлтгэн үйлчлүүлэгчид энэ талаар даруй мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ зөрчснөөс үйлчлүүлэгчид учирсан хохирлыг комисс нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

62.4. Үйлчлүүлэгчийн зааврын дагуу комисс бараа худалдан авах гэрээг байгуулсан бөгөөд тухайн гэрээ нь хоёр талт арилжааны хэлцэлд хамаарч байвал үйлчлүүлэгчийн шалгах үүрэг болон илрүүлсэн доголдлын талаар комисст мэдэгдэх

үүрэг, хадгалж байгаа эд хөрөнгийг худалдах эрхийн хувьд энэ хуулийн 46 дугаар зүйл, Иргэний хуулийн 259.3 дахь хэсгийг нэгэн адил хэрэглэнэ.

62.5.Комисс нь өөрийнх нь мэдэлд байгаа бүтээгдэхүүн устсан, эсхүл гэмтсэний хариуцлагыг хүлээнэ. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа устсан, эсхүл гэмтсэн тохиолдолд комисс хариуцлага хүлээхгүй.

62.6.Комисс нь үйлчлүүлэгчээс барааг даатгалд даатгуулах заавар хүлээж авсан тохиолдолд л барааг даатгуулаагүйдээ хариуцлага хүлээнэ.

63 дугаар зүйл.Комиссын байгуулсан хэлцлээс үүссэн шаардах эрх

63.1.Комиссын байгуулсан хэлцлээс үүссэн шаардах эрхийг үйлчлүүлэгч өөртөө шилжүүлэн авсны дараа тус шаардах эрхийг үйлчлүүлэгч үүрэг гүйцэтгэгчийн эсрэг хэрэгжүүлэх эрхтэй болно.

63.2.Комиссын байгуулсан хэлцлээс үүссэн шаардах эрхийг үйлчлүүлэгчид шилжүүлсэн эсэхийг үл харгалзан үйлчлүүлэгч болон комиссын хооронд, түүнчлэн комиссын үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө тухайн шаардах эрхийг үйлчлүүлэгчийн шаардах эрх гэж үзнэ.

64 дүгээр зүйл.Комиссын хөлс, зайлшгүй зардал, тусгай хөлс

64.1.Комиссын байгуулсан гэрээ хэрэгжсэн тохиолдолд комисс нь хөлс шаардах эрхтэй. Комиссын байгуулсан гэрээ үйлчлүүлэгчээс хамаарсан шалтгаанаар хэрэгжээгүй тохиолдолд ч хөлс шаардах эрхтэй.

64.2.Үйлчлүүлэгч нь комиссоос гарсан зайлшгүй зардлыг нөхөн төлөх бөгөөд үүнд нь комиссын агуулах болон тээврийн хэрэгсэл ашигласны зардал мөн хамаарна.

64.3.Комисс нь өөрийн байгуулсан тодорхой нэг хэлцлээс үүсэх бүх үүргийг хариуцахаар үйлчлүүлэгчид урьдчилан бичгээр, эсхүл цахим хэлбэрээр баталгаа гаргаж тусгай хөлс авч болно.

65 дугаар зүйл.Комиссын барьцааны эрх

65.1.Комисс нь хөлс, зайлшгүй зардал, тусгай хөлсөө зохих ёсоор төлүүлэх зорилгоор үйлчлүүлэгчийн зардлаар худалдан авсан барааг, эсхүл үйлчлүүлэгчийн барааг худалдсанаас олсон орлогыг барьцаалах эрхтэй.

66 дугаар зүйл.Комисс гэрээний нэг тал болох эрх

66.1.Комисс нь биржээр арилжаалагддаг барааг худалдах, худалдан авах даалгавар авсан бөгөөд үйлчлүүлэгч зөвшөөрөл олгосон тохиолдолд өөрөө гэрээний нэг тал болж худалдагч, худалдан авагч болж болно. Комисс өөрөө гэрээний нэг тал болох тухай мэдэгдлийг үйлчлүүлэгчид хүргүүлсэн үеийн биржийн үнээр барааны үнийг тооцно. Гэхдээ комисс нь өөрөө гэрээний нэг тал болох тохиолдлоос илүү үйлчлүүлэгчид ашигтай үнээр барааг худалдах, худалдан авах боломжтой байсан бол зөрүүг үйлчлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

67 дугаар зүйл. Аялал жуулчлалын гэрээ

67.1. Аялал жуулчлалын гэрээгээр тур оператор, аяллын агент нь жуулчинд хэлэлцэн тохиролцсон үйлчилгээ үзүүлэх, жуулчин нь ийнхүү үйлчилгээ үзүүлсний төлөө хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

67.2. Энэ бүлгийн зохицуулалт нь аялал жуулчлалын үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд үйлчилнэ.

67.3. Энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байгаа эсэхээс үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

68 дугаар зүйл. Аялал жуулчлалд гуравдагч этгээдийг оролцуулах

68.1. Жуулчин өөрийнхөө оронд гуравдагч этгээдийг аялалд оролцуулахаар аялал эхлэхээс өмнө тур оператор, аяллын агентад хүсэлт гаргах эрхтэй.

68.2. Энэ хуулийн 68.1-д заасан гуравдагч этгээд нь аялал жуулчлал хийхэд шаардагдах нөхцөлд тохирохгүй гэж үзвэл түүнийг өөр этгээдээр солихыг аялал жуулчлал эхлэхээс өмнө тур оператор, аяллын агент нь жуулчнаас шаардах эрхтэй.

68.3. Тур оператор, аяллын агент нь гуравдагч этгээдийг аялалд оролцуулахтай холбогдож гарсан нэмэлт зардлаа нөхөн төлүүлэхээр жуулчнаас шаардах эрхтэй.

69 дүгээр зүйл. Алдаа, дутагдал гаргахгүй байх үүрэг

69.1. Тур оператор, аяллын агент нь гэрээнд заасан аяллын ач холбогдлыг бууруулах буюу үр ашиггүй болгох аливаа алдаа, дутагдал гаргахгүйгээр аяллыг зохион байгуулах үүрэгтэй.

69.2. Тур оператор, аяллын агент энэ хуулийн 69.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол жуулчин уг алдаа, дутагдлыг арилгахыг шаардах эрхтэй бөгөөд ийнхүү алдаа, дутагдлыг арилгахад харьцангуй их зардал гарахаар бол тур оператор, аяллын агент нь алдаа, дутагдлыг арилгахаас татгалзаж болно.

69.3. Жуулчны тогтоосон боломжийн хугацаанд тур оператор, аяллын агент алдаа, дутагдлыг арилгахгүй бол жуулчин өөрөө уг уг алдаа, дутагдлыг арилгаж, гарсан зардлыг тур оператор, аяллын агентаас нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.

69.4. Тур оператор, аяллын агент алдаа, дутагдлыг арилгахаас шууд татгалзсан, эсхүл арилгах боломжгүй бол энэ хуулийн 69.3-т заасан хугацааг заавал тогтоох шаардлагагүй.

69.5. Аялал нь ямар нэгэн алдаа, дутагдалтай бол тухайн алдаа, дутагдлыг арилгасан хугацааг харгалзан аяллын үнийг бууруулж болно.

69.6. Жуулчин алдаа, дутагдлыг арилгуулах тухай тур оператор, аяллын агентад өөрийн буруугаас мэдэгдээгүй бол аяллын үнийг бууруулахгүй.

70 дугаар зүйл.Гэрээ дуусгавар болох

70.1.Дараах үндэслэлээр гэрээг дуусгавар болгоно:

70.1.1.аяллын алдаа, дутагдлаас болж жуулчинд үлэмж хохирол учирсан;

70.1.2.жуулчин хүндэтгэн үзэх шалтгаанаар аялалд оролцох боломжгүй болсон тухай аялал зохион байгуулагчид мэдэгдсэн;

70.1.3.тур оператор, аяллын агент нь жуулчны тогтоосон хугацаанд алдаа, дутагдлыг арилгаагүй.

70.2.Энэ хуулийн 70.1-д заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгосон бол тур оператор, аяллын агент нь хэлэлцэн тохиролцсон хөлс авах эрхээ алдана. Нэгэнт үзүүлсэн алдаа, дутагдалгүй үйлчилгээнийхээ хөлсийг шаардах эрхтэй.

70.3.Гэрээ дуусгавар болсны дараа тур оператор, аяллын агент жуулчныг буцааж хүргэх үүрэг гэрээгээр хүлээсэн бол энэ үүргээ гүйцэтгэх үүрэгтэй. Энэ тохиолдолд жуулчныг буцааж хүргэхтэй холбогдсон зардлыг аялал жуулчлал зохион байгуулагч хариуцна.

70.4.Гэрээ байгуулах үед урьдчилан мэдэх боломжгүй байсан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас аялал хийхэд ноцтой хүндрэл учирсан, эсхүл жуулчинд хохирол учруулж болох өөр бусад нөхцөл бий болсон бол тур оператор, аяллын агент, жуулчны аль нь ч гэрээг дуусгавар болгох эрхтэй бөгөөд жуулчныг буцаахтай холбогдох зардлыг талууд тэнцүү хэмжээгээр хариуцна.

71 дүгээр зүйл.Хохирол нөхөн төлөх

71.1.Тур оператор, аяллын агентын гэм буруугаар алдаа, дутагдал бий болсон бол жуулчин хөлсийг бууруулах буюу гэрээг дуусгавар болгохын зэрэгцээ учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр тур оператор, аяллын агентаас шаардах эрхтэй.

71.2.Аялал болоогүй буюу түүнийг зохих ёсоор зохион байгуулаагүй бол жуулчин үр ашиггүй өнгөрүүлсэн хугацааныхаа нөхөн төлбөрийг тур оператор, аяллын агентаас мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

72 дугаар зүйл.Гомдлын шаардлага гаргах хугацаа

72.1.Жуулчин энэ хуулийн 69.3, 71 дүгээр зүйлд заасан шаардлагыг гэрээнд заасан аяллын хугацаа дууссанаас хойш гурван сарын дотор тур оператор, аяллын агентад гаргаж болно.

72.2.Энэ хуулийн 72.1-д заасан хугацаа хэтэрсэн явдалд жуулчин гэм буруугүй бол дээрх хугацаа өнгөрснөөс хойш гомдол гаргаж болно.

73 дугаар зүйл.Хөөн хэлэлцэх хугацаа

73.1.Жуулчны шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа зургаан сар байна.

73.2.Хөөн хэлэлцэх хугацааг тур оператор, аяллын агент гомдлын шаардлагаас татгалзсан буюу гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс эхлэн тоолно.

74 дүгээр зүйл.Хариуцлагыг хязгаарлах

74.1.Дараах тохиолдолд тур оператор, аяллын агент нь жуулчинтай зөвшилцөн үйлчилгээний хөлсийг гурав дахин өсгөсөнтэй тэнцэх хэмжээгээр өөрийн хүлээх хариуцлагаа хязгаарлаж болно:

74.1.1.жуулчинд учирсан хохирол нь тур оператор, аяллын агентын санаатай, болгоомжгүй үйлдлээс болоогүй;

74.1.2.аялал зохион байгуулахад оролцогч бусад үүрэг гүйцэтгэгчийн хэн нэгний гэм буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг дангаараа бүрэн хариуцахаар тур оператор, аяллын агент үүрэг хүлээгээгүй.

75 дугаар зүйл.Гэрээнээс татгалзах эрх

75.1.Жуулчин аялал эхлэхээс өмнө хэдийд ч гэрээнээс татгалзаж болох бөгөөд энэ тохиолдолд аялал жуулчлал зохион байгуулаагүйгээс хэмнэсэн зардал болон бусад үйлчилгээний төлөө тур оператор, аяллын агентад урьдчилан төлсөн төлбөрөө буцаан авах эрхтэй.

75.2.Энэ хуулийн 75.1-д заасан тохиолдолд тур оператор, аяллын агент гэрээгээр тохиролцсон хөлс авах эрхээ алдах боловч өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр жуулчнаас шаардах эрхтэй.

76 дугаар зүйл.Хуульд заасан журмыг өөрчилж үл болох

76.1.Талууд гэрээ байгуулахдаа энэ бүлэгт заасан журмыг жуулчинд хохиролтойгоор өөрчилж болохгүй.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ ИЛГЭЭМЖИЙН ГЭРЭЭ

77 дугаар зүйл.Илгээмжийн гэрээ

77.1.Илгээмжийн гэрээгээр илгээгч өөрийн нэрийн өмнөөс захиалагчийн зардлаар ачаа, илгээмжийг тээвэрлэхтэй холбоотой үйлдэл хийж, захиалагч гэрээнд заасан хөлс төлөх үүргийг хүлээнэ.

77.2.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол илгээмжийн гэрээнд даалгаврын гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

77.3.Энэ бүлгийн зохицуулалт нь илгээмжийн үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд үйлчилнэ.

77.4.Энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байхаас үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

78 дугаар зүйл.Илгээгчийн үүрэг

78.1.Илгээгч нь дараах үүрэгтэй:

78.1.1.илгээмжийн гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангахуйц байдлаар тээврийн хэрэгсэл болон тээвэрлэх замыг шийдэх;

78.1.2.тээвэрлэлтэд оролцох этгээдийг буюу тээвэрлэгчийг сонгох, түүнд мэдээлэл болон зааварчилгаа өгөх;

78.1.3.илгээхэд шаардлагатай тээвэрлэлтийн, хадгалалтын, илгээмжийн гэрээг байгуулах;

78.1.4.захиалагчид хохирол шаардах эрхийг шилжүүлэх;

78.1.5.захиалагчийн ашиг сонирхлын дагуу түүний өгсөн даалгаврыг биелүүлэх;

78.2.Захиалагч хүсвэл илгээгч илгээмжийг даатгуулах үүрэгтэй. Захиалагч хүсэлт гаргаагүй бол илгээгч ердийн нөхцөлийн дагуу илгээмжийг даатгуулж болно.

78.3.Захиалагч татгалзаж байгаага бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тусгайлан илэрхийлээгүй бол илгээгч нь захиалагчийн зардлаар илгээгчийн үйлдлийн улмаас учирч болзошгүй гэм хорын даатгалын гэрээг өөрийн сонгосон даатгагчтай байгуулах бөгөөд энэ тухай захиалагчид мэдээлэх үүрэгтэй.

78.4.Энэ хуулийн 78.3-т заасан даатгалын гэрээг баримтлан захиалагч нь учирсан гэм хорын талаар илгээгчид даруй мэдээлэх бөгөөд илгээгч уг мэдээллийг даатгагчид дамжуулна.

78.5.Илгээмж хүлээн авагч илгээмжийг хүлээн аваагүй, эсхүл бусад үндэслэлээр илгээмжийг хүлээн авах боломжгүй болсон бол илгээгчийн эрх, үүргийг тээвэрлэлтийн дүрмээр тодорхойлно.

78.6.Талуудын оролцоотойгоор илгээмжийг шалгах боломжгүй бол илгээмжийг хүлээн авагч нь ачаанд учирсан гэм хорыг олж тогтоон илгээмжийг хүлээлгэн өгөгчид мэдэгдсэнээс бусад тохиолдолд илгээмжийг бүрэн бүтэн, аливаа гэмтэлгүй болохыг хүлээн зөвшөөрч, хүлээж авсанд тооцно.

78.7.Хэрэв илгээмж илт дутсан, эсхүл гэмтсэн байвал илгээмж хүлээн авагч энэ тухай илгээмжийг хүлээн авсан өдөрт нь багтааж илгээгчид мэдээлнэ.

79 дүгээр зүйл.Илгээгч өөрөө тээвэрлэлтийг гүйцэтгэх

79.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол илгээгч илгээмжийг өөрийн зардал, хэрэгслээр тээвэрлэж болно. Энэ тохиолдолд илгээгч нь тээвэрлэгчтэй нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд энэ нь захиалагчийн эрх ашгийг үл хөндөнө.

79.2.Илгээгч өөрөө тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа тохиолдолд илгээгч нь илгээмжийн үйл ажиллагааны хөлснөөс гадна тээвэрлэлтийн хөлсийг мөн шаардах эрхтэй.

80 дугаар зүйл.Илгээгчийн хүлээх хариуцлага

80.1.Илгээгч өөрөө, эсхүл түүний ажилтан гэм буруутай бол гэрээнээс үүсэх хариуцлагыг хүлээнэ.

80.2.Илгээгч хяналтандаа байгаа илгээмж алдагдсан, дутсан, гэмтсэний хариуцлагыг хүлээнэ. Үүнээс бусад хохирлыг илгээгч нь энэ хуулийн 78.1-д заасан үүргээ зөрчсөн нөхцөлд хариуцна. Илгээгч нь ердийн нөхцөлд шаардагдах анхаарал болгоомжтой байдлыг хангаж ажилласан ч энэ хохирол учрахаар байсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

80.3.Гуравдагч этгээд гэрээний талуудад гэм хор учруулсан бол илгээгч нь захиалагчийн зөвшөөрснөөр түүний зардал, эрсдэлээр шаардах эрх эдлэхээс бусад тохиолдолд гуравдагч этгээдэд шаардлага гаргах эрхийг захиалагчийн шаардсанаар түүнд шилжүүлэх үүрэгтэй.

80.4.Илгээгч, түүний ажилтан санаатай, эсхүл илт хайхрамжгүй хандаж захиалагчид гэм хор учруулсан бол тэдгээрийн хариуцлагыг хязгаарласан, эсхүл гэм бурууг нотлох үүргийг бусдад ногдуулсан гэрээний заалтууд хүчин төгөлдөр бус байна.

81 дүгээр зүйл.Захиалагчийн үүрэг

81.1.Захиалагч илгээмжийн талаарх болон бусад шаардлагатай мэдээлэл, түүний тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг бүрдүүлж илгээгчид өгөх үүрэгтэй.

81.2.Захиалагч энэ хуулийн 81.1-д заасан мэдээллийн үнэн зөвийг нотлох баримтыг илгээгчид шилжүүлж өгөх үүрэгтэй.

81.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч илгээмжийг тээвэрлэлтийн шаардлагад нийцүүлэн баглах үүрэгтэй.

81.4.Илгээмжийг бусдаас ялгах шаардлагатай бол захиалагч илгээмжийг эрх бүхий этгээдэд хүргэхээс өмнө таних тэмдэг тавих үүрэгтэй.

81.5.Захиалагч тээвэрлүүлэхээр шилжүүлсэн илгээмжийн онцлог шинж чанар, учруулж болзошгүй аюул, аюулгүй ажиллагааны талаар илгээгчид мэдээлнэ.

81.6.Захиалагч энэ хуулийн 81.5-д заасан үүргээ биелүүлээгүй бол илгээгч түүний шилжүүлсэн илгээмжийг аль ч үед устгах, буулгах, эсхүл аюулыг нь арилгах арга хэмжээ авч болох бөгөөд үүний улмаас захиалагчид учирсан гэм хорыг нөхөн төлөхгүй.

81.7.Баглаа боодол, таних тэмдэггүй, эсхүл тэдгээр нь дутуу, буруу байгааг илгээгч мэдсээр байж энэ талаар захиалагчид мэдээлээгүйгээс бусад тохиолдолд энэ хуулийн 81.3, 81.4-т заасан шаардлагыг биелүүлээгүйн улмаас учирсан гэм хорыг захиалагч хариуцна.

82 дугаар зүйл.Хөлс төлөх

82.1.Захиалагч илгээмжийг илгээгчид шилжүүлсний дараа хөлсийг төлнө.

82.2.Захиалагч илгээмжийг нэг бүрчлэн шалгахыг илгээгчид даалгаж, нэмэлт хөлс төлж болно.

83 дугаар зүйл.Захиалагчийн шаардах эрх

83.1.Захиалагч нь илгээгч өөрийн нэрээр захиалагчийн зардлаар байгуулсан гэрээнээс үүссэн шаардах эрхийг өөртөө шилжүүлж авсаны дараа хэрэгжүүлж болно.

84 дүгээр зүйл.Илгээгчийн саатуулан барих эрх

84.1.Илгээгч нь хөлс, холбогдох бусад зардал, захиалагчийн өмнөөс төлсөн аливаа төлбөрийн шаардлагаа хангуулах зорилгоор захиалагчийн илгээмжийг саатуулан барих эрхтэй.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ ТЭЭВЭРЛЭЛТ

Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл

85 дугаар зүйл.Тээвэрлэлтийн гэрээ

85.1.Тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь зорчигч, ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

85.2.Зорчигч, ачаа, тээшийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлтийн талаар талуудын хүлээх хариуцлага нь хууль, хуульд нийцсэн тодорхой төрлийн тээврийн дүрмээр тодорхойлогдоно.

85.3.Тээвэрлэлтийн үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд энэ бүлгийн зохицуулалт үйлчилнэ.

85.4.Энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байгаа эсэхээс үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

86 дугаар зүйл.Гэрээ байгуулах

86.1.Зорчигч, ачаа, тээш тээвэрлэхийг нийтэд санал болгож байгаа этгээд нь зайлшгүй татгалзах үндэслэл байхгүй бол тээвэрлэлтийн гэрээг заавал байгуулах үүрэгтэй.

Хоёрдугаар дэд бүлэг Зорчигч тээвэрлэлтийн гэрээ

87 дугаар зүйл.Зорчигч тээвэрлэлтийн гэрээ

87.1.Зорчигч тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь зорчигчийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

88 дугаар зүйл.Гэрээг цуцлах

88.1.Гэрээнд ямар нэгэн байдлаар саатал учруулахааргүй бол зорчигч нь тээвэрлэлтийн гэрээг хэдийд ч цуцалж болох бөгөөд гэрээг цуцалснаас үүссэн хохирлыг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

88.2. Урьдчилан мэдэх боломжгүй байсан бөгөөд мэдсэн тохиолдолд гэрээг хийхгүй байх шалтгаан болохоор нөхцөл байдал тээвэрлэгчийн зүгээс илэрсэн, түүнчлэн гэрээнд заасан газарт хүрч очих болон замд явах хугацаа хожимдох магадлал байгаа тохиолдолд зорчигч гэрээнээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирлыг нөхөн төлөх үүрэг үүсэхгүй.

89 дүгээр зүйл. Тээвэрлэгчийн хүлээх хариуцлага

89.1. Тээвэрлэлтийн явцад зорчигчид өөрт нь, эсхүл түүний эд хөрөнгөд гэм хор учирсан, авч яваа зүйл нь алдагдсан, гэмтсэн бол тээвэрлэгч хууль болон холбогдох тээврийн дүрэмд заасан хариуцлага хүлээнэ. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн явцад гэм буруугүй болохоо нотолбол энэ заалт хамаарахгүй.

89.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас, эсхүл зорчигчийн буруугаас болон түүний авч явсан зүйлээс шалтгаалж гэм хор учирсан бол тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй.

89.3. Тээвэрлэгч нь зорчигчийн хүлээлгэн өгсөн тээшний хувьд уг тээшийг тээвэрлэхтэй холбогдуулан нэмэлт хөлс авах эсэхээс үл хамааран ачаа тээвэрлэлтийн гэрээний тээвэрлэгчтэй адил хариуцлага хүлээнэ.

89.4. Тээвэрлэгчийн санаатай, эсхүл болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй бол зорчигчийн хүлээлгэн өгөөгүй гар тээш болон биедээ авч яваа эд зүйлс устаж гэмтсэний улмаас үүссэн хохирлыг тээвэрлэгч хариуцахгүй.

89.5. Зорчигч нь гар тээш болон тээшээ тээвэрлэлт дууссаны дараа тээвэрлэгчээс хүлээн аваагүй бол тээвэрлэгч нь тухайн гар тээш болон тээшийг 7 хоног хадгалах үүрэгтэй бөгөөд энэ хугацаанд хүлээн аваагүй бол Иргэний хуулийн 237 дугаар зүйлд заасан арга хэмжээг авна.

89.6. Тухайн төрлийн тээврийн хэрэгслийн жолооч болон бусад ажилтнуудын үйл ажиллагааны дутагдал, тээврийн хэрэгслийн бүрэн бус ажиллагаа, эвдрэл, эд материалын доголдол, дутагдал зэргээс зорчигчид хохирол учирсан нь тээвэрлэгчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

89.7. Тээвэрлэгч санаатай, эсхүл болгоомжгүй үйл ажиллагааныхаа улмаас хугацаа хоцроосон бол бусдад учруулсан хохирлыг хариуцна.

89.8. Тээвэрлэгчийн хариуцлагыг гэрээгээр хязгаарлах эсхүл чөлөөлж болохгүй.

90 дүгээр зүйл. Зорчигчийн хүлээх хариуцлага

90.1. Зорчигч нь өөрийн буруутай үйл ажиллагаа, түүнчлэн авч яваа гар тээш, тээш болон бусад эд хөрөнгөөс шалтгаалж тээвэрлэгчид учирсан хохирлыг хариуцна.

90.2. Зорчигч нь ачаа тээвэрлэлтийн явцад баримтлах хадгалалт, тээвэрлэлтийн бүхий л нөхцөл, журмыг чанд баримталсан бол хохирлыг хариуцахгүй.

Гуравдугаар дэд бүлэг Ачаа тээвэрлэлтийн гэрээ

91 дүгээр зүйл. Ачаа тээвэрлэлтийн гэрээ

91.1. Ачаа тээвэрлэлтийн гэрээгээр тээвэрлэгч нь ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээвэрлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

91.2. Тээвэрлэгч нь ачааны дагалдах бичиг үйлдэхийг ачаа илгээгчээс шаардаж болно.

91.3. Дагалдах бичгийг гурван хувь үйлдэж, талууд гарын үсгээ зурж эхний хувийг ачаа илгээгчид үлдээж, хоёр дахь хувийг ачаанд хавсаргаж, гурав дахь хувийг тээвэрлэгчид өгнө.

91.4. Ачааг хэд хэдэн тээврийн хэрэгслээр, эсхүл өөр өөр төрөл, тодорхой хэсэгт хувааж тээвэрлэхээр бол тээвэрлэгч, ачаа илгээгч талууд ачааны төрөл, тээврийн хэрэгслийн тоогоор дагалдах бичиг үйлдэхийг шаардах эрхтэй.

91.5. Дагалдах бичиггүй, түүнийг дутагдалтай үйлдсэн, эсхүл үрэгдүүлснээс үл хамааран энэ бүлгийн холбогдох заалт тээвэрлэлтийн гэрээний агуулга, хүчинтэй байх нөхцөлд нэгэн адил хамаарна.

92 дугаар зүйл. Дагалдах бичгийн агуулга

92.1. Дагалдах бичигт дараах зүйлийг тусгасан байна:

92.1.1. дагалдах бичиг үйлдсэн газар, он, сар, өдөр;

92.1.2. ачаа илгээгчийн нэр, хаяг;

92.1.3. тээвэрлэгчийн нэр, хаяг;

92.1.4. ачааг тээвэрлэгчид шилжүүлэх он, сар, өдөр, газар болон хүргэх газар;

92.1.5. хүлээн авагчийн нэр, хаяг;

92.1.6. ачааны болон сав, баглаа, боодлын ердийн нэр, түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед түүний нийтээр хүлээн зөвшөөрсөн тэмдэг, тэмдэглэгээ;

92.1.7. тээвэрлэх ачааны тоо, хэмжээ, тэмдэг, дугаар;

92.1.8. ачааны жин, хэмжээний талаарх бусад тэмдэглэл;

92.1.9. тээвэрлэлттэй холбогдсон зардал /тээврийн хөлс, нэмэлт зардал, гаалийн хураамж, гэрээ байгуулснаас ачааг хүргэх хүртэл гарах бусад зардал/;

92.1.10. хуульд заасан бусад нөхцөл.

92.2. Шаардлагатай гэж үзвэл талууд дагалдах бичигт дараах зүйлийг тусгаж болно:

92.2.1. ачааг өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэх, ачихыг хориглосон заалт;

92.2.2. тээвэрлүүлэгч хариуцах зардал;

92.2.3. ачаа илгээх үед төлөх нэмэгдэл үнийн хэмжээ;

92.2.4. ачааны өртөг, түүнийг дурдсан газарт хүргэх онцгой сонирхол;

92.2.5. тээвэрлүүлэгчээс ачааг даатгуулах тухай тээвэрлэгчид өгсөн заалт;

- 92.2.6.тээвэрлэлтийг дуусгахаар тохиролцсон хугацаа;
- 92.2.7.тээвэрлэгчид хүлээлгэн өгсөн баримт бичгийн жагсаалт.

93 дугаар зүйл.Тээвэрлэгчид ачааг хүлээлгэн өгөх

93.1.Тээвэрлэгч ачааг хүлээн авахдаа дараах зүйлийг шалгах үүрэгтэй:

- 93.1.1.ачааны тоо, хэмжээ, тэмдэг үнэн зөв эсэх;
- 93.1.2.ачааны гадаад байдал, сав, баглаа, боодол.

93.2.Тээвэрлэгч энэ хуулийн 93.1.1-д заасан үүргээ гүйцэтгэх бололцоогүй бол энэ тухай болон ачааны гадаад байдал, сав, баглаа, боодлын талаар холбогдох тэмдэглэл үйлдэнэ. Хэрэв дагалдах бичиг үйлдсэн бол тухайн тэмдэглэлийг дагалдах бичигт хийнэ.

93.3.Ачаа илгээгч нь ачааны жин болон бусад хэмжигдэхүүнээр тэмдэглэсэн түүний тоо, хэмжээ, түүнчлэн тээвэрлэх ачааны бүрэлдэхүүн хэсгүүдийг шалгаж, дагалдах бичиг болон бусад хэлбэрээр тэмдэглэхийг тээвэрлэгчээс шаардаж болох бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг тээвэрлэгч хариуцна.

93.4.Тээвэрлэгч нь ачааг хүлээн авсан болон гэрээний агуулга эсрэгээр нотлогдох хүртэл дагалдах бичгийг гэрээ байгуулсны нотолгоо гэж үзнэ.

93.5.Тээвэрлэгч ачааны дагалдах бичигт, эсхүл бусад хэлбэрээр энэ хуулийн 93.2-т заасан холбогдох тэмдэглэл хийгээгүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачааг хүлээн авахад түүний сав, баглаа боодлын гадаад байдал доголдолгүй, ачааны тоо хэмжээ, тэмдэг дугаар дагалдах бичигт заасантай тохирч байна гэж үзнэ.

93.6.Тээвэрлэгч ачааг хүлээн авах үед ачааны сав, баглаа, боодол илэрхий доголдолтой байсан, эсхүл тээвэрлэгч ачааны сав, баглаа, боодол доголдолтой талаар мэдсэн хэдий ч энэ талаар илгээгчид мэдэгдэхгүйгээр ачааг хүлээн авснаас бусад тохиолдолд тус доголдлын улмаас бусдад учирсан хохирол, аливаа зардлыг илгээгч хариуцна.

93.7.Ачаа илгээгч нь ачааг зохих газарт хүргэхэд шаардагдах гаалийн болон бусад бүх баримт бичгийг тээвэрлэгчид өгч, тээвэрлэгчийг зохих мэдээллээр бүрэн хангах үүрэгтэй.

93.8.Тээвэрлэгч энэ хуулийн 93.7-д заасан баримт бичиг, мэдээллийн үнэн зөв болон хангалттай эсэхийг шалгах үүрэггүй.

93.9.Тээвэрлэгчийн буруутай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд ачаа илгээгч нь баримт бичиг, мэдээллийн дутуу болон буруугаас учирсан гэм хорыг тээвэрлэгчийн өмнө хариуцна.

93.10.Дагалдах бичигт хавсаргасан, өөрөө хүлээн авсан баримт бичгийг үрэгдүүлсэн, буруугаар ашигласны хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ. Гэхдээ хариуцлагын хэмжээ нь ачааг үрэгдүүлснээс үүсэх хариуцлагаас ихгүй байна.

93.11.Тээвэрлэх ачаа нь шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай ачаа байгаа тохиолдолд ачаа илгээгч нь энэ талаар болон ачааны нэр төрөл, шинж чанар болон

тухайн ачааг аюулгүй тээвэрлэхтэй холбоотой мэдээллийг ачааг хүлээлгэж өгөхөөс өмнө тээвэрлэгчид өгөх үүрэгтэй.

94 дүгээр зүйл. Зааварчилгааг өөрчлөх эрх

94.1. Ачаа илгээгч нь дагалдах бичигт дурдсанаас өөр газар эсхүл өөр этгээдэд ачааг хүргүүлэх зорилгоор тээвэрлэлтийг зогсоох зэргээр тээвэрлэгчид өгсөн зааварчилгааг өөрчлөх, захиран зарцуулах эрхтэй.

94.2. Тээвэрлэгч нь ачааг гэрээнд заасан газарт хүргэснээр, эсхүл дагалдах бичгийн хоёр дахь хувийг ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр ачаа илгээгчийн энэ хуулийн 94.1-д заасан захиран зарцуулах эрх дуусгавар болох бөгөөд энэ үеэс тээвэрлэгч нь ачаа хүлээн авагчийн зааврыг биелүүлнэ.

94.3. Ачаа илгээгч дагалдах бичигт тусгай тэмдэглэл хийгээгүй бол ачаа хүлээн авагч нь дагалдах бичгийг хүлээн авсан үеэс эхлэн уг ачааг захиран зарцуулах эрхтэй болно.

94.4. Ачаа хүлээн авагч нь уг ачааг гуравдагч этгээдэд хүргүүлэхээр тээвэрлэгчид үүрэг хүлээлгэсэн бол гуравдагч этгээд нь ачаа хүлээн авагч өөр этгээдийг нэрлэх эрхгүй.

94.5. Ачааг захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлэхэд дараах журмыг баримтална:

94.5.1. ачаа илгээгч, эсхүл ачааг захиран зарцуулах эрхтэй хүлээн авагч нь тээвэрлэгчид өгсөн шинэ заавар, эсхүл шинэ зааврыг тусгасан дагалдах бичгийг тээвэрлэгчид өгч, эдгээр зааврыг гүйцэтгэсний дараа түүнд учирсан зардал, хохирлыг нөхөн төлнө;

94.5.2. тээвэрлэгчид өгөх шинэ заавар нь хүлээн авмагц биелэгдэх боломжтой, тээвэрлэгчийн хэвийн үйл ажиллагаа болон ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн бусад ачаанд саад, гэм хор учруулахааргүй байвал зохино;

94.5.3. ачааг задлан хуваах заавар өгч болохгүй.

94.6. Энэ хуулийн 94.5.2-т нийцээгүй заавар өгсөн бол түүнийг биелүүлэх боломжгүй талаар тээвэрлэгч заавар өгсөн этгээдэд нэн даруй мэдэгдэнэ.

94.7. Тээвэрлэгч нь энэ зүйлд заасан журмын дагуу өгсөн зааврыг биелүүлээгүйгээс үүссэн гэм хорыг эрх бүхий этгээдийн өмнө хариуцна.

95 дугаар зүйл. Хүлээн авагчид ачааг хүлээлгэн өгөх

95.1. Илгээгч дагалдах бичиг үйлдсэн тохиолдолд ачааг зохих газарт хүргэж, хүлээлгэн өгөх үед хүлээн авагч нь ачааг хүлээн авсны баталгаа болгож тээвэрлэгчээс дагалдах бичгийн хоёр дахь хувийг шаардан авах эрхтэй.

95.2. Ачаа алдагдсан, дутсан, эсхүл тохиролцсон хугацаандаа ирээгүй тохиолдолд ачаа хүлээн авагч нь илгээгчийн хэрэгжүүлэх шаардлагыг өөрийн нэрийн өмнөөс тээвэрлэгчид хандан гаргах эрхтэй.

95.3.Ачаа хүлээн авагч ачааг хүлээн авахдаа гэрээ, эсхүл дагалдах бичигт заасан төлбөл зохих бүх төлбөрийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй. Энэ талаар маргаан гарсан тохиолдолд тээвэрлэгч өөрийн шаардлагыг хангах хүртэл ачааг хүлээн авагчид шилжүүлэхээс татгалзаж болно.

96 дугаар зүйл.Тээвэрлэлтийг гэрээнд зааснаар гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал

96.1.Ачааг зохих газарт нь хүргэх, хүлээлгэн өгөхөөс өмнө тээвэрлэлтийг дагалдах бичиг, эсхүл гэрээнд заасан нөхцөлөөр, бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд тээвэрлэгч нь энэ хуулийн 94 дүгээр зүйлд заасан эрх бүхий этгээдээс шинэ заавар өгөхийг шаардах эрхтэй.

96.2.Нөхцөл байдал нь дагалдах бичиг, эсхүл гэрээнд зааснаас өөрөөр тээвэрлэхэд хүргэж, тээвэрлэгч нь эрх бүхий этгээдээс энэ хуулийн 94 дүгээр зүйлд заасан шинэ зааврыг зохих хугацаанд авч чадаагүй тохиолдолд тэрээр эрх бүхий этгээдийн ашиг сонирхолд илүү нийцэх арга хэмжээг авах үүрэгтэй.

96.3.Түргэн муудах ачаа, эсхүл ачааны нөхцөл байдал зайлшгүй шаардсан, эсхүл хадгалалтын зардал нь ачааны өртгөөс давахаар бол тээвэрлэгч нь эрх бүхий этгээдийн зааврыг хүлээхгүйгээр ачааг худалдах шийдвэр гаргаж болно.

96.4.Ачааг энэ хуулийн 96.3-т заасны дагуу худалдсанаас олсон орлогоос ачаатай холбогдон гарах зардлыг хасаж, үлдсэнийг нь эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. Ачаатай холбогдон гарах зардал ачааг худалдсан орлогоос давсан тохиолдолд тээвэрлэгч зөрүүг нөхөн төлүүлэхээр шаардаж болно.

96.5.Ачааг зохих газарт хүргэсний дараа түүнийг хүлээлгэн өгөхөд саад болох нөхцөл байдал үүсвэл тээвэрлэгч нь ачаа илгээгчээс зааварчилгаа шаардах эрхтэй.

96.6.Ачаа хүлээн авагч нь ачааг хүлээн авахаас татгалзсан хэдий ч ачаа илгээгчээс өөр заавар өгөөгүй бол тээвэрлэгч нь ачааг хүлээн авахыг ачаа хүлээн авагчаас шаардаж болно. Ачааг хүлээн авахаас татгалзсан хэвээр байвал тээвэрлэлтийг дууссанд тооцож, тээвэрлэгч нь буруутай этгээдийн эрсдэл болон зардлаар ачааг хадгалах, эсхүл уг үүргийг гуравдагч этгээдэд даалгаж болно.

96.7.Ачаа хүлээн авагч нь энэ хуулийн 94.4-т заасны дагуу ачааг гуравдагч этгээдэд хүлээлгэн өгөх заавар өгснөөс хойш ачааг хүлээлгэн өгөхөд саад болох нөхцөл байдал үүсч, энэ хуулийн 96.1, 96.2-т заасныг хэрэглэхэд хүлээн авагч нь ачаа илгээгчийн, гуравдагч этгээд нь хүлээн авагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

96.8.Энэ хуулийн 96.1, 96.3, 96.5, 96.6, 96.7-д заасан тохиолдолд тээвэрлэгч эрх бүхий этгээдийн зардлаар ачааг буулгаж болно.

97 дугаар зүйл.Ачаа барьцаалах тээвэрлэгчийн эрх

97.1.Тээвэрлэлтийн хөлс болон зардлыг төлүүлэхийн тулд тээвэрлэгч нь ачааг барьцаалах эрхтэй.

98 дугаар зүйл.Тээвэрлэгчийн хариуцлага

98.1.Тээвэрлэгч ачааг хүлээн авснаас хойш хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хоцроосны хариуцлагыг хүлээнэ.

98.2.Эрх бүхий этгээдийн буруугаас, эсхүл түүний зааварчилгааг биелүүлснээс ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, эсхүл тээвэрлэлтийн хугацаа хэтэрсэн, эсхүл дээрх нөхцөл байдал, түүний үр дагаврыг урьдчилан арилгах боломж тээвэрлэгчид байгаагүй бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө.

98.3.Тээвэрлэгч өөрийн буруугаас хохирол учруулсан бол түүний хүлээх хариуцлагыг хязгаарласан, эсхүл нотлох үүргээс чөлөөлсөн энэ бүлэгт заасан журам хамаарахгүй.

98.4.Дараах нөхцөл байдлын улмаас ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн бол тээвэрлэгч хариуцлагаас чөлөөлөгдөнө:

98.4.1.талууд шууд тохиролцон, дагалдах бичигт тэмдэглэснээр задгай тээврийн хэрэгсэл ашигласан;

98.4.2.ачаа сав, баглаа, боодолгүй, эсхүл түүний чанар муу байсан;

98.4.3.ачаа илгээгч, хүлээн авагч, эсхүл тэдгээрийг төлөөлөх гуравдагч этгээд ачаанд үзлэг хийж ачсан, эсхүл буулгасан;

98.4.4.тодорхой төрлийн ачааны онцлогоос хамаарч эвдрэх, зэврэх, хатах, элэгдэх, хэвийн алдагдал гарах, асгарах болон мэрэгч амьтдын нөлөөлөл зэргээр хэсэгчлэн, эсхүл бүрэн гэмтэх аюул байсан;

98.4.5.тээвэрлэх ачааны дугаар, эсхүл тэмдэглэл шаардлага хангаагүй байсан;

98.4.6.амьтан тээвэрлэсэн.

98.5.Энэ хуулийн 98.4-т заасан нөхцөл байдал байсан боловч гэм хор учирсан шалтгаан нь дээрхээс өөр бол гэм хорыг тээвэрлэгч хариуцна.

98.6.Энэ хуулийн 89.6-д заасан журам ачаа тээвэрлэгчид нэгэн адил хамаарна.

99 дүгээр зүйл.Гомдлын шаардлага гаргах

99.1.Ачаа хүлээн авагч ачааг хүлээн авахдаа тээвэрлэгчтэй хамт түүнийг шалгаагүй, эсхүл алдагдсан, дутсан ачааны болон учирсан хохирлын талаар ямар нэгэн шаардлага тээвэрлэгчид гаргаагүй бол эсрэгээр нотлогдох хүртэл ачаа хүлээн авагч ачааг гэрээнд заасан, эсхүл дагалдах бичигт заасан байдлаар хүлээн авсанд тооцно.

99.2.Ачаа хүлээн авагч ачааны илэрхий гэмтэл, дутагдлын талаарх шаардлагыг ачаа хүлээн авсан өдөр, харин далд дутагдалтай холбоотой шаардлагыг ачааг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тээвэрлэгчид гаргана.

99.3. Ачаа хүлээн авагч, тээвэрлэгч талууд ачааны байдлыг хамтран шалгасан боловч нуугдмал дутагдал, гэмтлийг тухайн үед илрүүлж чадаагүй бол ажлын 7 хоногийн дотор шалгасан үр дүнгийн талаар эсрэг нотолгоо гаргаж болно.

99.4. Ачаа хүлээн авагч хугацаа хэтэрсэнтэй холбоотой шаардлага ачаа хүлээн авсан өдрөөс хойш 21 хоногийн дотор тээвэрлэгчид бичгээр, **эсхүл цахим хэлбэрээр** гаргасан тохиолдолд хугацаа хэтэрснээс үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй.

99.5. Энэ зүйлд заасан хугацааг тоолохдоо ачаа илгээсэн, шалгасан, эсхүл хүлээлгэж өгсөн өдрийг оролцуулан тооцохгүй.

99.6. Тээвэрлэгч, ачаа хүлээн авагч талууд шаардлагатай шалгалт хийх, зайлшгүй хэрэгтэй гэж үзсэн хүчин зүйлийг тогтооход бие биедээ харилцан туслах үүрэгтэй.

100 дугаар зүйл. Хөөн хэлэлцэх хугацаа

100.1. Тээвэрлэлтийн гэрээнээс үүсэх шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа нэг жил, санаатай, эсхүл илтэд болгоомжгүй үйлдлийн улмаас хохирол учирсан бол хөөн хэлэлцэх хугацаа гурван жил байна.

100.2. Дор дурдсан үеэс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тоолно:

100.2.1. ачаа алдагдсан, гэмтсэн өдрөөс, энэ тухай мэдсэн, мэдэх ёстой байсан өдрөөс, эсхүл хүлээлгэн өгөх хугацааг хэтрүүлсэн бол ачааг хүлээн авах байсан өдрөөс;

100.2.2. ачааны зарим хэсэг алдагдсан тохиолдолд тээвэрлэлтийн гэрээгээр тохирсон ачааг хүлээлгэн өгөх хугацаа дууссанаас хойш 30 дахь өдрөөс, ийм хугацаа товлоогүй бол тээвэрлэгч ачаа хүлээн авснаас хойш 60 дахь өдрөөс;

100.2.3. бусад тохиолдолд гомдлын шаардлагын хариуг авсан, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дууссан өдрөөс.

101 дүгээр зүйл. Дамжуулан гүйцэтгэх тээвэрлэлт

101.1. Нэг гэрээгээр хэд хэдэн тээвэрлэгч тээвэрлэлтийг дамжуулан гүйцэтгэхээр байвал тээвэрлэгч бүр тээвэрлэлтийн үүргийг бүхэлд нь хариуцах бөгөөд дамжуулан тээвэрлэхээр ачааг хүлээн авч байгаа тээвэрлэгч ачааг хүлээн авснаар, эсхүл дагалдах бичиг үйлдсэн тохиолдолд ачааг дагалдах бичгийн хамт хүлээн авснаар гэрээний тал болно.

101.2. Өмнөх тээвэрлэгчээс ачааг хүлээн авсан тээвэрлэгч түүнийг хүлээн авсан он, сар, өдрийг тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулсан баримт бичгийг өмнөх тээвэрлэгчид өгөх үүрэгтэй бөгөөд дагалдах бичиг үйлдсэн тохиолдолд дагалдах бичгийн 2 дахь хувь дээр эдгээр тэмдэглэгээг хийж гүйцэтгэсэн байна.

101.3. Шаардлагатай тохиолдолд ачааг хүлээн авч байгаа тээвэрлэгч нь энэ хуулийн 93.2-т заасан тэмдэглэл болон ачаа хүлээн авсныг гэрчлэх тэмдэглэлийг дагалдах бичгийн 2 дахь хувь дээр тусгаж болно.

101.4.Ачаа дамжуулан тээвэрлэхэд ачааг хүлээлгэн өгч байгаа болон хүлээн авч байгаа тээвэрлэгчдэд энэ хуулийн 93.4, 93.5 нэгэн адил хамаарна.

101.5.Ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, хугацаа хэтэрснээс үүсэх гэм хорыг нөхөн төлүүлэх тухай шаардлагыг гагцхүү эхний болон эцсийн тээвэрлэгчид, эсхүл ачаа үрэгдүүлж, гэмтээсэн, хугацаа хэтрүүлсэн тээвэрлэгчид гаргаж болох бөгөөд нэг шаардлагыг хэд хэдэн тээвэрлэгчид гаргах эрхтэй.

101.6.Ачааг алдсан, дутаасан, гэмтээсэн тээвэрлэгч хэд хэдэн тээвэрлэгчийн хамтран хариуцвал зохих гэм хорыг дангаар нөхөн төлсөн бол бусад тээвэрлэгчийн эсрэг шаардлага гаргах эрхтэй.

101.7.Хэд хэдэн тээвэрлэгч ачааг алдсан, дутаасан, гэмтээсэн бол тус тусдаа өөрийн хүлээх хариуцлагад хувь тэнцүүлэн гэм хорыг нөхөн төлөх бөгөөд үүнийг тогтоох бололцоогүй тохиолдолд тээвэрлэгч тус бүр авсан хөлстэйгээ хувь тэнцүүлэн хариуцлага хүлээнэ.

101.8.Хэрэв тээвэрлэгчдийн хэн нэг нь төлбөрийн чадваргүй бол түүний төлөх ёстой байсан төлбөрийг бусад тээвэрлэгчид авсан хөлстэйгээ хувь тэнцүүлэн хариуцна.

101.9.Ачаа дамжуулан тээвэрлэгчид нь энэ хуулийн 101.6, 101.7, 101.8-д зааснаас бусад асуудлаар харилцан тохиролцож болно.

102 дугаар зүйл.Тээвэрлэлттэй холбоотой зарим хэлцэл хүчин төгөлдөр бус байх

102.1.Энэ хуулийн 101.6, 101.7, 101.8-д заасныг өөрөөр тогтоосон хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

102.2.Тээвэрлэгч ачааны даатгалаас үүсэх шаардлагаа, эсхүл нотлох үүргээ бусдад шилжүүлсэн аливаа хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

103 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлөх нэмэгдүүлсэн хариуцлага

103.1.Тээвэрлэгчид итгэмжлэн өгсөн ачаа нь онцгой ач холбогдолтой бол түүнийг алдсан, эсхүл дутаасан тохиолдолд үнийг хоёр нугалж төлүүлэхээр ачаа илгээгч, эсхүл хүлээн авагч тал нь тээвэрлэгчтэй урьдчилан тохиролцож болно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАЛТ

Нэгдүгээр дэд бүлэг Нийтлэг үндэслэл

104 дүгээр зүйл.Хадгалалтын гэрээ

104.1.Хадгалагч хадгалалтыг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхэлж байгаа бол урьдчилан тохиролцоогүй ч хадгалалтын хөлс төлөхийг шаардах эрхтэй.

104.2.Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээнд Иргэний хуулийн хадгалалтын гэрээний журам нэгэн адил үйлчилнэ.

104.3.Энэ бүлгийн зохицуулалт нь хадгалалтын үйл ажиллагааг арилжааны үйл ажиллагааны хүрээнд эрхлэх тохиолдолд үйлчилнэ.

104.4.Энэ хуулийн 5.3-т заасан жижиг арилжаа эрхлэгч байгаа эсэхээс үл хамааран энэ бүлгийн зохицуулалт тэдэнд нэгэн адил үйлчилнэ.

105 дугаар зүйл.Зочид буудалд эд зүйл үлдээх

105.1.Зочид буудал, амралт, сувиллын газар болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд нь үйлчлүүлэгчид олгосон өрөө, тасалгаанд байгаа үйлчлүүлэгчийн тусгай журмаар хүлээлгэн өгөх ёстой мөнгө, үнэт эдлэлээс бусад эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ гүйцэтгээгүйгээс эд хөрөнгө алдагдсан, гэмтсэн, үгүй болсон бол үйлчлүүлэгчид учирсан хохирлыг хариуцна.

105.2.Энэ хуулийн 105.1-д заасан хохирол нь гэнэтийн, эсхүл давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал, эсхүл тухайн үйлчлүүлэгч, түүнийг дагалдаж байгаа этгээдийн үйлдэл, эсхүл уг эд хөрөнгийн өөрийн шинж чанараас шалтгаалан үүссэн бол зочид буудал, амралт, сувиллын газар болон түүнтэй адилтгах үйл ажиллагаа эрхэлдэг этгээд хариуцлага хүлээхгүй.

105.3.Хохирлыг нөхөн төлөх үүрэг тээврийн хэрэгсэлд орхисон эд хөрөнгөд хамаарахгүй.

Хоёрдугаар дэд бүлэг Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах

106 дугаар зүйл.Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ

106.1.Хуульд өөрөөр заагаагүй бол барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээний хадгалагч нь эд хөрөнгийг хүлээн авахад түүний чанар, төрөл, жин, хэмжээ, тоо болон бусад шинжийг шалгах үүрэг хүлээхгүй.

106.2.Хадгалагчид шилжүүлж байгаа эд хөрөнгө шилжүүлэлтийн үеийн гадаад үзлэгээр гэмтсэн, эсхүл иж бүрдэл дутуу болох нь илэрхий байвал хадгалагч хадгалуулагчид энэ тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүйгээс хадгалуулагчид учирсан хохирлыг нөхөн төлнө.

106.3.Хадгалагч нь хадгалагдаж байгаа эд хөрөнгө устсан, гэмтсэн эсхүл хадгалагчид хохирол учруулахуйц өөрчлөлт бий болсон, эсхүл өөрчлөгдөх аюул учирч байгаа талаар хадгалуулагчид, эсхүл агуулахын баримт үйлдэгдсэн бол өөрийн мэдэж байгаа агуулахын баримтын сүүлчийн хууль ёсны эзэмшигчид нэн даруй мэдэгдэж түүний зааварчилгааг авах үүрэгтэй. Хадгалагч нь ердийн боломжит хугацаанд зааварчилгааг хүлээн авч чадаагүй бол эрх бүхий этгээдийн ашиг сонирхолд илүү нийцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Хадгалагдаж байгаа эд хөрөнгө нь өөрийн үнэ цэнийг алдахуйцаар гэмтэж өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн бол хадгалагч нь эрх бүхий этгээдийн зааварчилгааг хүлээлгүйгээр худалдан борлуулах шийдвэрийг гаргаж болно.

106.4.Хадгалагч нэг төрлийн орлуулагдах эд хөрөнгийг гагцхүү өмчлөгчийн зөвшөөрөлтэйгээр түүнтэй ижил төрөл, чанар бүхий эд хөрөнгөтэй нийлүүлж хадгалж болно. Ийнхүү нийлүүлснээс бий болсон эд хөрөнгө нь хадгалуулагчдын дундын өмч болох бөгөөд хадгалуулагчид оногдох хэсгийг хадгалуулсан эд хөрөнгийн хэмжээгээр тодорхойлно. Хадгалуулагчид оногдох хэсгийг хадгалагч бусад хадгалуулагчийн зөвшөөрөлгүйгээр буцаан өгөх эрхтэй.

106.5.Хадгалагч нь хадгалуулагч болон агуулахын баримт эзэмшигчид барааны агуулах ажиллах ажлын цагаар барааг шалгах, дээж авах, шаардлагатай арга хэмжээ авах боломжоор хангана. Хадгалагч мөн барааг хадгалахад шаардлагатай арга хэмжээ авах эрхтэй бөгөөд эд хөрөнгийг нийлүүлж хадгалж буй нөхцөлд мөн адил байна.

107 дугаар зүйл. Агуулахын баримт

107.1.Хадгалагч хадгалуулахаар шилжүүлж өгсөн эд хөрөнгийг хүлээн авахдаа хадгалуулагчид агуулахын баримт олгоно.

107.2.Агуулахын баримтад дараах зүйлийг заавал тусгана:

107.2.1. агуулахын баримт олгосон огноо, бүртгэлийн дугаар;

107.2.2. гэрээний талуудын нэр, хаяг;

107.2.3. эд хөрөнгийг хадгалах газар;

107.2.4. хадгалах эд хөрөнгийн тоо, хэмжээ, жин, өнгө, чанар, боодлын тодорхойлолт;

107.2.5. хадгалалтын хөлс, бусад зайлшгүй зардлын хэмжээ;

107.2.6. хадгалах эд хөрөнгийг даатгуулах бол даатгалын үнэ;

107.2.7. гэрээний хугацаа;

107.2.8. хадгалагчийн гарын үсэг, тамга, тэмдэг.

107.2.9. аюултай бараа байгаа тохиолдолд аюулын талаарх холбогдох мэдээлэл;

107.2.10. энэ хуулийн 106.4-т заасны дагуу хадгалж байгаа тохиолдолд энэ талаарх тэмдэглэгээ.

107.3. Талууд энэ хуулийн 107.2-т зааснаас бусад нөхцөлийг агуулахын баримтад нэмж тусгаж болно.

107.4. Энэ хуулийн 107.2-т заасан нөхцөлийг агуулахын баримтад бүрэн тусгаагүй нь талуудыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

107.5. Агуулахын баримт эзэмшигч нь өөр үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор эд хөрөнгийг агуулахаас гаргахгүй гэсэн баталгаа гаргаж, агуулахад байгаа эд хөрөнгөө барьцаалж болно.

107.6. Хадгалагч зөвшөөрсөн бол хадгалуулагч агуулахын баримтыг бичилт хийж гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

107.7. Агуулахын баримтыг бичилтийн дагуу шилжүүлсэн бол хадгалагч нь түүнд дурдсан мэдээллийн үнэн зөвийг баримт эзэмшигчийн өмнө хариуцах бөгөөд харин уг

мэдээллийг хадгалуулагч, эсхүл гуравдагч этгээдийн өгсөн мэдээллийг үндэслэсэн гэж уг баримтад тэмдэглэсэн бол хадгалагч хариуцлага хүлээхгүй.

107.8.Хадгалагч мэдээлэл буруу ташаа гэдгийг мэдэж байсан бол баримтад тэмдэглэл хийсэн ч энэ хуулийн 107.7-д заасан хариуцлагыг хүлээнэ.

107.9.Эд хөрөнгийг нийлүүлж хадгалсан тохиолдолд хадгалагч энэ хуулийн 107.7-д заасан тэмдэглэлийг хийх эрхгүй.

107.10.Агуулахын зөвшөөрлийн баримт олгосон хадгалагч хадгалж байгаа эд хөрөнгийг гагцхүү агуулахын баримтын хууль ёсны эзэмшигчид олгоно.

107.11.Агуулахын барьцааны баримт олгосон бол хадгалагч түүнийг буцаан авахаар шаардах эрхтэй.

107.12.Хадгалагч бичилт хийн шилжүүлсэн баримтын үнэн эсэхийг шалгах үүрэггүй бөгөөд шилжүүлэлт нь агуулахын баримт дахь зохих тэмдэглэлээр баталгаажна.

107.13.Агуулахын баримт, эсхүл барьцааны баримтыг гээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд хууль ёсны эзэмшигч нь үрэгдүүлсэн баримт бичгийг хүчингүйд тооцуулахаар шүүхэд өргөдөл гаргаж болох бөгөөд хадгалагч шүүхийн шийдвэрийг үндэслэн агуулахын болон барьцааны баримтуудыг шинээр олгоно.

107.14.Агуулахад хадгалуулахаар шилжүүлсэн эд хөрөнгийг барьцаалахад өмчлөгч нь барьцааны баримтад тусгай тэмдэглэл хийж түүнийг шилжүүлнэ.

107.15.Бичилт хийн шилжүүлсэн баримтад хадгалуулагч, зээлдүүлэгч болон тэдгээрийн үүргийн талаарх мэдээллийг тусгана.

107.16.Эд хөрөнгө хадгалуулсан баримтыг шилжүүлсэн тухай хадгалагчид мэдэгдэх бөгөөд хадгалагч зохих бичилтийг хийнэ.

107.17.Эд хөрөнгийн хадгалалттай холбогдон үүссэн зардлыг төлүүлэхээр хадгалагч тухайн эд хөрөнгийг барьцаалах эрхтэй.

107.18.Агуулахын баримтыг бичилт хийн шилжүүлсэн бол шинэ эзэмшигчид барьцаалах эрх үүснэ.

108 дугаар зүйл.Хадгалалтын хугацаа дуусгавар болох

108.1.Хадгалалтын гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө, хугацаа тогтоогоогүй бол эд хөрөнгө хадгалуулахаар шилжүүлсэн өдрөөс эхлэн гурван сарын дотор хадгалагч эд хөрөнгөө буцаан авахыг хадгалуулагчаас шаардах эрхгүй.

108.2.Хадгалалтын хугацаа дуусгавар болсны дараа агуулахын баримт эзэмшигч нь эд хөрөнгийг агуулахаас гаргах арга хэмжээ авахгүй бол хадгалагч түүнд арван дөрөв хоногийн нэмэлт хугацаа олгох бөгөөд энэ хугацаанд эд хөрөнгийг буцаан авахгүй бол хадгалагч түүнийг худалдах эрхтэй.

108.3.Эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хадгалалтын явцад гарсан зайлшгүй зардал, хөлсийг хасаж, үлдсэн хэсгийг агуулахын баримт эзэмшигчид шилжүүлнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ДААТГАЛ

109 дүгээр зүйл. Даатгалын гэрээ

109.1. Даатгалын гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол, хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ.

109.2. Даатгалын зүйл нь эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол байна.

109.3. Хуульд өөрөөр заагаагүй бол даатгалын гэрээг бичгээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

109.4. Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

- 109.4.1. даатгалын зүйл;
- 109.4.2. даатгалын эрсдэлийн төрөл;
- 109.4.3. даатгалын үнэлгээний хэмжээ;
- 109.4.4. даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
- 109.4.5. даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
- 109.4.6. даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
- 109.4.7. гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

110 дугаар зүйл. Даатгалын төрөл, хэлбэр

110.1. Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна.

110.2. Албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.

110.3. Энэ хуулийн 110.2-т зааснаас бусад даатгал сайн дурын даатгалд хамаарна.

111 дүгээр зүйл. Даатгалын баталгаа

111.1. Даатгагч нь гарын үсэг зурсан даатгалын баталгааг даатгуулагчид гардуулах үүрэгтэй.

111.2. Даатгалын баталгааг тодорхой этгээдэд нэр заасан, эсхүл мэдүүлгийн баталгааны хэлбэрээр олгосон бол даатгагч нь анхны даатгуулагчид тавих бүх шаардлагыг баталгаа эзэмшигчид гаргаж болно. Даатгалын баталгаа эзэмшигч нь даатгалтай холбогдсон эрхээ шилжүүлж байгаагаа даатгагчид мэдэгдсэн бөгөөд эрх шилжүүлэгч шаардлагаа нэн даруй гаргасан бол энэ журам хамаарахгүй.

111.3. Даатгуулагч гагцхүү даатгалын баталгаа үзүүлсэн тохиолдолд даатгагч үүргээ гүйцэтгэхээр гэрээнд заасан бөгөөд баталгааг алдаж үрэгдүүлсэн бол тусгай

журмын дагуу уг баталгаа хүчингүй болсон тухай зарлан мэдэгдсэн тохиолдолд л даатгуулагч гэрээний биелэлтийг шаардах эрхтэй.

111.4. Даатгалын баталгааг алдаж үрэгдүүлсэн боловч энэ хуулийн 111.3-т заасны дагуу зарлуулсан бол даатгуулагч нь баталгааны хуулбар олгохыг даатгагчаас шаардаж болох бөгөөд хуулбар олгохтой холбогдсон зардлыг даатгуулагч хариуцна.

112 дугаар зүйл. Даатгалын гэрээ дуусгавар болох үндэслэл

112.1. Даатгалын гэрээний хугацааг даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож тогтооно.

112.2. Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно:

- 112.2.1. хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;
- 112.2.2. даатгагч, даатгуулагчийн аль нэг дампуурсан, татан буугдсан;
- 112.2.3. шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
- 112.2.4. даатгуулсан эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураасан;
- 112.2.5. талууд тохиролцож гэрээг цуцалсан;
- 112.2.6. даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.

113 дугаар зүйл. Даатгалын гэрээг цуцлах

113.1. Даатгалын гэрээг 5 жилээс илүү хугацаагаар байгуулсан бол нэг тал нь гэрээ цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 3 сарын дараа цуцалж болно.

113.2. Даатгалын гэрээг нэг жилээс дээш хугацаагаар сунгах нөхцөлтэйгээр байгуулсан тохиолдолд талууд гэрээний хугацааг дуугүй хүлээн зөвшөөрөх замаар сунгах, даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлахгүй байх тохиролцоо хүчин төгөлдөр бус байна. Даатгуулагч гэрээг цуцлахдаа энэ хуулийн 113.1-д заасан хугацааг баримтлах үүрэгтэй.

113.3. Даатгагч даатгалын хураамжийг нэмэгдүүлсэн тохиолдолд даатгуулагч нь 1 сарын дотор гэрээг цуцалж болно.

114 дүгээр зүйл. Гэрээ цуцалж болох ноцтой нөхцөл байдал

114.1. Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах, эсхүл даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон ийм нөхцөл байдлын талаар даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

114.2. Даатгагч нь гэрээнээс татгалзах, эсхүл гэрээний агуулгыг өөрчлөх шийдвэр гаргахад нөлөөлж болох, түүнчлэн даатгагч нь даатгуулагчаас тодорхой, хоёрдмол утга санаагүйгээр шууд, бичгээр, эсхүл цахим хэлбэрээр асуусан нөхцөл байдлыг ноцтойд тооцно.

114.3. Даатгуулагч энэ хуулийн 114.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол даатгагч нь гэрээнээс татгалзах, эсхүл энэ тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гэрээг цуцлах, эсхүл даатгалын хураамжийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийг шаардах эрхтэй. Харин даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг хэдийд ч цуцалж болно.

114.4.Даатгуулагч энэ хуулийн 114.2-т заасан ноцтой нөхцөл байдлын тухай мэдээлэх гэж байхад даатгагч санаатайгаар зайлсхийсэн, эсхүл даатгагч тухайн нөхцөл байдлын талаар мэдэж байсан бол энэ хуулийн 114.3-т заасан журам үйлчлэхгүй.

114.5.Ноцтой нөхцөл байдлын тухай мэдээнд буруу ташаа баримт дурдсан бол даатгагч гэрээнээс татгалзаж болох бөгөөд даатгагч энэ мэдээ баримтын буруу ташааг мэдэж байсан, эсхүл ийм мэдээ ирүүлсэнд даатгуулагч буруугүй бол гэрээнээс татгалзах эрхгүй.

114.6.Даатгуулагч аюул учрах нөхцөл байдлын тухай бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдээлэх үүргээ санаатайгаар биелүүлээгүй бол даатгагч гэрээг цуцлах эрхтэй.

114.7.Даатгалын тохиолдол бий болсноос хойш даатгагч гэрээ цуцлахаар мэдэгдсэн бөгөөд даатгуулагч ноцтой нөхцөл байдлын талаар заавал мэдээлэх үүргээ биелүүлээгүй нь даатгалын тохиолдол бий болох болон даатгагчаас үүргээ биелүүлэхэд нөлөөлөөгүй бол даатгагч үүргээс чөлөөлөгдөхгүй.

115 дугаар зүйл.Даатгалын хураамж төлөх үүрэг

115.1.Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй бол даатгагч хураамж төлөх 15 хоногийн нэмэлт хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацааг дахин хэтрүүлбэл үүсэх үр дагаврыг даатгагч бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

115.2.Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй.

115.3.Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй.

115.4.Даатгагчийн төлбөрийн чадвар үлэмж доройтож, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахааргүй нөхцөл бий болсон бол даатгуулагч даатгалын хураамж төлөхөөс татгалзах эрхтэй.

116 дугаар зүйл.Даатгалын үнэлгээний хэмжээ

116.1.Даатгалын үнэлгээний хэмжээг талууд харилцан тохиролцож тодорхойлно.

116.2.Эд хөрөнгийг даатгах тохиолдолд даатгагч эд хөрөнгийг үзэж үнэлгээний хэмжээг тогтоох эрхтэй.

116.3.Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний хэмжээ тухайн үеийн зах зээлийн үнээс илүүгүй байна.

116.4.Гэрээнд заасан даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс илүү байвал эд хөрөнгийн өртгөөс илүү гарсан хэсэгт нь гэрээ хүчин төгөлдөр бус байна.

116.5.Гэрээнд заасан даатгалын үнэлгээний хэмжээ эд хөрөнгийн өртгөөс бага байвал даатгалын тохиолдол бий болоход даатгагч даатгуулагчид учирсан хохирлыг даатгуулсан эд хөрөнгийн өртөгт даатгалын үнэлгээний хэмжээг хувь тэнцүүлэн бодож нөхөн төлбөр олгоно.

116.6.Даатгалын гэрээгээр энэ хуулийн 116.5-д зааснаас илүү хэмжээгээр нөхөн төлбөр төлөхөөр зааж болох боловч энэ нь даатгалын үнэлгээний хэмжээнээс хэтэрч болохгүй.

116.7.Даатгалын гэрээнд заасан бол даатгалын тохиолдол бий болсны улмаас олж чадаагүй ашиг, орлогыг даатгалын үнэлгээний хэмжээнд хамааруулж болно.

116.8.Даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс үлэмж их болох нь тогтоогдвол даатгагч даатгалын үнэлгээний хэмжээг бууруулах, даатгуулагч хураамжийг багасгахыг тус тус шаардах эрхтэй.

116.9.Даатгуулагч даатгалын үнэлгээний хэмжээг зориуд өсгөсөн бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох бөгөөд энэ байдлыг даатгагч гэрээ байгуулах үедээ мэдээгүй байсан бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцохоос өмнө даатгуулагчийн төлсөн хураамж даатгагчид үлдэнэ.

117 дугаар зүйл.Даатгалын тохиолдол бий болох үед даатгагч, даатгуулагчийн хүлээх үүрэг

117.1.Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

117.2.Даатгалын тохиолдол бий болсон үед даатгагч даатгалын тохиолдол, эсхүл нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай аливаа мэдээг даатгуулагчаас шаардах эрхтэй.

117.3.Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсныг мэдээлэх үүргээ биелүүлээгүй боловч энэ нь даатгагчийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулаагүй бол даатгагч үүргээс чөлөөлөгдөхгүй.

117.4.Даатгалын тохиолдол бий болж, даатгагчийн төлбөл зохих нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа даатгагч үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.

117.5.Даатгуулагч нь даатгалын тохиолдол бий болох үед аюулыг зайлуулах, эсхүл хохирлыг багасгах арга хэмжээг даатгагчийн өгсөн зааврын дагуу авах бөгөөд үүнтэй холбогдон гарсан зардлыг даатгагч хариуцна.

118 дугаар зүйл.Даатгалын төлөөлөгчийн эрх

118.1.Даатгалын төлөөлөгч даатгалын гэрээ байгуулах эрхтэй.

118.2.Даатгалын төлөөлөгчид даатгалын гэрээ байгуулах эрх олгосон бол гэрээний нөхцөлийг өөрчлөх, хугацааг сунгах, эсхүл гэрээг цуцалж болно.

119 дүгээр зүйл.Бусад этгээдэд ашигтайгаар даатгах даатгал

119.1.Даатгуулагч өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд ашигтайгаар даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд энэхүү гэрээний үндсэн дээр үүсэх бүхий л эрхийг ашиг сонирхол нь даатгагдсан этгээд /цаашид "ашиг сонирхол бүхий этгээд"-гэх/ эдлэх боловч даатгалын баталгаа олгохыг гагцхүү даатгуулагч шаардах эрхтэй.

119.2.Ашиг сонирхол бүхий этгээд зөвхөн даатгалын баталгааг өөртөө авсан тохиолдолд даатгуулагчтай зөвшилцөхгүйгээр гэрээнд заасан эрхээ эдлэх, эсхүл ийнхүү эрхээ хэрэгжүүлэхээр шүүхэд хандах эрхтэй.

119.3.Даатгагч даатгуулагчид даатгалын баталгаа олгосон бол даатгуулагч ашиг сонирхол бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр гэрээ ёсоор эдлэх аливаа эрхийг эдлэх, гэрээнд зааснаар шагнал авах, эсхүл ашиг сонирхол бүхий этгээд даатгалын баталгаа авсан нөхцөлд түүнд эрхийг нь шилжүүлэх эрхтэй.

119.4.Ашиг сонирхол бүхий этгээд даатгалын гэрээг хүлээн зөвшөөрч байгааг даатгуулагч нотолсон тохиолдолд даатгагч ашиг сонирхол бүхий этгээдийн төлөө нөхөн төлбөр гүйцэтгэх үүрэгтэй.

120 дугаар зүйл.Нийгмийн даатгал

120.1.Нийгмийн даатгалын төрөл, хэлбэрийг хуулиар тогтооно.

120.2.Нийгмийн даатгалтай холбогдон үүсэх харилцааг хуулиар зохицуулна.

121 дүгээр зүйл.Гэм хорын даатгал

121.1.Гэм хорын даатгалаар даатгагч нь даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан гэм хорыг даатгалын үнэлгээний хэмжээгээр мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

121.2.Иж бүрдэл бүхий эд хөрөнгө даатгуулсан бол түүний бүрэлдэхүүнд багтах бүх эд хөрөнгөд даатгал нэгэн адил хамаарна.

121.3.Төлсөн даатгалын хураамж нь даатгалын тохиолдол бий болоход учирсан хохирлоос илүү эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид учирсан хохирлын хэмжээгээр нөхөн төлбөр төлнө.

121.4.Даатгуулагч нэг ашиг сонирхлыг хэд хэдэн даатгагчид нэгэн зэрэг даатгуулсан бол энэ тухай даатгагч бүрд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

121.5.Энэ хуулийн 121.4-т заасан тохиолдолд даатгалын үнэлгээний хэмжээ нь нийлбэр дүнгээрээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс давсан, эсхүл өөр шалтгаанаар хохирлыг нөхөн төлөх хэлбэрээр олгох мөнгө нь нийлбэр дүнгээрээ хохирлын хэмжээнээс давж байвал даатгагчид хамтран үүргээ биелүүлнэ. Энэ тохиолдолд даатгуулагч хохирлын хэмжээнээс давсан нөхөн төлбөр шаардах эрхгүй.

121.6.Тусгай гэрээнд заасан тохиолдолд дайны үед учирсан гэм хорыг даатгагч хариуцна.

121.7.Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд даатгагч уг гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ. Харин даатгуулагч гуравдагч этгээдэд

шаардлага гаргах, эсхүл шаардлагыг хангуулах эрхээсээ татгалзсан бол тэр хэмжээгээр даатгагч гэм хорыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

121.8.Хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах даатгуулагчийн эрх нь түүнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүнд хамааралтай бол уг гишүүн санаатай хохирол учруулснаас бусад тохиолдолд түүний зөвшөөрөлгүйгээр шаардах эрхийг шилжүүлж болохгүй.

121.9.Даатгуулсан эд хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлсэн бол даатгуулагчийн эрх шинэ өмчлөгчид шилжинэ. Эд хөрөнгө ийнхүү шилжсэнийг даатгуулагч болон шинэ өмчлөгч даатгагчид нэн даруй мэдэгдэнэ.

121.10.Даатгуулагч болон шинэ өмчлөгч энэ хуулийн 121.9-т заасан үүргээ биелүүлээгүй тухай даатгагч мэдвэл зохих байсан үеэс хойш 1 сар өнгөрсний дараа даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

121.11.Даатгагч гэрээг цуцлах 1 сарын хугацааг баримтлан эд хөрөнгийн шинэ өмчлөгчтэй даатгалын харилцаагаа дуусгавар болгох эрхтэй.

121.12.Энэ хуулийн 121.9-т зааснаар эд хөрөнгө өөр этгээдэд шилжсэнийг даатгагч мэдсэнээс хойш 1 сарын дотор шинэ өмчлөгчтэй даатгалын гэрээг дуусгавар болгох эрхээ хэрэгжүүлээгүй бол уг эрх хүчингүй болно.

121.13.Даатгалын эрх шилжүүлэн авсан этгээд нэн даруй, эсхүл даатгалын тухайн үе дуусахад даатгалын гэрээг цуцлах эрхтэй.

121.14.Шинэ өмчлөгч эд хөрөнгө шилжүүлэн авахдаа даатгалын гэрээний тухай мэдээгүй бөгөөд энэ тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гэрээ цуцлах эрхээ хэрэгжүүлээгүй бол уг эрх нь хүчингүй болно.

121.15.Гэрээг энэ хуулийн 121.11, 121.13-т заасан үндэслэлээр цуцалсан бол эд хөрөнгийн эрхээ шилжүүлсэн даатгуулагч даатгагчид даатгалын хураамж төлөх үүрэгтэй бөгөөд хураамж нь гэрээ цуцлах үеийг оролцуулан тооцсон гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байсан хугацаанд төлбөл зохих хэмжээнээс хэтрэхгүй. Энэ тохиолдолд эрх шилжүүлэн авсан этгээд даатгалын хураамж төлөх үүрэг хүлээхгүй.

121.16.Гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө амь нас даатгах гэрээ байгуулах тохиолдолд уг этгээд, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг бичгээр авна.

121.17.Амь насаа даатгуулсан этгээд амиа хорлосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

121.18.Гуравдагч этгээдэд ашигтайгаар амь нас даатгасан тохиолдолд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий гуравдагч этгээдийн хууль бус үйлдлийн улмаас даатгагдсан этгээд нас барсан бол уг этгээд даатгалын нөхөн төлбөр авах эрхээ алдана.

121.19.Даатгалтай холбоотой шаардлагыг хангах шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж байгаа, эсхүл даатгагч дампуурсантай холбоотой хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол даатгалын гэрээнд нэр заагдсан даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий

этгээд даатгуулагчийн оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй. Даатгуулагч дампуурсантай холбоотойгоор даатгалын гэрээ цуцлагдсан нөхцөлд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд нь даатгагчаас шаардвал зохих мөнгөний хэмжээгээр дампуурлын үед даатгуулагчийн бусдад хуваарилагдах хөрөнгийг бүрдүүлэхэд оролцох үүрэгтэй.

121.20.Хэрэв даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд энэ хуулийн 121.19-д заасан эрхийг эдлэх сонирхолгүй, эсхүл гэрээнд даатгалын нөхөн төлбөр авах этгээдийн нэрийг заагаагүй бол даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагч уг эрхийг эдэлж болно.

122 дугаар зүйл.Хариуцлагын даатгал

122.1.Хариуцлагын даатгалаар даатгагч нь даатгалын хугацаанд үүсэх хариуцлагатай холбоотойгоор гуравдагч этгээдийн өмнө , хүлээх үүргээс даатгуулагчийг чөлөөлөх үүрэгтэй.

122.2.Гуравдагч этгээд өөрт учирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр даатгагчид шууд шаардлага гаргасан бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргийн хэмжээнд уг гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ.

122.3.Гуравдагч этгээдийн шаардлагаас өөрийгөө хамгаалах зорилгоор гаргасан шүүхийн болон шүүхийн бус бусад зардлыг хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй нөхөн төлөх шаардлагатай бол энэхүү зардал даатгалд нэгэн адил хамаарна.

122.4.Гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхэд хүргэсэн нөхцөл байдлыг даатгуулагч санаатай бий болгосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

122.5.Даатгагч даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээсээ бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдсөн байсан ч албан журмаар даатгах даатгалын хувьд даатгагчийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага хүчин төгөлдөр байна.

122.6.Энэ хуулийн 122.5-д заасан үүргийнхээ дагуу даатгагч нь гуравдагч этгээдийн шаардлагыг хангасан бол гуравдагч этгээдээс даатгуулагчид гаргах шаардлага даатгагчид шилжинэ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ ЗЭЭЛ ТООЦООНЫ ҮҮРЭГ

Нэгдүгээр дэд бүлэг Төлбөр тооцоо

123 дугаар зүйл.Төлбөр тооцооны гэрээ

123.1.Төлбөр тооцооны гэрээгээр банк, эрх бүхий бусад хуулийн этгээд /цаашид "төлбөр тооцоо гүйцэтгэгч" гэх/ нь иргэн болон хуулийн этгээд /цаашид "харилцагч" гэх/-ийн бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

123.2.Хуульд өөрөөр заагаагүй бол бэлнээр хийх төлбөр тооцоог банк, эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан гүйцэтгэж болно.

123.3.Бэлэн бусаар хийх төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр гүйцэтгэж болно.

123.4.Төлбөр тооцоо гүйцэтгэгч нь харилцагчийн өгсөн үүрэг, эсхүл зөвшөөрлийн үндсэн дээр гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог гүйцэтгэнэ.

123.5.Хуульд өөрөөр заагаагүй бол дансан дахь мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах харилцагчийн эрхийг төлбөр тооцоо гүйцэтгэгч хязгаарлах, хянах эрхгүй.

123.6.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь харилцагчийн төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалгах эрхтэй.

123.7.Төлбөр тооцооны гэрээгээр талууд төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний хөлс төлөхөөр тохиролцож болно.

123.8.Банк, төлбөр тооцоо хийх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хийх төлбөр тооцооны харилцааг хуулиар зохицуулна.

124 дүгээр зүйл.Төлбөр тооцоо гүйцэтгэгчийн үүрэг

124.1.Төлбөр тооцоо гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

124.1.1.бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;

124.1.2.гэрээнд заасан хугацаанд харилцагчид түүний дансны талаар мэдээлэл, дансны хуулга өгөх;

124.1.3.харилцагчийн данснаас түүний өгсөн үүрэг, эсхүл зөвшөөрлийн үндсэн дээр гүйлгээ хийх;

124.1.4.хуульд зааснаас бусад тохиолдолд данс, гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх;

124.1.5.алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн гүйлгээг залруулж, харилцагчийг хохиролгүй болгох;

124.1.6.харилцагчийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх;

124.1.7.хуульд заасан бусад үүрэг.

125 дугаар зүйл.Харилцагчийн эрх

125.1.Харилцагч дараах эрхтэй:

125.1.1.өөрийн данс, гүйлгээний талаарх мэдээллийг хэдийд ч авах;

125.1.2.мөнгөн төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхээс өмнө төлбөрийн даалгавраа цуцлах;

125.1.3.хуульд заасан бусад эрх.

125.2.Энэ хуулийн 125.1.2-т заасан тохиолдолд харилцагч нь төлбөр тооцоо гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх бөгөөд төлбөр тооцоо гүйцэтгэгч нь төлбөрийн даалгаварт заасан мөнгийг харилцагчийн дансанд буцаан оруулна.

126 дугаар зүйл.Төлбөр тооцооны гэрээг цуцлах

126.1.Хууль, эсхүл гэрээнд өөрөөр заагаагүй бол талууд төлбөр тооцооны гэрээг хэдийд ч харилцан тохиролцож цуцалж болно.

127 дугаар зүйл.Аккредитив

127.1.Аккредитив нээсэн банк нь үйлчлүүлэгчийн гаргасан хүсэлт, өгсөн үүрэг, зааврын дагуу гуравдагч этгээд /төлбөр авагч/-ээс тодорхой бичиг баримт хүлээн авч, хариуд нь түүнд, эсхүл түүний заасан этгээдэд мөнгө шилжүүлэх, төлбөр авагчийн бичсэн шилжих вексельд заасан төлбөрийг төлөх, зөвшөөрөх, эсхүл уг гүйлгээг гүйцэтгэхийг өөр банкинд даалгах үүрэг хүлээнэ.

127.2.Үйлчлүүлэгч нь харилцан тохиролцсон хөлсийг банкинд төлнө.

127.3.Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.

128 дугаар зүйл.Инкасс

128.1.Инкассийн төлбөр тооцоогоор төлбөр тооцоо гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн өгсөн даалгаврын дагуу, түүний зардлаар, төлбөр хариуцагчаас төлбөрийг хүлээн авах, эсхүл төлбөр хийх үүрэг хүлээнэ.

128.2.Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална.

Хоёрдугаар дэд бүлэг Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох

129 дүгээр зүйл.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээ

129.1.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.

129.2.Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ.

129.3.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

130 дугаар зүйл.Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүү

130.1.Зээлдүүлэгчээс олгох зээл нь хүүтэй, эсхүл хүүгүй байж болно.

130.2.Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.

130.3.Зээлдүүлэгч зээлийн хүүгийнхээ хэмжээг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

131 дүгээр зүйл.Зээлдэгчийн хариуцлага

131.1.Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй.

131.2.Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар зээлдүүлэгчид шилжүүлэхээр гэрээнд заасан бол тухайн барьцааны зүйлийг гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн зээлдүүлэгч захиран зарцуулах эрхтэй. Энэ заалт зөвхөн хөдлөх эд хөрөнгөнд хамаарна.

132 дугаар зүйл.Үүрэг гүйцэтгэх дараалал

132.1.Зээлийн гэрээнд заасан хугацаа дууссанаас хойш зээлдэгчийн төлсөн мөнгөн хөрөнгө нь зээл, зээлийн хүүг төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд уг мөнгөн хөрөнгөнөөс зээл болон зээлийн хүүг тэнцүү хэмжээгээр төлүүлэх бөгөөд мөнгөн хөрөнгө үлдсэн тохиолдолд хэтэрсэн хугацааны хүү, эцэст нь гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлүүлэх дарааллаар үүргийг гүйцэтгүүлнэ.

132.2.Зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө зээлдэгчийн хэсэгчлэн төлсөн төлбөр нь зээлийн хуваарьт төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд уг төлбөрөөс зээлийн гэрээний аль үүргийг тэргүүн ээлжинд гүйцэтгүүлэхийг талууд гэрээгээр харилцан тохиролцоно.

Гуравдугаар дэд бүлэг Мөнгөн хадгаламж

133 дугаар зүйл.Мөнгөн хадгаламжийн гэрээ

133.1.Мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, хадгалуулсан мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ.

133.2.Мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс талуудын хүлээх хариуцлагыг тусгана.

133.3.Хуульд өөрөөр заагаагүй бол мөнгөн хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн сертификат болон хуульд заасан бусад арга хэрэгслийг ашиглан бичгээр байгуулна.

133.4.Хадгалуулагч хэдийд ч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах эрхтэй.

133.5.Хуульд өөрөөр заагаагүй бол банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд хадгалуулагчийн мөнгөн хадгаламжийн нууцыг хадгалах, холбогдох гүйлгээний талаарх мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

133.6.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөнгөн хадгаламжийг даатгуулж болно.

133.7.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

133.8.Мөнгөн хадгаламжийн гэрээгээр хадгалуулсан мөнгөө шаардахад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.

134 дүгээр зүйл.Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа

134.1.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой, эсхүл тодорхой бус хугацаагаар байгуулна.

134.2.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол хадгалагч нь хадгалуулагчийн хүссэн цагт түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүүг төлөх үүрэгтэй.

134.3.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол банк уг хугацаа дууссаны дараа хадгалуулагчийн анхны шаардлагаар хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх бөгөөд гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгалуулагч мөнгөө буцаан авах шаардлага тавиагүй бол уг гэрээг цаашид тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно.

134.4.Тодорхой хугацаагаар байгуулсан гэрээг банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас нь өмнө цуцлах эрхгүй.

135 дугаар зүйл.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдийн мэдээлэл

135.1.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд санхүүгийн тайлан, мэдээллийг хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлэх үүрэгтэй.

135.2.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд өөрийн төлбөр гүйцэтгэх чадвар, найдвартай байдлын талаарх мэдээллийг хадгалуулагчид гаргаж өгөх үүрэгтэй.

135.3.Энэ хуулийн 135.2-т заасан мэдээллийг буруу, ташаа мэдээлсэн банк нөхөх хариуцлага хүлээнэ.

Дөрөвдүгээр дэд бүлэг Банкны баталгаа

136 дугаар зүйл.Банкны баталгааны гэрээ

136.1.Банкны баталгааны гэрээгээр банк нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

136.2.Баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүргээ үндсэн гэрээгээр үүрэг гүйцэтгэгчийн хүлээсэн үүргээс үл хамааран гүйцэтгэнэ.

136.3.Гэрээнд өөрөөр заагаагүй бол баталгаа гаргагч банк нь нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрхгүй.

136.4.Үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд өөрөөр заагаагүй бол банкны баталгааны талаарх шаардах эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

136.5.Үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн баталгаа бүхий үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь баталгаа гаргагч банкнаас мөнгөн төлбөр төлөхийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр шаардана.

136.6.Энэ хуулийн 136.5-д заасан шаардлагыг банкны баталгааны гэрээнд заасан хугацаанд гаргана.

136.7.Баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хүлээн авсан даруй үүрэг гүйцэтгэгчид энэ тухай мэдэгдэж, үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага болон түүнд хавсаргасан баримт бичгийн хуулбарыг шилжүүлнэ.

136.8.Баталгаа гаргагч банк ердийн боломжит хугацааны дотор үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргасан шаардлага, түүнд хавсаргасан баримт бичиг нь гэрээний нөхцөлд нийцэж байгаа эсэхийг тогтооно.

136.9.Үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргасан шаардлага, түүнд хавсаргасан баримт бичиг нь гэрээний нөхцөлд нийцээгүй, эсхүл гэрээнд заасан хугацаанд гаргаагүй бол баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаас татгалзах эрхтэй бөгөөд энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид нэн даруй мэдэгдэнэ.

136.10.Банк үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахаас өмнө үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн, тухайн үүрэг бусад үндэслэлээр дуусгавар болсон, эсхүл хүчин төгөлдөр бус болсон бол баталгаа гаргагч банк энэ тухай үүрэг гүйцэтгүүлэгчид нэн даруй мэдэгдэнэ. Үүрэг гүйцэтгүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш баталгаа гаргагч банкнаас мөнгөн төлбөр төлөхийг дахин шаардвал банк шаардлагыг хангаж, гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлнэ.

136.11.Баталгаа гаргагч банкны хүлээх хариуцлага гэрээнд заасан хэмжээгээр хязгаарлагдана.

136.12.Банкны баталгааны гэрээнд өөрөөр заагаагүй бол баталгаа гаргагч банкны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас хүлээх хариуцлага энэ хуулийн 136.11-д заасан хэмжээнээс үл хамаарна.

136.13.Баталгаа гаргагч банкны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:

136.13.1. баталгаа гаргагч банк үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;

136.13.2. гэрээнд заасан хугацаа дуусгавар болсон;

136.13.3. үүрэг гүйцэтгүүлэгч гэрээнд заасан шаардах эрхээсээ татгалзсан.

136.14. Баталгаа гаргагч банкны үүрэг энэ хуулийн 136.13-т заасны дагуу дуусгавар болсон бол банк энэ тухай нэн даруй үүрэг гүйцэтгүүлэгчид мэдэгдэнэ.

136.15. Банк, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж төлсөн мөнгийг үүрэг гүйцэтгэгчид сөрөг нэхэмжлэл гаргах замаар буцаан авах журмыг баталгаа гаргагч болон үүрэг гүйцэтгэгч гэрээгээр харилцан тохиролцоно.

136.16. Баталгаа гаргагч банк гэрээний нөхцөлийг зөрчиж үүрэг гүйцэтгүүлэгчид төлбөр төлсөн, эсхүл энэ хуулийн 136.12-т заасны дагуу хариуцлага хүлээсэн бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол үүрэг гүйцэтгэгчээс дээрх мөнгийг шаардах эрхгүй.

136.17. Энэ хуулиар зохицуулаагүй банкны баталгаатай холбогдсон бусад харилцааг олон улсын хэмжээнд хэрэглэдэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлаар зохицуулна.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТООЦОО НИЙЛЭХ

137 дугаар зүйл. Тооцоо нийлэх гэрээ

137.1. Тооцоо нийлэх гэрээгээр талууд өөрсдийн ажил хэргийн харилцаанаас харилцан бие биедээ үүссэн шаардах эрх болон үүрэг, түүний хүүг гэрээнд заасан хугацааны дотор харилцан тооцож дуусгавар болгон гэрээний талуудад үүссэн үлдэгдлийг тодорхойлох замаар тооцоог хаахаар тохиролцох бөгөөд тооцоо нийлэх хүртэл шаардлага гаргахгүй байх үүрэг хүлээнэ. Гэрээний дор хаяж нэг тал нь аж ахуй эрхлэгч байна.

137.2. Гэрээний талуудад үүссэн үлдэгдлийг тооцоо нийлэх гэрээнд заасан хугацаанд төлөх бөгөөд тооцоог хааснаар тооцооны үлдэгдлийг төлөхийг шаардах эрх үүснэ.

137.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол тооцоогд жилд нэг удаа хаана.

137.4. Тооцоо нийлэх гэрээний талуудад үүссэн үлдэгдэлд хүү тооцож болно.

137.5. Үүргийн гүйцэтгэлийг хангах аль нэг аргыг хэрэглэхээр талууд тохиролцсон шаардах эрхийг тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан бол тооцоог хааснаар гэрээний талуудад үүсэх үлдэгдэл болон тухайн шаардах эрхийн давхцал үүссэн хэсгийн хувьд үүрэг гүйцэтгүүлэгч нь үүргийн гүйцэтгэлийг хангах тухайн тохиролцсон аргыг хэрэглэхээр шаардах эрхтэй.

137.6. Тооцоо нийлэх гэрээнд хамааруулсан шаардах эрхийн талаар гуравдагч этгээд хамтран үүрэг гүйцэтгэгчийн хувиар хариуцлага хүлээх тохиолдолд тухайн гуравдагч этгээдийн эсрэг шаардах эрхийг хэрэгжүүлэхэд энэ хуулийн 137.5-д заасан зохицуулалтыг нэгэн адил хэрэглэнэ.

**ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

138 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

138.1.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 88 дугаар зүйлд дараах агуулгатай 88.3 дахь хэсэг нэмсүгэй:

“88.3.Эд юмс эсхүл эрхээс эрх зүйн харилцааны үр дүнд бий болгосон зүйл, орлого нь үр шимд нэгэн адил хамаарна.”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “этгээдийг” гэсний дараа “хоршоо,” гэж, 183 дугаар зүйлийн 183.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэсний дараа “гуравдагч этгээдийн хувьд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг:

“3.3.Энэ хуулиар зохицуулсан харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулсан бол тухайлсан хуулийг хэрэглэх бөгөөд тухайн харилцааг хэд хэдэн тухайлсан хуулиар зохицуулсан бол илүү нарийвчлан зохицуулсан хуулийг хэрэглэнэ.”

2/255 дугаар зүйлийн 255.1.1 дэх заалт:

“255.1.1.гэрээ байгуулах үед худалдан авагч доголдлын талаар мэдэж байсан, эсхүл илт болгоомжгүйн улмаас доголдлын талаар мэдээгүй бол;”

3/255 дугаар зүйлийн 255.2 дахь хэсэг:

“255.2.Худалдагч доголдлыг мэдсээр байж нуун дарагдуулсан, эсхүл эд хөрөнгийн аливаа доголдлыг бүрэн хариуцахаар тохиролцсон тохиолдолд энэ хуулийн 255.1 хамаарахгүй.”

4/257 дугаар зүйлийн 257.1 дэх хэсэг:

“257.1.Ямар нэгэн доголдолтой эд хөрөнгө худалдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх, эсхүл худалдагчийн хүлээх хариуцлагыг хязгаарлахаар тохиролцсон тохиролцоо хүчин төгөлдөр бус байна.”

5/274 дүгээр зүйл:

“274 дүгээр зүйл.Солилцооны гэрээ

274.1.Солилцооны гэрээгээр талууд тодорхой хөрөнгийг харилцан өмчлөлд шилжүүлэх үүрэг хүлээнэ.

274.2.Солилцооны гэрээгээр талууд нь солилцож байгаа хөрөнгийн хувьд худалдагч, солилцон авч байгаа хөрөнгийн хувьд худалдан авагч болно.

274.3.Солилцооны гэрээнд худалдах-худалдан авах гэрээний талаарх энэ хуулийн холбогдох заалтууд нэгэн адил хамаарна.

274.4.Төрийн өмчлөлийн мөнгө, үнэт цаасаар солилцоо хийх журмыг хуулиар тогтооно.”

6/275 дугаар зүйл:

“275 дугаар зүйл.Солилцох хөрөнгийн үнийн зөрүүг тооцох

275.1.Солилцооны гэрээгээр харилцан тохиролцож байгаа хөрөнгийн үнэ нь тэнцүү биш бол үнийн зөрүүг мөнгөөр тооцож болно.”

7/318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэг:

“318.1.Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад тодорхой хөрөнгө шилжүүлж, тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашигласны үр дүнд бий болсон үр шимийг олж авах эрхийг олгох, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.”

8/318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэг:

“318.3.Хуульд өөрөөр заагаагүй бол түрээсийн гэрээг бичгээр байгуулна.”

4 дүгээр зүйл.Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “сан, хоршооны” гэснийг “сангийн” гэж, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн” гэснийг “зүйл” гэж, 237 дугаар зүйлийн 237.1 дэх хэсгийн “шилжүүлэх үүрэгтэй.” гэснийг “шилжүүлж болно.” гэж, 251 дүгээр зүйлийн 251.3 дахь хэсгийн “түүнийг бүхэлд нь доголдолтой гэж үзэхгүй.” гэснийг “худалдан авагч гэрээнээс татгалзаж болохгүй.” гэж, 256 дугаар зүйлийн 256.1 дэх хэсгийн “худалдагч, худалдан авагчийн аль нь ч” гэснийг “худалдан авагч” гэж, 259 дүгээр зүйлийн 259.3 дахь хэсгийн “нь энэ зүйлд заасан журмын дагуу түүнийг худалдах үүрэгтэй.” гэснийг “нөгөө талдаа урьдчилж мэдэгдэхгүйгээр худалдаж болно.” гэж, 88 дугаар зүйлийн 88.3 дахь хэсгийн дугаарыг “88.4” гэж, 88 дугаар зүйлийн 88.4 дэх хэсгийн дугаарыг “88.5” гэж, 22 дугаар бүлгийн Зургадугаар дэд бүлгийн гарчигт “Арилжаа” гэснийг “Солилцоо” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Иргэний хуулийн 198 дугаар зүйлийн 198.6 дахь хэсгийн “, талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэг, 196 дугаар зүйлийн 196.1.7 дахь заалт, мөн зүйлийн 196.2, 196.3 дахь хэсэг, 200 дугаар зүйлийн 200.4 дэх хэсэг, 255 дугаар зүйлийн 255.1.2 дахь заалт, 286, 312, 313, 314, 315, 316, 317, 333, 334, 335, 336, 337, 338, 338¹, 370, 371, 372, 373, 374, 375, 376, 377, 378, 379, 380, 381, 382, 383, 384, 385, 386, 387, 388, 389, 390, 391, 392, 393, 394, 395, 396, 397, 398, 407, 408, 409, 413, 414, 415, 416, 417, 418, 419, 422.2, 427, 428, 429, 430, 431, 432, 433, 434, 435, 436, 437, 438, 439, 440, 441, 442, 443, 444, 445, 446, 447, 448, 449, 450, 451, 452, 453, 454, 455, 456, 457, 466 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.¹

7 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

¹барьцаалан зээлдэх журмаар зээл олгох (ИХ 286)

Санхүүгийн түрээс (ИХ 312-317)

Түрээсийн гэрээ (ИХ 318-332)

Франчайзийн гэрээ (ИХ 333-338)

Аялал жуулчлалын гэрээ (ИХ 370-379)

ИХ 413-419-р зүйл (Худалдааны зуучлагч, төлөөлөгч, комисс)

ИХ 427-430-р зүйл (Хадгалалтын гэрээ)-ийн зарим хэсэг, заалт, Барааны агуулахад эд хөрөнгө хадгалуулах гэрээ

Даатгал (ИХ 430-444)

Зээл тооцооны үүрэг (ИХ 445-457)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд дараах агуулгатай 12.2.5 дах заалт нэмсүгэй:

“12.2.5. ашгийн төлөө хуулийн этгээд, эсхүл арилжааны үйл ажиллагаа явуулж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээд бол энэ хуулийн 12.2.3-т зааснаас гадна арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрх бусдад олгосон бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эрх хэмжээнд тавьсан хязгаарлалт бий бол тэр талаарх мэдээлэл, хуулийн этгээдийн хүчинтэй байгаа дүрмийн батлагдсан огноо, үйл ажиллагаа хугацаатай эсэх талаарх мэдээлэл, салбар, төлөөлөгчийн газартай бол түүний эрх баригчийн мэдээлэл, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн хэмжээ, татан буулгах тухай мэдэгдэл бүртгүүлсэн эсэх талаарх мэдээлэл;”

2 дугаар зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд дараах агуулгатай 10.1.15, 10.1.16 дахь заалт тус тус нэмсүгэй:

“10.1.15.хуулийн этгээд арилжааны үйл ажиллагааг бүхэлд нь эрхлэн явуулах бүрэн эрхийг бусдад олгосон бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эрх хэмжээнд тавьсан хязгаарлалт байгаа бол тэр талаарх мэдээлэл;

10.1.16.татан буулгах тухай мэдэгдэл бүртгүүлсэн эсэх талаарх мэдээлэл.”

2 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Иргэний хуулийн” гэсний өмнө “Арилжааны хуулийн 8 дугаар зүйл болон” гэж, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “Хуулийн этгээдийн нэр” гэсний дараа “, хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны нэр” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг ““хуулийн этгээдийн нэр” гэж Арилжааны хуулийн 8 дугаар зүйл болон Иргэний хуулийн 27 дугаар зүйлд заасан, хуулийн этгээдийг бусад хуулийн этгээд, арилжаа эрхлэгчээс ялгах зорилгоор хэрэглэх нэрийг;” гэж өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нөхөрлөлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Нөхөрлөл оноосон нэртэй байна. Нөхөрлөлийн оноосон нэр нь бусад хуулийн этгээдийн нэр, хувиараа арилжаа эрхлэгчийн арилжааны нэртэй давхардаагүй байна.” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй” гэснийг “бусад хуулийн этгээдийн нэр, арилжаа эрхлэгчийн арилжааны нэртэй” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ТҮРЭЭС /ЛИЗИНГ/-ИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “Иргэний хуулийн” гэсний өмнө “Арилжааны хууль болон” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг:

“5.1. Санхүүгийн түрээсийн гэрээ нь Арилжааны хуульд заасан шаардлагыг хангасан байна:

5.2. Санхүүгийн түрээсийн зүйлийн ашиглалтын хугацааг тооцохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан элэгдэл, хорогдол тооцох журмыг баримтална.”

2/16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг:

“16.2. Түрээслүүлэгч, түрээслэгчийн аль нэг нь гэрээг цуцлах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэх бөгөөд ийнхүү цуцалснаас үүсэх үр дагаврыг шийдвэрлэхтэй холбогдсон харилцаанд Иргэний хуулийн 295.1, 295.4 болон бусад холбогдох зохицуулалтыг хэрэглэнэ.”

3 дугаар зүйл. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “Иргэний хуулийн 313.2-т зааснаас гадна” гэснийг “Арилжааны хуулийн 49.3-т зааснаас гадна” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “316” гэснийг “Арилжааны хуулийн 52” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт дараах агуулгатай 5.1.11 дэх заалт нэмсүгэй:

“5.1.11.байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн бол хувиараа арилжаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлсэн байх.”

2 дугаар зүйл. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Монгол Улсын иргэн” гэсний өмнө “иргэний эрх зүйн бүрэн чадамжтай” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “бүрдэнэ.” гэсний дараа “Хэрэв зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн арилжааны нэртэй бол үйл ажиллагаандаа арилжааны нэрээ хэрэглэж болно.” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.12 дахь заалтыг “7.2.12.Иргэний хуулийн Гучин есдүгээр бүлэг /Зуучлал/, Арилжааны хуулийн Долоодугаар бүлэг /Арилжааны төлөөлөгч/, Наймдугаар бүлэг /Арилжааны зуучлагч/, Арвандөрөвдүгээр бүлэг /Комисс/ болон тэдгээртэй адилтгах бусад үйлчилгээ үзүүлэх;” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэснийг “Арилжааны хууль” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Аялал жуулчлалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 370-379 дүгээр зүйлд” гэснийг “Арилжааны хуулийн 67-76 дугаар зүйлд” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Иргэний хуулиар” гэснийг “Иргэний хууль болон Арилжааны хуулиар” гэж, 6¹ дугаар зүйлийн 6^{1.2} дахь хэсгийн “Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасныг” гэснийг “Арилжааны хуулийн 136 дугаар зүйлд заасныг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Иргэний хуулийн” гэсний дараа “Арилжааны хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтын “Иргэний хуулийн 457 дугаар зүйлд заасныг” гэснийг “Арилжааны хуулийн 136 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Иргэний хуульд” гэснийг “Иргэний хууль болон Арилжааны хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ШИЛЖҮҮЛЭГ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 454.1-д” гэснийг “Арилжааны хуулийн 133.1-д” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 451.1-д” гэснийг “Арилжааны хуулийн 129.1-д” гэж, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн “Иргэний хуульд” гэснийг “Иргэний хууль болон Арилжааны хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэсний дараа “, Арилжааны хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэснийг “Арилжааны хууль” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усан замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэсний дараа “, Арилжааны хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Өрсөлдөөний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль” гэсний дараа “, Арилжааны хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ЭДИЙН БУС ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

1 дүгээр зүйл. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 354, 392, 422.3.8, 429.17-д заасны дагуу” гэснийг “Иргэний хуулийн 354, 422.3.8 болон Арилжааны хуулийн 97.1, 107.17-д заасны дагуу” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “ Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “ Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсгийн “зээлийн гэрээг Иргэний хуульд заасны дагуу байгуулах ба уг зээлийн гэрээнд Иргэний хуулийн 452.2-т заасны дагуу” гэснийг “зээлийн гэрээг Арилжааны хуульд заасны дагуу байгуулах ба уг зээлийн гэрээнд Арилжааны хуулийн 130.2-т заасны дагуу” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэсний дараа “Арилжааны хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “Иргэний хуулийн 338¹ дүгээр зүйлийн дагуу” гэснийг “Арилжааны хуулийн 60.1-д заасны дагуу” гэж, мөн зүйлийн 35.6 дахь хэсгийн “Иргэний хуулийн дагуу” гэснийг “Арилжааны хуулийн дагуу” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Арилжааны хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг